

СОНГУУЛИЙН БОЛОВСРОЛ

ОНОЛ, АРГА ЗҮЙН СЭТГҮҮЛ

ДУГААР 2025 №4 (13)

ᠰᠣᠩᠭᠤᠯᠢᠢᠨ
ᠪᠣᠯᠣᠪᠰᠣᠷᠣᠯ



www.m-election.mn



GECMongolia



Монгол Улсын Сонгуулийн
ерөнхий хороо

МОНГОЛ УЛСЫН ТУСГААР ТОГТНОСОН
АСУУДЛААР БҮХ АРД ТҮМНИЙ САНАЛ
ГАРГУУЛСНЫ 80 ЖИЛИЙН ОЙ



Мэндчилгээ

Сонгогчид, улс төрийн нам, эвсэл, төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагуудын төлөөлөл, их дээд сургуулийн хамт олон, иргэний нийгмийн байгууллагууд, сургагч багш, эрдэмтэн судлаач Та бүхэнд шинэ он, шинэ жилийн баярын мэнд хүргэн мэндчилье.

Чөлөөт, шударга, ил тод сонгуулийг зохион байгуулах, сонгуулийн боловсрол олгох, сонгуулийн эрх зүйг хөгжүүлэх, сонгуулийн үйл ажиллагаанд хөндлөнгийн хараат бус хяналт хэрэгжүүлэх зэрэг ардчилсан сонгуулийг бэхжүүлэх олон талт үйл ажиллагаанд үнэтэй хувь нэмэр оруулж буйг тань тэмдэглэн Та бүхэнд гүн талархал илэрхийлье.

Айлчлан ирж буй 2026 оныг угтан Та бүхэндээ эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэж, эрхэлж буй үйл хэрэгтээ арвин амжилт гаргахын өлзийтэй ерөөлийг өргөн дэвшүүлье.

ШИНЭ ОНЫ БАЯРЫН МЭНД ХҮРГЭЕ!

СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРОО

РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

ЭРХЛЭГЧ

Б.Цэцэгдэлгэр

Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах асуудал хариуцсан референт-хэвлэлийн төлөөлөгч

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Г.Ариунболд

Мэдээлэл, судалгаа хариуцсан ахлах мэргэжилтэн

ЗӨВЛӨХ

Ж.Амарсанаа

Академич, Хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор

ГИШҮҮД

Т.Дорж

Академич, Эдийн засгийн шинжлэх ухааны доктор, профессор

Ч.Содномцэрэн

Академич, Хөдөө аж ахуйн шинжлэх ухааны доктор, профессор

Д.Дашпүрэв

Философийн шинжлэх ухааны доктор, профессор

Д.Даваа-Очир

Хууль зүйн доктор, профессор

Д.Гангабаатар

Хууль зүйн доктор, профессор

З.Сүхбаатар

Бизнесийн удирдлагын доктор, профессор

О.Хатанболд

Улс төр судлалын доктор

А.Эрдэнэцогт

Хууль зүйн доктор, профессор

Д.Бат-Эрдэнэ

Хууль зүйн магистр

С.Оюунтуяа

"Сонгогчдын боловсрол төв" ТББ-ын Гүйцэтгэх захирал

Ч.Сайнсанаа

"Чимид сан"-ийн Тэргүүн

С.Уянга

"Сонгуулийн боловсрол" клубийн Удирдах зөвлөлийн ахлагч

АГУУЛГА

4

Б.ЧИМИД “СОНГУУЛЬД СУРАЛЦАХУЙ” НОМООС...

- Сонгогчдын нэрийн жагсаалт ба сонгогчийн үнэмлэх*

8

ТЭМДЭГЛЭЛТ ОЙ

- Монгол Улсын тусгаар тогтносон асуудлаар бүх ард түмний санал гаргуулсны 80 жилийн ой
- Б.Чимидийн “Сонгуульд суралцахуй” номын уншлага боллоо

12

“СОНГУУЛИЙН БОЛОВСРОЛ” ОНОЛ, АРГА ЗҮЙН СЭТГҮҮЛ ОЮУНЫ ӨМЧӨӨР БАТАЛГААЖЛАА

13

ДУГААРЫН ЗОЧИН

- Г.Туяагэрэл: Ил, тод, нээлттэй, хүн нэг бүр идэвх оролцоотой, мэргэшсэн байх зарчим намын түвшинд хангагдах ёстой

16

ХУУЛЬ ТОГТООМЖ

- Улсын дээд шүүхэд улс төрийн намуудаас ирүүлсэн өргөдөл, хавсаргасан баримт бичгийг “Шалгах хуудас”-т зааснаар хянана
- Улс төрийн намын санхүүжилтийн ил тод байдлыг хангах цахим системийн шаардлага, техникийн тодорхойлолтыг боловсрууллаа
- Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагаас Улс төрийн намын тухай хуульд өгсөн санал зөвлөмж

34

ХАРИУЦЛАГАТАЙ СОНГОГЧ

- Сонгогчийн боловсрол, зан төлөвийн судалгаа
- Баримтаар баталгаажуул: Иргэдийн мэдээллийн дархлаа ба хариуцлагатай сонгуулийн оролцоо

40

СОНГУУЛИЙН ЭРХ ЗҮЙ

- “Сонгууль-2024” эрдэм шинжилгээний илтгэл
“Сонгуулийн процессын тулгамдсан асуудал- сонгуулийн ирцийг нэмэгдүүлэхэд эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох нь”

44

ОНЦЛОХ НИЙТЛЭЛ

- Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэр: Шүүхийн хяналт

48

ГАДААД ХАРИЛЦАА

- “Сонгуулийн үр нөлөө тогтвортой байдал” сэдэвт олон улсын семинараас гаргасан дүгнэлт, зөвлөмж
- Ардчиллын төлөв байдал 2025

54

СОНГУУЛИЙН БОЛОВСРОЛД

- Үндэсний номын санд “Сонгуулийн боловсрол, эрх зүйн уншлагын танхим” ажиллаж байна
- Гадаад орнуудын үндсэн хуулиас...
- “Б.Чимидийн нэрэмжит шилдэг илтгэлийн уралдаан-2026” зарлалаа



ТАВДУГААР БҮЛЭГ

СОНГОГЧДЫН НЭРИЙН ЖАГСААЛТ БА СОНГОГЧИЙН ҮНЭМЛЭХ*

Бяраагийн Чимид

Ардчилсан Үндсэн хуулийн эхийг баригч, Монгол Улсын

Хөдөлмөрийн баатар, Ардын багш, Гавьяат хуульч, доктор, профессор

“Сонгуульд суралцахуй” номоос цувралаар хүргэж байна.

5.1 НЭРИЙН ЖАГСААЛТ, ҮНЭМЛЭХ ХОЁРЫН АЧ ХОЛБОГДОЛ

Сонгуулийн үйл явцын маргаанд нэлээд өртдөг асуудал бол сонгогчдын нэрийн жагсаалт юм. Түүнийг үйлдэх, танилцуулах, магадлан шалгах (тулгах), санал хураасныг тэмдэглэх, тооцох, хадгалах зэрэгт будлиан гарах, бас “гаргах” гээд байдгийг олон хүн мэднэ дээ. Тойрог хэсэг хичнээн сонгогчтой, хэд нь оролцсон, хаана хийдэг хоцорсон, санал “давхардуулан өгч” будлиулсныг нь нэрийн жагсаалт толь мэт харуулна. Иймд түүнийг бүртгүүлэхэд тал талаасаа, сонгогч өөрөө ч анхаарууштай байдаг.

Нэрийн жагсаалт гаргах нь ердийн нэг бичиг хэргийн чанартай ажил мэт санагдаж болох юм. Магадгүй түүнд нэр “орсон ч, байсан ч яалаа” гэсэн хайнга залхаг санаа тархинд сүүмэлзэж ч магадгүй. Буруу шүү! Та өөрийгөө “улсын иргэн” гэж үнэлэхгүй, “улс төрийн үхдэл” болгож байгаагаас нэг их өөрцгүй. Монголчууд:

“Цасан дээр гаргах мөртэй
Цаасан дээр бичих нэртэй
Төрдөө данстай

Түмэндээ алдартай”, бүрэн эрхт “Монгол Улсын иргэн хүн, би!” гэж бахархах нь зүй билээ. Эрийн цээнд хүрч, эмийн шинжийг олж төрийн хэрэгт шийдвэрлэх эрхтэй оролцон явнаа гэдэг чинь нийгмийн идэвхтэй гишүүн болсны тод нотолгоо мөн шүү. Энэ нь сонгуулиас жинхэнэ утгаараа эхэлдэг. Сонгуульд бол таны удам, овог нэр, иргэний

үнэмлэхийн болон бүртгэлийн дугаар нэрийн жагсаалтад бичигдэж баймааж Та тухайн тойргийн аль нэг хэсэгт саналаа өгч төрөө төвхнүүлэхэд хүч нэмнэ. Жагсаалтын гадна үлдсэн, түүнд буруу бичигдсэн бол Та улс төрийн суурь эрхээ эдэлж үл чадна. Ухаандаа сул орхиж хөсөр хаяж байгаа хэрэг. Яг л “эрхээ хасуулснаас юуны ялгаа байна” гэмээр. 1924 оны Үндсэн хуулиар язгууртан, баян чинээлэг, лам хувраг гэгдэж, дараа нь 1940 онд “эсэргүү” гэгдэж иргэний улс төрийн эрхээ хасуулсан хүмүүс цөөнгүй байлаа. Тэд сонгуульд байтугай баг, хорины хурал, цуглаанд ч үзэгдэж болдоггүй, хот айлд нь багийн хурал болж байхад “гэрийнхээ гадаа ганцаар гиюүрэн суудаг” байсныг ахмад үеийн бид нүдээр үзсэн билээ.

Одоо бол тийм цаг огт биш ээ. Нийтээр сонгох, сонгогдох улс төрийн эрхтэй, улс, аймаг, сумынхаа эзэн болцгоосон. Үүний тулд сонгогч Та нэрийн жагсаалтад зөв бүртгүүлэхийг өөрөө тухайлан анхаарч хянаж байх учиртай. Засаг төрийн байгууллага ч түүнийг цагт нь үнэн зөв гаргаж, сонгогч бүрт үзүүлж шалгуулж алдаа, эндэл байвал засаж залруулах үүрэгтэй.

Тэр жагсаалтад үнэн зөв бичүүлсэн эсэхийг магадлан үзэх, бурууг зөвтгөх нь сонгогч иргэний гуйлт биш, дархан эрх мөн. Та нэрийн жагсаалтад үнэн зөв бичүүлж баймааж сая сонгогчийн үнэмлэх авна. Тэр үнэмлэх нь Таны сонгох эрхийн хууль ёсны гол нотолгоо болно.

* Б.Чимид “Сонгуульд суралцахуй”. УБ 2008 108-114 тал

Сонгогчдын нэрийн жагсаалт бол сонгуулийн эрх бүхий иргэн бүр сонгуульд оролцох нэгэн зүйл баталгаа болох бөгөөд түүний хууль зүйн нотолгоо нь сонгогчийн үнэмлэх мөн.

5.2. СОНГОГЧДЫН НЭРИЙН ЖАГСААЛТ

УИХ-ын СТХ-ийн дөрөвдүгээр бүлэгт сонгогчдын нэрийн жагсаалт (нэрийн жагсаалт гэв) үйлдэх, танилцуулах, энэ талаар гомдол гаргах зарчим, журмыг тодорхойлжээ. 2007-12-26-нд УИХ-аас гаргасан хуулиар сонгогчдын нэрийн жагсаалт гаргах үүрэг, үйл ажиллагааны журмыг нэлээд нарийсгасан нэмэлт өөрчлөлт оруулжээ. Уул нь сум, баг, хорооны Засаг дарга хариуцдаг байсан энэ ажлыг Иргэний бүртгэл мэдээллийн алба (ИБМА), Сонгуулийн ЕХ-нд хариуцуулсан байна. Зарчим нь:

- сонгогч бүр сонгуулийн нэг хэсэгт, нэрийн нэг жагсаалтад бүртгэгдэнэ;
- хэсэг бүрт **«үндсэн», «зөөврийн хайрцгаар санал хураах»** хоёр төрлийн жагсаалт байна;
- нэрийн жагсаалтыг хувилж олшруулах, тараахыг хориглоно;
- сонгогч нэрийн жагсаалт болон ВЭБ хуудаснаас нэрээ шалгах, орхигдуулсан, буруу бүртгэснийг хэсгийн хороонд, түүний шийдвэрийг эс зөвшөөрвөл дээш давж гомдох замаар зөвтгүүлнэ.

Нэрийн жагсаалтыг үйлдэх, хянах, нэгтгэх, бэхжүүлэх, сонгогчдод танилцуулах үйл ажиллагааг дараах үе шатаар тодорхойлон журамласан байна.

- нэрийн жагсаалтыг сум, дүүргийн иргэний бүртгэл эрхэлсэн ажилтан сонгогчдын баг, хороонд оршин суугаа хаягийн бүртгэлийг иргэний үнэмлэхтэй тулган шалгаж гаргана;
- энэ жагсаалтыг аймгийн ДТГ-ын дэргэдэх ИБМА-д, тэндээс Төвдөө хүргүүлнэ;
- Улсын Иргэний бүртгэл мэдээллийн төв нь батлагдсан маягтын дагуу аймаг, нийслэлээр нэгтгэж санал авахаас өмнө Сонгуулийн ЕХ-нд ирүүлнэ;
- Сонгуулийн ЕХ сум, баг, дүүрэг, хороогоор гаргасан нэрийн жагсаалтыг ВЭБ хуудаст байрлуулах бөгөөд уул жагсаалтыг санал хураах өдрөөс 25-аас доошгүй хоногийн өмнө хэсгийн хороодод хүргүүлнэ.

Дээр эрэмбэлэн тайлбарласан зарчим, журам нь сонгогч нэрээ ВЭБ хуудсанд байгаа болон хэсэгт байгаа жагсаалтаас танилцаж, зөрөө байвал арилгуулах боломж олгоход чиглэжээ.

5.3 НЭРИЙН ЖАГСААЛТЫГ БИЧИХ, ТАНИЛЦУУЛАХ

Нэрийн жагсаалтын эцсийн хувилбарыг бичиж нэгтгэн гаргах, албан ёсны болгон баталгаажуулах, хэсгийн байранд тавьж сонгогчдод чөлөөтэй танилцуулах, илэрсэн алдаа зөрчлийг арилгах үүргийг **хэсгийн хороо** эрхлэн гүйцэтгэнэ. Үүний тул Сонгуулийн ЕХ-ноос ирүүлсэн нэрийн жагсаалтыг нягтлан шалгана. Энэ нь анх бүртгэгдсэн сонгогч тухайн үед (санал хураахаас өмнөх 25 хоногт) хэсгийн нутаг дэвсгэр дээр оршин суугаа эсэх, уул жагсаалт дээш, доош дамжиж явах зуур шилжиж ирсэн явсан хэн, хэн байгаа, бичлэг, бүрдэл нь сонгогчийн иргэний үнэмлэхтэй тохирч буй эсэхийг магадлана гэсэн үг болно. Энэ зорилгоор сонгогчид хийгээд сум, дүүргийн иргэний бүртгэл мэдээллийн ажилтан баг, хорооны Засаг дарга нартай уулзаж лавлах хэрэгцээ тохиолдож ч болно. Хуульд заасан хугацааг тооцвол уг ажилд хэрэг дээрээ 5 хоног л ноогдож байна. Шургуу шуурхай ажиллахаас аргагүй.

Хэсгийн хороо нягтлан шалгасны үндсэн дээр санал хураах өдрөөс **«20-оос доошгүй хоногийн өмнө»** Сонгуулийн ЕХ-ны баталсан маягтын дагуу нэрийн жагсаалтыг нэгтгэн хоёр хувь үйлдэнэ. Хэсгийн хорооны дарга, нарийн бичгийн дарга гарын үсэг зурна. Ингэснээр уг жагсаалт албан ёсны ба баримт бичигтэй танилцах, маргах мэтийн харилцааны үндэслэл болно. Аль ч шатанд нэрийн жагсаалт үйлдэхэд цагдаа, эмнэлэг, амралт сувиллын газрын захиргаа шаардагдах мэдээллийг хэсгийн хороонд гаргаж өгөх үүрэгтэй (СТХ-20.9).

Албан ёсны нэрийн жагсаалтыг санал хураахаас 15-аас доошгүй хоногийн өмнө хэсгийн байранд нийтэд ил тавьж, сонгогчдод танилцах боломж олгоно. Танилцах эсэх нь сонгогчдын хүсэл мэдэх эрх боловч тэдний сонгох эрхийг хангахын тулд аль болохоор танилцуулж, алдаа зөрүүгүй болгоход туслах нь зүй ёсны ажил болно.

Энэ бүхэнд Сонгуулийн ЕХ-ны 2008 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 05 дугаар тогтоолоор баталсан нэрийн



Сонгогч нэрийн жагсаалттай танилцаж байна

жагсаалтын загвар буюу маягтын үзүүлэлтийг эш үндэс болгоно.

"УИХ-ын 2008 оны сонгуулийн ... дугаар тойргийн ... дугаар хэсгийн сонгогчдын нэрийн жагсаалт"

№	Сонгогчийн эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр	Нас	Оршин суугаа газрын хаяг	Иргэний үнэмлэхний дугаар	Регистрийн дугаар
1.					
2.					

Дээрх маягтад жагсаалт үйлдэх үед тухайн хэсэгт байнга буюу түр оршин суугаа бүх сонгогчийн:

- эцэг /эх/-ийн нэр;
- өөрийн нэр;
- оршин суугаа газрын хаяг;
- иргэний үнэмлэхний дугаар;
- регистрийн дугаарыг тус тус бичнэ.

Харин **нэрийн дэс дугаарыг** сонгогчдын оршин суугаа газрын байршлаар нь "аль тохиромжтой байдлаар" дараалуулан бичнэ гэсэн заалттай. Практикаас үзвэл хороо, байр, хэсэг гэх мэт томоохон хэсгээр нь бүлэглэж өөрийнх нь нэрийн эхний үсгээс эхлэн цагаан толгойн дэс дараагаар цувиулан бичих нь зөв.

ЗӨВЛӨМЖ


Хуулийн заалт, маягтаас үзвэл сонгогч Та нэрийн жагсаалтад бүртгэгдсэн эсэхийг дээр дурдсан үзүүлэлт, маягтын дагуу 5 асуултаар тулган шалгаж, элдэв зөрөө, үсгийн алдаа байгаа эсэхийг магадлаарай.

5.4. СОНГОГЧИЙН ҮНЭМЛЭХ

Сонгогчийн үнэмлэх нь тухайн сонгогч бүртгүүлсэн хэсэгтээ **саналаа өгөх эрхийг нотолсон хууль ёсны баримт бичиг юм**. Өрсөлдөөнт сонгуулийн үед үнэмлэхийн үүрэг чамгүй их:

- сонгогчдын сонгох эрхийн гэрчилгээ болно.
- нэг сонгогч нэг хэсэгт нэг удаа санал өгөх тэгш эрхийн байдлыг хангахад тусална.
- сонгогчийг нэг хэсэгт дахин эсвэл өөр өөр хэсэгт санал өгүүлж, луйвар хийхээс сэргийлэхэд нотлох баримтын ач холбогдолтой.
- сонгогчийн эрхийг нотлоод зогсохгүй бас сонгуулийн дүнг гаргахад ч хууль зүйн ач холбогдолтой байж болно. Иймд үнэмлэх нь батлагдсан загвар, нэгдсэн "бар код" буюу нууц таних тэмдэгтэй байна.

Сонгуулийн ЕХ сонгогчийн үнэмлэхийн **загварыг баталж**, хэвлүүлэх, тараах ашиглах журмыг тогтоож зохицуулна. Загвар хараахан батлагдаагүй тул төслөөр үзүүлбэл:



Сонгогчийн үнэмлэхийг бичиж, олгох түүний хүчин төгөлдөр байдлыг баталгаажуулах журмыг СТХ-иар тогтоосон байдаг. Үүнд:

- үнэмлэхийг зөвхөн нэрийн жагсаалтад бүртгэгдсэн сонгогч бүрт дор дурдсанаар бичнэ.

СТХ-ийн 23 дугаар зүйлээс:

«23.2. Сонгогчийн үнэмлэхэд сонгогчийн эцэг /эх/-ийн нэр, нэр, төрсөн он, сар, өдөр, нас, иргэний үнэмлэхийн болон регистрийн дугаар, оршин суугаа газрын хаягийг бичнэ».

Энэ заалтаас үзвэл үнэмлэхэд бичсэн үзүүлэлт нь тухайн сонгогчийн жагсаалтад бүртгэгдсэн бүх үзүүлэлттэй яг тохирч байх ёстой. "Тулгана, шалгана" гээд байгаагийн учир энэ. Ийнхүү тулгах шалгах нь сонгууль будилахгүй, сонгогч хохирохгүй байх нөхцлийн нэг болно. Сонгогч шилжихэд жагсаалтаас хасаж үнэмлэхэд тэмдэглэнэ (Энэ тухай хойно 11 дүгээр бүлэгт тайлбарласныг үзээрэй).

- үнэмлэхэд хэсгийн хорооны дарга, нарийн бичгийн дарга гарын үсэг зурж, тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болно.
- үнэмлэхийг зөвхөн нэрийн жагсаалтад бүртгэгдсэн сонгогчдод олгоно (олгох журмыг энэ номын 10.2.3-т үзээрэй).

5.5. ЖАГСААЛТ, ҮНЭМЛЭХТЭЙ ХОЛБОГДСОН МАРГААН, ХАРИУЦЛАГА

Энэ тухай СТХ-д юу гэж заасан бэ?

СТХ-ийн 21 дүгээр зүйлээс:

«21.1. Сонгогчийг нэрийн жагсаалтад бүртгээгүй буюу буруу бүртгэсэн байвал сонгогч, сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигч тухайн хэсгийн хороонд гомдол гаргах эрхтэй».

Дээрх заалт сонгогчийн үнэмлэх өгөөгүй, тэр нь зөрүүтэй гэх асуудлаар гомдол гаргаж шийдвэрлүүлэхэд нэгэн адил хамаарна гэж ойлгож болно.

Нэрийн жагсаалтад бүртгээгүй, үнэмлэх олгоогүй, буруу бүртгэсэн (бичсэн) тухай гомдлоо сонгогч хэсгийн хороонд өгнө.

Хэсгийн хороо гомдлыг хүлээн авснаас хойш 3 хоногийн дотор шийдвэрлэнэ. Хэрэв санал хураах өдөр хүртэлх 3 хоногийн дотор юм уу, эсвэл мөн өдөр хүлээн авсан бол нэн даруй ("өдөрт нь") шийдвэрлэнэ. Гомдол үндэслэлтэй буюу үнэн зөв бол нэрийн жагсаалт, үнэмлэхийг зөвтгөх, үндэслэлгүй гэж тогтоогдвол хэрэгсэхгүй болгож хариу мэдэгдэнэ. Сонгогч хэсгийн хорооны шийдвэрийг эс зөвшөөрвөөс салбар хороонд, тийм хороогүй бол тойргийн хороонд давж гомдох эрхтэй.

СТХ-д тусгайлан заагаагүй ч гэсэн сонгуулийн хороодын эцсийн шийдвэрийг зөвшөөрөөгүй аливаа иргэн (сонгогч)-ий зохих шүүх ба цэцэд давж гомдох эрхийг хэрэгсэхгүй байж болохгүй. Энэ бол иргэдийн **үндсэн эрх** бөгөөд **сонгууль нь төр, иргэн хоёрын шууд харилцаа** мөн болохоос үүдэлтэй юм. Нэрийн жагсаалт гаргаж танилцуулах, үнэмлэх бичиж олгох, шилжүүлэх журам зөрчсөн сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүнийг уг зөрчил нь гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй бол СТХ-д зааснаар захиргааны журмаар торгоно.

Нэрийн жагсаалтыг олшруулан тараасан, бүртгэгдээгүй хүнд сонгогчийн үнэмлэх бичиж олгосон, шилжих журмыг буруугаар хэрэглэсэн этгээдийг хорооны бүрэлдэхүүнээс хасаж, дахин томилохгүй гэсэн бий (СТХ-26.6). Сүүлд дурдсан нь ёс суртахууны хариуцлага гэсэн үг.

Хариуцлагын арга хэмжээ нь сонгогчийн нэрийн жагсаалт, үнэмлэхийн талаарх харилцаа нарийн бөгөөд хариуцлага ихтэйг харуулна.

Үүнтэй холбогдуулж дараахь зөрчил гажуудлаас сэргийлэхийг Танд зөвлөе!

СЭРЭМЖЛҮҮЛЭГ

1. Нэрийн жагсаалт гаргах, түүнд тавигдах шаардлага, мэдээлэл өгөхдөө:

- «намчирхаж» өөрийн эсрэг санал өгч болзошгүй гэх нэгнийг сэм орхигдуулах;
- "иргэний үнэмлэхгүй", байвч "зөрчилтэй гэх";
- оршин суугаа хаяг тодорхойгүй; тойрог, хэсгийн "харьяа" биш гэх;
- насанд хүрсэн эсэх эргэлзээтэй;
- сонгуулийн өдрөөс өмнө засаж залруулж бүрнээ болох байтал худал үнэн шалтаг зааж ажлын цагаар хавчиж үнэмлэх олгохгүй чирэгдүүлэх зэргээс сэрэмжлээрэй. Цаг алдуузай!

2. Зарим хүн бусдын ятгалагатай автаж

- нэг жагсаалтад өөр нэрээр давхар бүртгүүлэх;
- хоёр буюу хэд хэдэн хэсэгт бүртгүүлэх;
- хэсэгтээ урьдчилан санал өгчихөөд өөр газар шилжин ирж буй дүрээр нэмэлт жагсаалтад бүртгүүлэх гэхчлэн луйвар гардгаас сэрэмжлээрэй!

3. Нэрийн жагсаалтаа алдаж гээгдүүлэх, гал, ус, салхи шуурганы аюул зэрэг шалтгаанаар үрэгдэхээс сэрэмжлэн найдвартай харж хамгаалаарай!

Зөвхөн 2004 оны сонгуулиар сонгуулийн насны 192856 иргэн нэрийн жагсаалтад бүртгэгдээгүй, олонхи нь "гадаадад" гэх боловч хэдэн арав нь эх орондоо байсан нь лавтай.

Сөргөөр бодоод эерэгээр дуусгавал өлзийтэй гэсэн шүү!

Сонгуулийн нэрийн жагсаалт бол иргэний аюулгүй байдал, халдашгүй эрхэд хохирол учруулахад ашиглагдаж болзошгүй¹ мэдээллийг агуулдаг. Иймд түүнийг нутгийн захиргааны болон сонгуулийн байгууллага данс хараатай эрхэлж, хариуцсан эзэнтэй, хадгалах савтай, иргэнээ нэмж бүртгэдэг "төрийн аж ахуй" болгон хариуцна.

СТХ-ийн 20 дугаар зүйлээс:

«20.11.Аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэдэх Иргэний бүртгэл, мэдээллийн алба сонгогчдын нэрийн жагсаалтыг жил тутам гаргаж байна»

¹ СТХ-д 2007 оны 12 дугаар сарын 26-нд оруулсан нэмэлтээр ВЕБ хуудсанд байрлуулсан жагсаалтыг «нам, эвсэл тойргийн хэмжээгээр, иргэд зөвхөн өөрийн нэрийг шалган танилцах боломжоор хангана» гэсэн нь тэгш байдлын болон иргэний халдашгүй эрхийн үүднээс эргэлзээтэй заалт мөнийг Сонгуулийн ЕХ нэгийг бодож хууль тогтоогчдод уламжилмаар. Бүх субъектийн дээр нам биш иргэн бий билээ! - Б.Ч.

МОНГОЛ УЛСЫН ТУСГААР ТОГТНОСОН АСУУДЛААР БҮХ АРД ТҮМНИЙ САНАЛ ГАРГУУЛСНЫ 80 ЖИЛИЙН ОЙ

“Монгол Улсын тусгаар тогтнолын асуудлыг ард түмнийх нь санал хураалтын үр дүнгээс шалтгаалан авч үзэж болох юм” гэсэн мэдэгдэл нот бичгийг Бүгд Найрамдах Хятад Улсын Гадаад яамны сайд Ван Си Зыгээс Монгол Улсад 1945 оны 08 дугаар сарын 14-ны өдөр илгээсэн байна. Уг нот бичгийг үндэслэн БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчдээс 1945 оны 9 дүгээр сарын 21-ний өдрийн 76 дугаар хурлаас тогтоол гаргажээ. Үүнд “Бүх ард түмний саналыг тус улсын бүх дэвсгэр нутаг дээр 10 дугаар сарын 20-ны өдөр нэгэн зэргээр гаргуулахаар тогтоосугай” хэмээн заасан байдаг.

Харин БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 1945 оны 10 дугаар сарын 5-ны өдрийн 85 дугаар тогтоолд: “Санал гаргах хуудсан дээр тавьсан өөрийн овог, нэрийн доор “зөвшөөрөх” болон “татгалзах” хоёрын аль нэгийг бичиж, гарынхаа үсгийг зур. Хэрвээ бичиг мэдэхгүй бол баруун гарынхаа эрхий хурууг дар” гэж заасны дагуу 1945 оны 10 дугаар сарын 20-нд улс орон даяар тусгаар тогтнолын төлөө бүх нийтийн санал хураалтыг 06:00-23:00 цагийн хооронд явуулсан юм.

Санал хураалтын төв комиссыг БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчдийн дарга Г.Бумцэндээр даргалуулан байгуулж, орлогчоор Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга Ю.Цэдэнбал, нарийн бичгийн дарга Ч.Сүрэнжав, нарийн бичгийн дарга Г.Дамба, Б.Ширэндэв нар томилогджээ. Ухуулга таниулгын хуудсыг Улаанбаатарт хэвлүүлж, орон нутагт тарааснаас гадна улс даяар 13000 удаа хурал цуглаан зохион байгуулж малчин, ард, ажилчин, сэхээтнүүдийг оролцуулсан. Санал хураалтын төв комиссын дарга болон орлогч нар аймаг бүрийг хуваарилан авч, өөрийн биеэр бэлтгэл ажлыг зохион байгуулсан байна.

Санал асуулгыг нийт 4251 хэсэгт явуулсан бөгөөд нэрсийн жагсаалтад 494,074 хүн бүртгэгджээ. Тэдгээрээс 487,285 хүн буюу нийт сонгогчийн 98.6 хувь нь саналаа өгсөн байна. Харин үлдсэн нь буюу 6791 хүн замд





явж байсан, өвчтэй зэрэг байсны улмаас санал хураалтад оролцож чадаагүй ажээ. Санал хураалтад оролцсон бүх хүн БНМАУ-ын тусгаар тогтнолын төлөө саналаа өгсөн түүхэн баримт Монгол Улсын Үндэсний төв архивт хадгалагдаж байна.

Санал хураалтанд “будлиан” орно гэж Хятадын Засгийн газраас тусгайлан Ли Фа Жан тэргүүтэй төлөөлөгчид ирж 1945.10.20-нд санал хураалт эхлэхэд ажиглалт хийсэн байна. Ажиглагчид саналын дүнг санал хураасан өдрийн маргааш, нөгөөдөр нь нэгтгэн дүгнэж, Төвдөө мэдээлж байжээ. Зарим санал авах газар мэдээгээ 11:00 гэхэд хийж дууссан байсан тул санал хураалтын дүнг нэгтгэхэд асуудал гараагүй ажээ.

Энэхүү санал хураалтын дүнг БНМАУ-ын Бага хурлын Тэргүүлэгчид 1945 оны 11 дүгээр сарын 10-нд баталж, түүнийг хэвлэлд нийтлэн ЗХУ ба Хятад Улсын Засгийн газарт тус тус мэдэгджээ.

1940 он гэхэд монголчуудын тал хувь нь бичиг үсэг тайлагдсан байлаа. Иймээс санал хураалтыг гарын үсэг болон баруун гарын эрхий хурууны хээгээр баталгаажуулсан байдаг юм. Гарын үсэг зурагчдын дийлэнх нь монгол бичгээр бичсэн бол кирилл үсгээр тун цөөн хүн гарын үсгээ зурсан баримт байна.

Монгол Улсын тусгаар тогтносон асуудлаар бүх ард түмний санал гаргуулсны үр дүнд хөрш орнууд БНМАУ-ын тусгаар тогтнолыг албан ёсоор бүрэн хүлээн зөвшөөрчээ. Үүний дараа Ази-Европ, Америк, Африкийн олон улс дипломат харилцаа тогтоон БНМАУ-ын тусгаар тогтнол олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн түүхтэй. 2025 онд Монгол Улсын тусгаар тогтносон асуудлаар бүх ард түмний санал гаргуулсны 80 жилийн түүхт ой тохиож байна.





Б.ЧИМИДИЙН “СОНГУУЛЬД СУРАЛЦАХУЙ” НОМЫН УНШЛАГА БОЛЛОО


Монгол Улсын тусгаар тогтносон асуудлын талаар бүх ард түмний санал гаргуулсны 80 жилийн түүхт ойд зориулав.

Монгол Улсын тусгаар тогтносон асуудлын талаар бүх ард түмний санал гаргуулсны 80 жилийн түүхт ойг тохиолдуулан Монгол Улсын төр, нийгмийн зүтгэлтэн, ардчилсан Үндсэн хуулийн эхийг баригч, Хөдөлмөрийн баатар, Ардын багш, Гавьяат хуульч, доктор, профессор Бяраагийн Чимидийн “Сонгуульд суралцахуй” номын уншлагыг Сонгуулийн ерөнхий хороо, Үндсэн хуулийн цэц, “Чимид сан”, МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэн хамтран 2025 оны 10 дугаар сарын 20-ны өдөр зохион байгууллаа.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дарга Г.Баясгалан уншлагыг нээж хэлсэн үгэндээ “Б.Чимидийн уншлага”-ыг зохион байгуулснаар уншихгүйгээр таамгаар ярих, уншсан ч ухаж ойлгохгүйгээр гуйвуулах явдал багасаж

түүний шинжлэх ухаанч өвийг хадгалах, үзэл санааг түгээн дэлгэрүүлэхэд түлхэц үзүүлэх нь гарцаагүй. Улмаар Үндсэн хуулийн шинжлэх ухааныг хөгжүүлэх, Үндсэн хуульт ёсыг төлөвшүүлэхэд нэн чухал хувь нэмэр болно хэмээн найдаж байна” гэж онцолсон юм.

Сонгуулийн ерөнхий хорооны Нарийн бичгийн дарга Д.Даваа-Очир “Б.Чимид багшийн “Сонгуульд суралцахуй” бол манай улсын сонгуулийн эрх зүйн хөгжлийн онцгой эх сурвалж, сонгогчдын боловсролын суурь гарын авлага, цаашлаад сонгууль зохион байгуулах үйл ажиллагааны үнэт өв хэмээн хүлээн зөвшөөрөгдөхүйц бүтээл юм. Энэхүү бүтээл нь сонгуулийн үйл явцын онол, арга зүйг тайлбарлахын зэрэгцээ ардчиллын үнэт зарчмыг иргэдэд





ойлгуулах, өнөөдрийн төдийгүй ирээдүйн сонгогчдын ухамсрын төлөвшилд хувь нэмэр оруулсаар ирсэн билээ.

“Сонгуульд суралцахуй” бүтээлийг нэг удаа судалж, хэлэлцээд өнгөрөх биш цаашид ч бүх нийтийн хүртээл, судалгааны эх сурвалж болгох нь нэн чухал. Тиймээс ч сонгуулийн эрх зүй, сонгуулийн процессын эрх зүйн салбарын эрдэм шинжилгээ, судалгааны бүтээлийг нэмэгдүүлэх, мэргэшсэн судлаач бэлтгэх, түүнд шаардлагатай орчин, нөхцөлийг бүрдүүлэх, энэ чиглэлээрх эрдэм шинжилгээ, судалгааны бүтээлийг судалгаа, шинжилгээний эргэлтэд оруулах, судлаачдыг идэвхжүүлэх, сонгогчдод сонгуулийн болон эрх зүйн боловсрол олгох зорилгоор Сонгуулийн ерөнхий хороо, Хууль зүйн үндэсний хүрээлэн, Үндэсний номын сантай хамтран Үндэсний номын санд “Сонгуулийн боловсрол, эрх зүйн уншлагын танхим” нээн ажиллуулж байна. Уншлагын танхимаа Хөдөлмөрийн баатар, Ардын багш, гавьяат хуульч, доктор, профессор Бяраагийн Чимидийн нэрэмжит болгож байгаагаа Та бүхэнд дуулгахад таатай байна” гэлээ.

“Чимид сан”-ийн тэргүүн Ч.Сайнсанаа хоёр дахь жилдээ уламжлал болгон зохион байгуулж байгаа энэхүү уншлага нь номын үг, өгүүлбэр бүрийг дахин судалж, Б.Чимидийн оюуны өвийг түгээн дэлгэрүүлэх, тайлбарлан таниулах, судалгааны эргэлтэд оруулах зорилготойг тодотгосон юм. Мөн “Сонгуульд суралцахуй” бүтээл нь зөвхөн хуульчдад зориулаагүй иргэн бүрд сонгуулийн боловсролыг түгээх бүтээл гэдгийг онцолсон. Б.Чимидийн “Сонгуульд суралцахуй” номын уншлагын үеэр дараах илтгэлүүдийг хэлэлцүүлэв:

- Хууль зүйн доктор, профессор Д.Солонго “Сонгуулийн эрх зүйн үндсэн асуудалд”;
- Сонгуулийн ерөнхий хорооны нарийн бичгийн дарга асан Ж.Сүхбаатар “Сонгуулийн байгууллага”;
- МУБИС-ийн Нийгэм, хүмүүнлэгийн ухааны сургуулийн дэд профессор, улс төр судлалын доктор Э.Гэрэлт-Од “Нам сонгуульд оролцох тухай”;
- “Нээлттэй нийгэм форум”-ын Засаглалын хөтөлбөрийн менежер, улс төр судлаач Д.Энхцэцэг “Сонгуулийн сурталчилгаа, санхүүжилт”;
- “Сонгогчдын боловсрол төв” ТББ-ын гүйцэтгэх захирал С.Оюунтуяа “Сонгогчийн боловсрол чухал болох нь”;
- Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын дарга Д.Бат-Эрдэнэ “Сонгуулийн маргаан хянан шийдвэрлэх хэргийн харьяалал”.

Эдгээр илтгэлтэй холбогдуулан 20 гаруй эрдэмтэн, судлаач санал дүгнэлтээ танилцуулж, хэлэлцүүлэг өрнүүллээ.

Уншлагыг Үндсэн хуулийн цэцийн гишүүн, хууль зүйн доктор, дэд профессор Ж.Эрдэнэбулган, МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэнгийн захирал, хууль зүйн доктор, профессор Х.Сэлэнгэ, Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн Д.Баяндүүрэн нар чиглүүлэн удирдсан бөгөөд Улсын Их Хурал, Сонгуулийн ерөнхий хороо, Үндсэн хуулийн цэцийн үе үеийн гишүүд, төр, нийгмийн зүтгэлтэн, судлаачид оролцсон юм.

БЯРААГИЙН
ЧИМИДИЙН

“Сонгуульд суралцахуй”

НОМЫН УНШЛАГА

Бяраагийн Чимидийн “Сонгуульд суралцахуй” номын уншлагын илтгэл, санал дүгнэлтүүдийг эмхэтгэл болгон хэвлэсэн бөгөөд уншигч та дараах QR -аар уншина уу ▶

Б.Чимид “Сонгуульд суралцахуй” (тогтолцоо, үйл явдал, эрх зүй) ном ▶

“СОНГУУЛИЙН БОЛОВСРОЛ” ОНОЛ, АРГА ЗҮЙН СЭТГҮҮЛ ОЮУНЫ ӨМЧӨӨР БАТАЛГААЖЛАА

МОНГОЛ УЛС
ОЮУНЫ ӨМЧИЙН ГАЗАР
БАРААНЫ ТЭМДГИЙН ГЭРЧИЛГЭЭ

Монгол Улсын Оюуны өмчийн газрын даргын 2025 оны 10 сарын 28-ны өдрийн А/119 тоот тушаалаар барааны тэмдгийг эзэмших онцгой эрхийг зөвшөөрч гэрчилгээ олгов.

Улсын бүртгэлийн дугаар:	40-0032537
Мэдээллийн бүртгэлийн дугаар:	40-2025-0037554
Анхдагч огноо:	2025.01.10
Эзэмшигчийн нэр:	Сонгуулийн ерөнхий хороо ТБАГ УТУГ
Эзэмшигчийн хаяг:	Улаанбаатар-15141, Ж.Самбуугийн гуудамж, Засгийн газрын 11 дүгээр байр, Монгол Улсын сонгуулийн ерөнхий хороо 2025.01.10
Хүчинтэй байх хугацаа:	Ангилал 16: Сэтгүүл [тогтмол хэвлэл]; сэтгүүл [нийтлэл]; хууль эрх зүйн сэтгүүл.
Бараа, үйлчилгээний олон улсын ангилал:	
Барааны тэмдэг:	

СОНГУУЛИЙН БОЛОВСРОЛ
ОНОЛ АРГА ЗҮЙН СЭТГҮҮЛ

Хамгаалагдахгүй үг, дүрс: онол арга зүйн сэтгүүл

ДАРГА  Г.ЗӨЛБЭГСЭЙХАН



0014403

Монгол Улсын Оюуны өмчийн газрын даргын 2025 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн А/119 тоот тушаалаар Сонгуулийн ерөнхий хороо “Сонгуулийн боловсрол” онол, арга зүйн сэтгүүл” барааны тэмдгийг эзэмших онцгой эрхтэй боллоо.

Мөн тогтмол эрхлэн гаргадаг сонин, сэтгүүлд олгодог олон улсын стандарт дугаар ISSN (International Standard Serial Number)-3106-4078 авсан юм. Ингэснээр “Сонгуулийн боловсрол” онол, арга зүйн сэтгүүлийг дэлхийн хаанаас ч унших боломжтой, олон улсад данстай болов.

Улсын бүртгэл, Оюуны өмчийн гэрчилгээгээр баталгаажиж, олон улсын ISSN дугаар авснаар “Сонгуулийн боловсрол” онол, арга зүйн сэтгүүл академик сэтгүүлийн статустай болох боломж бүрдэж байгаа юм. Тиймээс “Сонгуулийн боловсрол” онол, арга зүйн сэтгүүлийг дотоодын мэргэжлийн эрдэм шинжилгээний сэтгүүлд бүртгүүлэхээр Шинжлэх ухааны

академид хүсэлт хүргүүлээд байна.

Сонгуулийн ерөнхий хорооноос эрхлэн гаргадаг тус сэтгүүлийн редакцид Академич, Хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор Ж.Амарсанаа зөвлөдөг бөгөөд редакцын бүрэлдэхүүнд Академич, Эдийн засгийн шинжлэх ухааны доктор, профессор Т.Дорж, Академич, Хөдөө аж ахуйн шинжлэх ухааны доктор, профессор Ч.Содномцэрэн, Философийн шинжлэх ухааны доктор, профессор Д.Дашпүрэв, Хууль зүйн доктор, профессор Д.Даваа-Очир, Хууль зүйн доктор, профессор Д.Гангабаатар, Бизнесийн удирдлагын доктор, профессор З.Сүхбаатар, Улс төр судлалын доктор О.Хатанболд, Хууль зүйн доктор, профессор А.Эрдэнэцогт болон Хууль зүйн магистр Д.Бат-Эрдэнэ, “Сонгогчдын боловсрол төв” ТББ-ын Гүйцэтгэх захирал С.Оюунтуяа, “Чимид сан” ТББ-ын Тэргүүн Ч.Сайнсанаа, “Сонгуулийн боловсрол” клубийн Удирдах зөвлөлийн ахлагч С.Уянга нарын эрдэмтэн, судлаачид ажилладаг.

Г.ТУЯАГЭРЭЛ:**ИЛ, ТОД, НЭЭЛТТЭЙ, ХҮН НЭГ БҮР ИДЭВХ ОРОЛЦООТОЙ, МЭРГЭШСЭН БАЙХ ЗАРЧИМ НАМЫН ТҮВШИНД ХАНГАГДАХ ЁСТОЙ**

*МУИС-ийн, Улс төр судлалын тэнхимийн доктор, дэд профессор
Г.Туяагэрэлтэй ярилцлаа.*

Сэтгүүлч **С.Уянга**



-Засгийн газрын хувь заяа дээсэн дөрвөн дээр дэнжгэнэдэг болоод удлаа. Та бүхний судалгаанаас харахад улс төрийн намууд гүйцэтгэх засаглалын тогтворгүй байдалд хэрхэн нөлөөлж байна вэ?

-Улс төрийн намд итгэх иргэдийн итгэл буурахаар нийгэмд "Асуудлыг намгүйгээр шийдье" гэдэг ойлголт бий болж эхэлдэг. Гэтэл бодит байдал дээр ардчиллын баталгаа, гүйцэтгэх засаглалын тогтвортой байдал нь улс төрийн намын төлөвшил, хөгжилтэй шууд холбоотой.

Судалгаанаас харахад Монголд гүйцэтгэх засаглалын тогтвортой байдлыг 1.6-2.3 жил гэж тодорхойлдог. Энэхүү үзүүлэлт нь гүйцэтгэх засаглалыг бүрдүүлж байгаа улс төрийн намуудын хөгжил төлөвшил, эрх зүйн орчинтой холбоотой. Улс төрийн намын хуулийн шинэчилсэн найруулга энэ оны эхнээс хэрэгжих ёстой байсан. Гэтэл хуулиа дагаж мөрдөхгүй байх, дахин өөрчлөхөөр ярьж байгаа зэрэг нь гүйцэтгэх засаглалын тогтворгүй байдал, улс төрийн намын төлөвшилд сөрөг үр дагавар авчирч болзошгүй байна.

Улс төрийн намын хөгжилд нөлөөлж буй зайлшгүй шийдвэрлэх ёстой гурван асуудал бий. Нэгдүгээрт, санхүүжилтийн ил тод, нээлттэй байдал. Хоёрдугаарт, намын шийдвэр гаргах түвшинд гишүүн нэг бүр оролцох боломжтой юу, эсвэл цөөн тооны эрх мэдэлтэй хэсгийг тойрсон фракц нөлөөлж байна уу гэдгийг олж харж байж дотоод ардчилал хангагддаг. Гуравдугаарт, нэр дэвшигчдийг сонгон шалгаруулах журам тодорхой байх ёстой. Эдгээр гурван асуудал хэр бүрхэг байна, тэр хэмжээгээр улс төрийн намын хөгжил төлөвшилд нөлөөлдөг. Эдгээр асуудлаа бүрэн шийдвэрлээгүй нам гүйцэтгэх засаглалын түвшинд ажиллах, эвсэж юм уу хамтарч байгаа тохиолдолд төр тогтворгүй болох үндсэн шалтгаан болдог. Улс төрийн намд үүссэн санхүүжилтийн ил тод бус байдал, гишүүдийн

идэвх, оролцоо, итгэл үнэмшилгүй байдал бүгд гүйцэтгэх засаглалын түвшинд ажиллаж эхлэхээр тодорхойгүй, хаалттай болж эхэлдэг. Нэг ёсондоо, Засгийн газрын кабинетад орж ажиллахад тавигдах ур чадварын шалгуур үзүүлэлт тодорхойгүй байдаг. Тиймээс гүйцэтгэх засаглалын тогтвортой байдлыг хангах ил, тод, нээлттэй, хүн нэг бүр идэвх оролцоотой, мэргэшсэн байх зарчим бүгд намын түвшинд хангагдах ёстой. Улс төрийн намууд энэ бүхнийг шийдвэрлэж байж гүйцэтгэх засаглалын тогтвортой байдал хангагдана, ахиц дэвшил гарна.

Улс төрийн нам дотоод асуудал, фракцын зөрчил тэмцэл нь төрийн эрх бариагүй үед намын "өвчин" байна. Гэтэл энэ асуудлаа дотооддоо шийдэж чадалгүй төр засгийн эрх мэдэл бариад ирэхээр төрийн "өвчин" болж хувирдаг.

Нам дотоод асуудлаа шийдвэрлэх гарц нь Улс төрийн намын тухай хуулиа хэрэгжүүлэх, намын дүрэм журмаа сайжруулж ил тод болгох, гишүүдээрээ нээлттэй хэлэлцүүлж батлах үйл явц буюу нам дүрмээрээ юу шийдэх вэ гэдэг тал дээр тодорхой бодлогын баримт бичигтэй болж байна гэсэн үг. Харин энэ бодлогын баримт бичгийнхээ дагуу асуудлаа шийдвэрлэж чадвал нам дээр хүн биш журам засаглана. Жишээлбэл, намын дүрэмд парламентад нэр дэвших, жагсаалтад орох, тойрогт өрсөлдөх хүмүүст ямар шалгуур тавих вэ гэдгийг намын дээд удирдлага мэддэг байх ёсгүй. Намын гишүүд, сонгогчид мэдэх ёстой. Улс төрийн нам тухайн нэр дэвшигчийг ямар шалгуураар сонгож УИХ-д нэр дэвшүүлж байгааг сонгогчдын хэдэн хувь нь мэдэж байгаа вэ гэдэг чухал. Өөрөөр хэлбэл, өнөөгийн нөхцөлд намын гаргаж ирсэн жагсаалт дундаас иргэд сонголтоо хийж байгаагаас хэн гэдэг нэр дэвшигч ямар шалгуураар ард түмнийг төлөөлж чадна гээд нэр дэвшиж байгааг нь мэдэхгүй байна. Угтаа ард иргэд сонгогдчихсон хүмүүсээс сонголтоо хийж байгаа хэрэг.

УИХ ч тэр, орон нутаг ч гэсэн яг ямар шалгуур хангасан хүмүүс нэр дэвших эрхээ авах буюу намын сонгон шалгаруулалтын систем дүрэмдээ ил тод, нээлттэй байх юм бол дотоод ардчиллын механизмыг бий болгоно. Намын хүний нөөцийн бодлого, дэмжлэг, хариуцлагын хөшүүрэг намын дүрэмдээ тодорхой туссан байх ёстой болохоос Улс төрийн намын хуулиар зохицуулдаггүй. Иймээс л намын дүрмийн шинэчлэлийн асуудал чухал байгаа юм. Товчхондоо, улс төрийн намын тогтвортой байдлыг хангаж байж гүйцэтгэх засаглал бие даасан, хараат бусаар ажиллах механизм бүрдэнэ.

Улс төрийн намын тухай хуулийн шинэчлэлээр намууд дүрмээ шинэчилж байж Дээд шүүхэд бүртгүүлэх зохицуулалттай. Намын дүрмээ зөрчсөн бол ямар хариуцлага хүлээлгэх вэ гэдэг нь тодорхой байх ёстой. Тухайлбал, Засгийн газрын гишүүн кабинетынхаа эсрэг ажилласан бол яах юм. УИХ дахь намын бүлгийн шийдвэрээ дагахгүй хувийн тоглолт хийвэл яах юм. Энэ тохиолдолд ёс зүйн зөрчил гэж үзэх үү, ямар дүрэм журмаар шийдвэрлэх вэ гэдэг тодорхой байх шаардлагатай. Хэрэв зөрчил гэж үзэж байгаа бол хүлээлгэх хариуцлага ямар байх вэ. Энэ бүгдээс үүдэлтэйгээр нийгэмд үүсээд буй шүүмжлэл, эсэргүүцлийг дүрэм журмын хүрээнд шийдвэрлээд явдаг байх ёстой. Тодорхой бус байгаа учраас асуудлыг томруулах үндсэн шалтгаан болж байна.

ОЛОНХТОЙ САНАЛ НИЙЛЭЭГҮЙ ЦӨӨНХИЙН АСУУДЛЫГ БОДЛОГЫН ТҮВШИНД ХЭРХЭН ТУСГАЖ ЧАДАЖ БАЙНА ВЭ ГЭДЭГ АРДЧИЛЛЫН ЧАНАРЫН ХЭМЖҮҮР ЮМ-

-Танхимаа бүрдүүлэх нь Ерөнхий сайдын бүрэн эрхийн асуудал. Харин сайд болохын тулд ямар шалгуур шаардлага хангах ёстой вэ гэдэг дүрэм журмыг нам дүрэмдээ тусгаж, нээлттэй болгох нь гэж ойлголоо?

-Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулиар бол Монгол Улсын Ерөнхийлөгчид тавигддаг шаардлага бий. Мөн УИХ-ын гишүүнээр сонгогдох насны хязгаарын заалт байгаагаас өөр бусад шалгуур шаардлага хуульчлагдаагүй байна. Ер нь хуульчлагдах шаардлагагүй ч байж магадгүй. Харин улс төрийн намын дотоод дүрэм журамд хэн аль шатанд ажиллахаас шалтгаалан сонгон шалгаруулалт, шалгуур үзүүлэлт тодорхой байх ёстой. Ингэж байж нам ил тод нээлттэй, гишүүн бүр оролцох боломжийг хангаж өгнө.

Ардчилал гэдэг олонхоороо түрж шийдвэр гаргах юм уу эсвэл шийдвэр гаргах эрх мэдэлтэй цөөн тооны хүмүүсийг тойрон хүрээлсэн фракцын механизм биш. Харин олонхтой санал нийлээгүй цөөнхийн асуудлыг бодлогын түвшинд хэрхэн тусгаж чадаж байна вэ гэдэг ардчиллын чанарын хэмжүүр юм. Магадгүй улс төрийн нам дээр гарч байгаа шийдвэр намын дарга, аль нэг түвшний удирдлага,

алба, хэлтсийнх байж болно. Гэхдээ хамгийн гол нь намын зохион байгуулалтын бүтцэд орж байгаа мянга мянган гишүүдийн үзэл бодлын илэрхийлэл байх ёстой. Үүнийг намын нээлттэй байдал, дотоод ардчилал хангагдсан гэж үздэг. Мэдээж намын гишүүн нэг бүртэй уулзаж ярилцах боломжгүй ч тэдгээрийн саналыг төлөөлөх механизмыг яаж бүрдүүлэх вэ гэдэг нь шинэчлэлийн бодлогын цөм байх, үүнд технологийн хөгжлийг ашиглах талаарх шийдэл судалгаанууд дэлхийн хэмжээнд цөөнгүй хийгдэж байна. Намын бодлого шийдвэрийг нийт гишүүдэд маш бага өртөг зардлаар хүргэх технологийн шийдлийг хэрэгжүүлэхэд улс орнуудад маш том өөрчлөлт гарсаар байна. Нам хаалттай хэлбэрээс нээлттэй хэв шинж рүү шилжиж байгаагийн нэг жишээ нь хатуу гишүүнчлэлээс татгалзаж, дижитал намын тухай үзэл баримтлал гарч ирж байна.

-Монгол Улсад 37 нам бүртгэлтэй атлаа парламент бүрдүүлж буй цөөн хэдэн намын байр суурь тод байдаг. Бусад намуудын дуу хоолой хаачив гэдгийг судлаачийн талаас хэрхэн харж байна вэ?

-Төрийн үйл ажиллагааг тогтвортой, тасралтгүй явуулахад зөвхөн парламентад байгаа сөрөг хүчин ажиллах ёстой гэсэн үг биш. Монголд Улс төрийн 37 нам бүртгэлтэй байгаа мөртлөө яагаад байр сууриа идэвхтэй илэрхийлэхгүй байна вэ гэвэл гуравдагч хүчний төлөвшил, институцлал ямар түвшинд байгааг харуулж байгаа хэрэг. Эдгээр намууд тодорхой хэмжээгээр бойжих гэж оролдож байгаа байх. Олон нийтийн сүлжээнд тавигдсан мэдээллээс харахад дүрмийн шинэчлэлээ хийж, Сонгуулийн ерөнхий хороо, аудитын байгууллагын сургалтад хамрагдаж шат ахих, хөгжих гэж хичээж байна гэж харж байгаа.

Төрийн бодлого үйл ажиллагаанд хөндлөнгөөс хяналт тавьж, сөрөг хүчний байр сууринаас хандах үйл явц бол улс төрийн намууд байгуулагдаад 1-2 жилийн дотор хийдэг зүйл бол бас биш юм. Улс төрийн зарим намын онцлог, туршлагаас харахад институцжих үйл явцад магадгүй 10 жил хангалтгүй. Цаг хугацаанаас гадна хүний нөөц чухал.

Манай улсын хувьд сонгогчдын тоотой харьцуулж, эдийн засгийн агуулгаар нь аваад үзэхэд жижиг зах зээл шүү дээ. Мөн 37 намын ард талд хуульд заасан хэмжээний гишүүн байх боломжтой юу гэж үзвэл өрөөсгөл. Өөрөөр хэлбэл, намыг төлөвшүүлэх хэмжээний зах зээл буюу гишүүн дэмжигч, хүний нөөц хангалтгүй байгааг харуулж байна. УИХ-д суудалтай намуудын хувьд ч гэсэн хүний нөөцөө хэрхэн яаж бэлтгэж байна вэ гэдэг нь ямар түвшний хүмүүс хууль тогтоох институцид болон гүйцэтгэх засаглалд ажиллаж байна вэ гэдгээс харагдаж байна. Нам дээр асуудлаа хэрхэн шийдвэрлэдэг соёл нь хууль тогтоох, гүйцэтгэх засаглалд ороод ирэхээрээ яг тэр зарчмаараа яваад байгаа хэв шинж ажиглагддаг.

Гуравдагч хүчний бойжиж төлөвших үйл явц нь санхүүжилт, хүний нөөц, тогтвортой үйл ажиллагаа явуулах хугацаанаас ихээхэн хамааралтай. Гэтэл манай улсад зарим намууд сонгуулийн үеэр идэвхжээд бусад үед намын гэрчилгээ нь байгуулсан хүнийхээ халаасанд явдгийг ч

үгүйсгэхгүй. Төрийн бус байгууллагууд ч мөн адил ийм хэв шинжээр бойжиж өгөхгүй байгаа юм.

Тиймээс цаашид улс төрийн намууд илүү бодлого боловсруулах түвшинд орж ажиллах, институцлэгдэхэд зайлшгүй Улс төрийн намын тухай хуулийг хэрэгжүүлэх шаардлагатай. Намууд өөрчлөгдөх оролдлогууд хийж байгаа ч удаан байна уу гэж харж байна.

-Сонгогчдын боловсролыг дээшлүүлэх ажил дорвитой хийгдэхгүй өдийг хүрлээ. Үүний нэг шалтгаан нь сонгогчдыг соён гэгээрүүлэх, боловсролд зарцуулах төсвийг төр баталж өгдөггүйтэй холбоотой. Ер нь сонгогчдод боловсрол олгох нь хэний үүрэг юм бэ?

-Сонгогчдын боловсролд анхаарах нь зөвхөн Сонгуулийн ерөнхий хорооны үүрэг биш. Сонгуулийн боловсролтой холбоотой чиг үүрэг хэрэгжүүлэх ёстой нэг институц нь улс төрийн намууд. Тиймээс Улс төрийн намын хуулийн шинэчилсэн найруулгаар намын санхүүжилтийн 20 хувийг сонгогчдын боловсролд зарцуулахаар тусгасан. Энэ бол сонгогчдын боловсролд улс төрийн нам ямар чухал үүрэгтэй вэ гэдгийг харуулаад зогсохгүй хуулиар баталгаажуулж өгч буй хэрэг.

Гуравдугаарт, иргэний нийгмийн байгууллага болон иргэдийн оролцоо чухал. Иргэн өөрийнхөө амьдралтай холбоотой асуудлыг шийдвэрлэхэд оролцох нь соёлын илэрхийлэл байдаг. Үүнийг зөвхөн сонгуулийн байгууллага, улс төрийн нам хийхээс илүү иргэн өөрийнхөө өмнө хариуцлага хүлээх ёстой. Түүнчлэн төрийн үйл ажиллагааг иргэнтэй холбох гүүр болдог иргэний нийгмийн байгууллагын үүрэг, оролцоо, хяналт зайлшгүй шаардлагатай.

Төрөөс сонгогчдын боловсролд зарцуулахад тодорхой төсөв олгохгүй байна гэдэг нь төрийн бодлогыг тогтвортой хэрэгжүүлэх нэг функц нь ажиллахаа болино гэсэн үг шүү дээ.

Сүүлийн жилүүдэд Монголын ардчилал аюулд орлоо гэдэг айдас, эргэлзээ нийгэмд бий боллоо. Гэхдээ ардчилал яаж бэхэждэг вэ гэдгийг анхаарах хэрэгтэй. Ардчилал тухайн улс оронд тогтож, хэлбэржихэд хяналтын байгууллагын үүрэг маш чухал байдаг. Үүнийг засаглал хуваарилах онолоор хууль тогтоох дээд байгууллага УИХ, гүйцэтгэх засаглал, шүүхийн үйл ажиллагаа хуулийн хүрээнд явагдахад хөндлөнгөөс хяналт тавих байгууллагуудыг хэлж байгаа юм.

Ардчилал өндөр хөгжсөн орнуудын жишгээс харахад төрийн институцид хяналт тавьдаг байгууллагуудыг удирдан чиглүүлэх үйл ажиллагаа төрөөс хамааралгүй, бие даасан байх ёстой. Төр өөрийнхөө үйл ажиллагааг хянахад өөрөө оролцох ёсгүй. Үүнийг хангаж чадаж байвал ардчиллын баталгаа болж өгдөг. Төрөөс удирдлагыг нь томилоод, төсвийг нь батлаад, үүрэг чиглэл өгөөд байх юм бол тэнд бие даасан байдал, хөндлөнгийн хяналт гэж үгүй.

-НАМУУД ФРАКЦЫН АСУУДЛАА ШИЙДЭХГҮЙ БОЛ ЭРХ АШГИЙН ЗӨРЧИЛ МӨНХИЙН ДАГАЛДАХ БОЛНО-

-Нэг хэсэг намуудын фракцийн асуудал сөхөгддөг байсан бол одоо УИХ, Засгийн газар эрх ашгаараа нэгдсэн бүлэглэлтэй боллоо гэж олон нийт шүүмжилж байна. Фракцыг хүлээн зөвшөөрөөд намын дүрэм журамдаа тодорхой тусгаж болох уу. Бусад орны туршлага ямар байдаг вэ?

-Намыг фракцгүйгээр ойлгох ямар ч боломжгүй. Харин яагаад далд байна вэ гэвэл нам нь дүрмээрээ зохицуулж чадахгүй болохоор хөшигний ард тоглолт хийгээд байгаа хэрэг. Фракцыг зохицуулах дүрэм журамтай болчихвол хөшигний ардах тоглолт тодорхой хэмжээгээр ил болно. Ингээд ярихаар хүмүүс боломжгүй гэж бодож магадгүй. Хэрэв фракцыг дүрмээрээ зохицуулах боломжгүй байсан бол ардчилал өндөр хөгжсөн, улс төрийн ёс зүйг чанд мөрддөг улс орнуудад энэ асуудлыг намын дүрэм журамдаа оруулж, хүлээн зөвшөөрөхгүй шүү дээ. Тэдгээр улс орнуудад яагаад улстөрчид нь буруу зүйл хийсэн бол ард түмнээсээ уучлал гуйж огцроод байна вэ гэвэл улс төрийн намынх нь дүрэм журмууд нь маш тодорхой байдаг. Намын дүрэм нь маш том зохицуулалт болж өгдөг. Намын гишүүн ноцтой улс төрийн алдаа гаргасан гэж үзвэл дүрмээрээ хариуцлага хүлээдэг, түүгээрээ фракцуудаа зохицуулдаг тодорхой жишиг бий.

Аливаа зүйлд хууль, дүрэм биш хүн засагладаг болоод ирэхээрээ субъектив үр дүн гаргах гээд байдаг талтай. Нэг хүний дүрэм, эрх ашгаар асуудлыг шийдээд явах сөрөг нөлөөтэй.

Улс төрийн намын бусад институциас ялгардаг нэг шинж нь үүсгэн байгуулагчаасаа урт настай байдаг. Өөрөөр хэлбэл, удирдаж байгаа хүн нь байсан байгаагүй нам урт удаан хугацаанд тогтвортой оршин байх нь дүрэм байдаг. Тэр дүрэм нь л институцийг хэн манлайлж байхаас үл хамааран урт удаан хугацаанд оршин тогтнох суурийг тавьж өгдөг.

Нам институцлэгдэх, урт удаан хугацаанд орших, бодитой байна гэдэг бүх асуудал нь хүнээс үл хамаарах засаглал, удирдлага хяналтын тогтолцоо, хүнээс үл хамаарах асуудал шийдвэрлэдэг тогтолцоо байдаг. Түүнээс фракц байх нь маш муу гэдэг ойлголт өрөөсгөл. Институц байгаа л бол фракц байх л болно.

Фракцын асуудлаа шийдвэрлэхгүй бол намыг эрх ашгийн зөрчил мөнхийн дагалдах болно.

Монголчуудад байдаг нэг сөрөг сэтгэгдэл бол фракц, амбиц гэхээр л муу, муухай юм шиг ойлгодог. Гэтэл фракц бол аливаа институцийн жам ёсны л асуудал.

УЛСЫН ДЭЭД ШҮҮХЭД УЛС ТӨРИЙН НАМУУДААС ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ХАВСАРГАСАН БАРИМТ БИЧГИЙГ “ШАЛГАХ ХУУДАС”-Т ЗААСНААР ХЯНАНА

Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 2-т “Нам өөрийн дүрэм, хөтөлбөр, дотоод зохион байгуулалтыг Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-тай нийцүүлэх арга хэмжээг 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор авч хэрэгжүүлэх бөгөөд уг өөрчлөлтийг Улсын дээд шүүхэд 30 хоногийн дотор хүргүүлнэ” гэж заасан.

Хуулийн хэрэгжилтийг хангах, улс төрийн намуудад зөвлөмж, мэдээлэл өгөх зорилгоор Сонгуулийн ерөнхий хороо, Улсын дээд шүүхийн Тамгын газартай хамтран “Улс төрийн намын дүрмийн нэмэлт, өөрчлөлт (шинэчилсэн найруулга)-ийг бүртгүүлэхэд анхаарах асуудал” уулзалтыг 2025 оны 11 дүгээр сарын 7-ны өдөр зохион байгууллаа.

Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн 2025 оны 9 дүгээр сарын 12-ны өдрийн хуралдаанаар Улсын дээд шүүхээс бүртгэхээс татгалзаж буцаасан тогтоол, шийдвэрүүдийг судлан үзэж, намын дүрэм, хөтөлбөрийг Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д нийцүүлэх шаардлага, шалгуурын талаар нэгдсэн, нэг мөр ойлголтыг

дотоод ажлын хүрээнд бий болгох зорилгоор намуудаас ирүүлсэн өргөдөл, хавсаргасан материалыг хянах “Шалгах хуудас” үүсгэж, үүний дагуу намын дүрмийн өөрчлөлтийг бүртгүүлэх, шинээр улс төрийн нам үүсгэн байгуулсныг бүртгүүлэх өргөдлийг холбогдох Бүртгэлийн алба, хүлээн авсан шүүгч хянан шалгаж, Улс төрийн намын бүртгэл хөтлөх журмын дагуу өргөдлийг шийдвэрлэж байхаар Нийт шүүгчийн хуралдаанаас тогтсоныг Захиргааны хэргийн танхимын тэргүүн Д.Мөнхтуяа уг уулзалтын үеэр мэдээлж, анхаарах асуудлын талаар арга зүйн зөвлөмж өгсөн юм.

Улсын дээд шүүхэд бүртгэлтэй намуудын хувьд:

- Намын дүрэм, мөрийн хөтөлбөрийг шинэчлэн баталсан үйл ажиллагаа нь тухайн намын хүчин төгөлдөр дүрэмд нийцсэн эсэхийг **“ШАЛГАХ ХУУДАС-1”**;
- Намын дүрэм, мөрийн хөтөлбөр нь Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д нийцсэн эсэхийг **“ШАЛГАХ ХУУДАС-2”**-т заасан бүрдлийн дагуу хянан шалгах аж.





УДШ-д бүртгэлтэй улс төрийн нам:

**ДҮРЭМ, МӨРИЙН ХӨТӨЛБӨРИЙГ ШИНЭЧЛЭН БАТАЛСАН ҮЙЛ АЖИЛЛАГАА
/ШАЛГАХ ХУУДАС - 1/**

д/д	Үйл ажиллагаа	Дүрэмд нийцсэн эсэхийг шалгах шалгуур	Зөрчил илэрсэн эсэх
Улсын дээд шүүхэд бүртгэлтэй хүчин төгөлдөр Дүрэм			
1	Дүрэм, мөрийн хөтөлбөрийг шинэчлэн батлах эрхтэй этгээдийг тодорхойлох	- Намын Их хурал - Намын Төлөөллийн төв байгууллага /Аль нь эсэх/	
2	Хурал зарласантай холбоотой процесс	Намын Дүрэмд зааснаар хурлыг эрх бүхий этгээдээс зарласан эсэх / аль нь болох/: - Намын дарга - Төлөөллийн төв байгууллага - Гүйцэтгэх байгууллага /Хурлыг зарлан хуралдуулах шийдвэр нь намын Дүрэмд нийцсэн эсэхийг шалгана/	
		Хурал зарласан хугацаа: - Хурлын тов тогтоохтой холбоотой аливаа хугацааг Дүрмээр тогтоосон эсэх; - Хурлыг зарлахдаа уг хугацааг баримталсан эсэх; - Эрх бүхий этгээдийн шийдвэрээр хурлын тов тогтоосон эсэх; /холбогдох баримтуудыг ирүүлэх/	
		Хурал зохион байгуулах газар, хурлын товыг гишүүдэд ямар хэлбэрээр мэдэгдсэн, хүргэсэн талаарх баримтыг ирүүлнэ: - Сонинд зарласан; - Утсаар мэдэгдсэн /бүртгэл/; - Цахимаар /намын вэбсайт, мэйл/; - Радио, телевиз; - Урилга хүргүүлсэн; гэх мэт	
		Их хурлын Төлөөлөгчийг сонгож, томилсонтой холбоотой баримтууд: - Төлөөлөгчийг сонгож, томилох ажиллагаа Дүрэм-д заасны дагуу явагдсан эсэх • Хурлын төлөөлөгчдийг хэн, хэрхэн сонгож, томилохоор Дүрэмд заасныг тодорхойлж, төлөөлөгчийг сонгож томилсонтой холбоотой шийдвэр, баримтыг ирүүлэх; • Төлөөлөгчдийн нийт тоо; • Орон нутгийн төлөөллийн тоо; - Төлөөлөгчдийн бүрэн эрхийг баталсан баримт. /Төлөөллийн төв байгууллага нь намын Дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах эрхтэй бөгөөд уг байгууллагаас Дүрмийн нэмэлт өөрчлөлтийг баталсан тохиолдолд Их хурлын Төлөөлөгчийг сонгож, томилсонтой холбоотой энэ хэсэг хамаарахгүй./	
3	Хурлын явц	- Дүрэмд заасны дагуу хурлыг цахимаар эсхүл танхимаар биечлэн аль хэлбэрээр хийсэн талаарх баримт; - Хуралд оролцсон гишүүдийн ирцийн бүртгэл; /намын гишүүн, тухайн хуралд оролцох эрхтэй этгээд мөн эсэхийг шалгана/ - Оролцвол зохих этгээдийн олонх оролцсон буюу ирц хүрсэн эсэхийг шалгана. - Хурлаар хэлэлцэх асуудлыг тодорхойлж баталсан, хуралдаан даргалагч, Тооллогын комисс томилсон гэх мэт хурлын явцад гарсан шийдвэрүүд; - Хуралдааны тэмдэглэл; - Хуралдааны явцыг баримтжуулсан фото зураг, видео бичлэг байгаа эсэх;	
4	Шийдвэр гаргалт	Хурлын шийдвэр намын Дүрэмд заасны дагуу гарсан эсэх: • Асуудлыг олонхиор шийдвэрлэсэн эсэх; • Санал хураалт нууц, ил ямар хэлбэрээр явагдсан; • Санал хураалтын дүнг баталгаажуулсан эсэх /саналын хуудас, дүнгийн протокол/; • Цахимаар хийгдсэн тохиолдолд цахим баримтууд шаардлагатай.	

**УЛС ТӨРИЙН НАМЫН ДҮРЭМ, ХӨТӨЛБӨР
/ШАЛГАХ ХУУДАС - 2/**

д/д	Тусгах нийтлэг зүйл	Хуульд нийцсэн эсэхийг шалгах шалгуур Дараах асуудлыг Дүрэмд заана.	Зөрчил илэрсэн эсэх
УТНТХ-ийн 15.2. Намын Дүрэмд дараах нийтлэг зүйлийг тусгана.			
1	Намын зорилго, үзэл баримтлал, үнэт зүйл УТНТХ-15.2.1	Улс төрийн намын үйл ажиллагаанд хориглохоор хуульд заасан үйл ажиллагааг /10 дугаар зүйл/ зөвшөөрөх агуулга илэрхийлээгүй, Дүрэм, хөтөлбөрийн заалт нь ийм үр дагавар үүсгэхээргүй байх.	
2	Намын бүтэн болон товчилсон нэр, бэлгэ тэмдэг УТНТХ-15.2.2	- Нам нь оноосон нэртэй байх бөгөөд түүний төгсгөлд "нам" гэсэн ерөнхий нэрийг заавал хэрэглэнэ. (6.1) - Төрийн байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага, сүм хийд, өөр хуулийн этгээд, бусад намын нэр, бэлгэ тэмдэгтэй давхардсан буюу бусдыг төөрөгдүүлэхээр ижил, төсөөтэй байж болохгүй. (6.4) - Намын нэрийг бүтэн болон товчилсон байдлаар Дүрэмдээ заана. - Нэрийг олон янзаар бичихгүй, нэг мөр тусгана.	
3	Намын гишүүнээр элсэх УТНТХ-15.2.3	- Намын гишүүнээр элсэх шалгуур, үндэслэлийг заана.	
4	Намын гишүүний эрх, үүрэг УТНТХ-15.2.3	- Хуулийн 20.1, 20.2-т заасан нийтлэг эрх, үүргээс гадна Дүрмээр тусгайлан заах эрх, үүргийг нэрлэн зааж болно.	
5	Намын гишүүнээс түдгэлзэх УТНТХ-15.2.3	Намын Дүрэмд гишүүнээс түдгэлзүүлэхтэй холбоотой зохицуулалтыг тодорхой тусгана: - Намын гишүүнээс түдгэлзэх, түдгэлзүүлэх үндэслэл; - Хугацаатай эсэх; - Гишүүнчлэл сэргэх зохицуулалт; - Намын гишүүнээс түдгэлзүүлэхтэй холбоотой шийдвэр гаргах журам; - Шийдвэр гаргах эрхтэй этгээдийг тодорхой нэрлэн заана.	
6	Намын гишүүнээс хасах УТНТХ-15.2.3	Хуулийн 20.3, 20.4 -т намын гишүүнээс хасах үндэслэлийг тусгайлан заасан. Намын Дүрэмд: - "намын дүрмийг санаатай зөрчсөн" - "намын үнэт зүйл, зарчмыг ноцтой зөрчсөн" гэж үзэх үйлдэл, эс үйлдэхгүйг тодорхойлж заана.	
7	Бусад сахилгын шийтгэл ногдуулах УТНТХ-15.2.3	- Сахилгын шийтгэлийн төрөл, шийтгэл оногдуулах үндэслэлүүдийг заана. - Сахилгын шийтгэл оногдуулах хөөн хэлэлцэх болон сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа, үр дагавар зэргийг тодорхойлно.	
УТНТХ-ийн 16.1, 16.2. Намын бүтэц, зохион байгуулалт, удирдлагын тогтолцоо			
8	Улс төрийн намын дотоод зохион байгуулалт, үйл ажиллагааг ардчилсан зарчимд нийцүүлэх УТНТХ-ийн 8 дугаар зүйл.	Дараах нийтлэг шаардлагыг хангана: - Намын удирдах дээд байгууллага, төлөөллийн төв байгууллага, гүйцэтгэх төв байгууллага, хяналтын байгууллагыг байгуулахдаа: • Нууц санал хураалт явуулах; (8.2.1) • Гишүүдийн оролцоо, ил тод байдлыг хангах; (8.2.2) - Нэр дэвшүүлэхдээ аль нэг хүйсийн төлөөлөл 30 хувиас доошгүй байх; (8.2.3) шаардлагыг хангахаар заана. • Аливаа асуудлыг шийдвэрлэхдээ олонхоороо хэлэлцэн шийдвэрлэдэг байх; (8.3) - /Аливаа/ хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар асуудлыг шийдвэрлэх, цөөнхийн саналыг хэлэлцэх боломж олгосон байх. - Намын Дүрэм, хөтөлбөрийг батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах болон сонгуульд нэр дэвшигчийг санал болгоход намын гишүүдийн оролцоог хангаж, саналыг сонсох агуулгыг тусгасан байх. • Нам бодлого, үйл ажиллагаанд эмэгтэй, ахмад, залуу, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг нийгмийн сонирхлын бүлгүүдийн төлөөлөл, оролцоог хангах; (8.5) • Намын аливаа шийдвэр, үйл ажиллагаа нь хувь хүн болон нийгмийн бүлгийг аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхах агуулга, үр дагавар үүсгээгүй байх (8.6)	



9	Удирдах дээд байгууллагатай холбоотой Дүрмийн зохицуулалт УТНТХ-15.2.4, 17.1	Намын удирдах дээд байгууллага нь намын Их Хурал байна. /нэр нь өөр байж болно/ а/Хуралдах журам: - Ээлжит Их Хурал хуралдуулах хугацааг тодорхой заах. /Ж: "4 жил тутам 1 удаа", "4 жил тутам 2 удаа" гэх мэт/ - Ээлжит болон ээлжит бус Их Хурлыг зарлах эрхтэй этгээд; - Хурлын төлөөлөгчийг сонгох журам; • Нэр дэвшүүлэхдээ аль нэг хүйсийн төлөөлөл 30 хувиас доошгүй байх шаардлагыг хангасан эсэх - Хурлын тов мэдэгдэх журам; - Хурал хүчинтэйд тооцох ирц; - Хэлэлцэх асуудал тогтоох эрх хэмжээ; - Шийдвэр гаргах журам; • Санал хураалтын журам б/Намын Их Хурал УТНТХ-ийн 17.2-т нэрлэн зааснаас өөр бусад асуудал хэлэлцэн шийдвэрлэх эрх хэмжээтэй байх бол түүнийг нэрлэн заана. в/Их Хурлын онцгой бүрэн эрхэд хуулиар харьяалуулсан асуудлыг бусад бүтцийн байгууллага шийдвэрлэх эрхгүй – хуулийн шаардлагыг хангана. (17.2)	
10	Төлөөллийн төв байгууллагатай холбоотой Дүрмийн зохицуулалт УТНТХ-15.2.4, 17.3	Намын удирдах дээд байгууллагын чөлөө цагт ажиллах Төлөөллийн төв байгууллага - Их хурлаас Төлөөллийн төв байгууллагын бүрэлдэхүүнийг шууд сонгох эсхүл батламжлах аль нь болохыг заана. (17.2.2) - Бүрэлдэхүүний тоог тодорхой заана. (17.2.2) - Бүрэн эрхийн хугацаа нь "дөрвөн жил" эсхүл түүнээс бага хугацаатай эсэх - хэдэн жил байхыг заана. (17.2.2) - Гишүүдийг ямар журмаар нэр дэвшүүлэх /аль нэг хүйсийн төлөөлөл 30 хувиас доошгүй байх хуулийн шаардлагыг хангах/ (8.2.3) - Бүрэлдэхүүнд /аль нэг хүйсийн төлөөлөл 40 хувиас доошгүй байх хуулийн шаардлагыг хангах/ (17.7) - Гишүүний бүрэн эрхийн хугацаа, хугацаанаас өмнө өөрчлөгдөх, чөлөөлөгдөх, нөхөн сонгох зохицуулалтыг заана. - Нэг жилд хэдэн удаа хуралдахыг эсхүл тогтмол хуралдах хугацааг заана. (17.3) - Хурал зарлах, асуудал хэлэлцэх, шийдвэр гаргах журмыг тодорхойлно. - Хуулийн 19.4, 19.5-д заасан журмыг батлахтай холбоотой зохицуулалтыг тусгана.(19.6) - Дотоод аудиторыг 4 жилийн хугацаатай томилно: (37.7) • Хэн нэр дэвшүүлэх, хэрхэн хэлэлцэх, дахин эсхүл нөхөн томилох зэрэг асуудлыг Дүрэмд тусгана.	
11	Гүйцэтгэх төв байгууллагатай холбоотой Дүрмийн зохицуулалт УТНТХ-15.2.4, 17.5	Намын Гүйцэтгэх төв байгууллага - Намын Их Хурлаас, эсхүл Төлөөллийн төв байгууллага алинаас нь сонгож байгуулахыг тодорхой заана. (17.5) - Бүрэн эрхийг хугацааг тодорхой заана. Хэдэн жилийн хугацаагаар сонгох. /ж: "4 жил", "3 жил" гэх мэтээр заана/ (17.5) - 3-аас дээш хэдэн гишүүнтэй байх тоог тодорхой заана. (17.5) - Гишүүдийг ямар журмаар сонгох. /аль нэг хүйсийн төлөөлөл 40 хувиас доошгүй байх шаардлагыг хангах/ (17.7) • Нэр дэвшүүлэх, хэлэлцэх, санал хураалт явуулахтай холбоотой зохицуулалтыг тусгана. (8.2.3) - Гишүүд нь бүрэн эрхийн хугацаанаас өмнө чөлөөлөгдөх, огцрох, өөрчлөгдөх тохиолдолд дахин эсхүл нөхөн сонгох зохицуулалтыг заана. - Гүйцэтгэх төв байгууллагын шийдвэр гаргах журмыг Дүрэмд заана. - Гүйцэтгэх төв байгууллагаас санхүүгийн асуудал хариуцсан удирдах ажилтныг сонгох журмыг Дүрэмдээ тодорхой заана: (17.5) • Хэн нэр дэвшүүлэх, хэлэлцэх журам, шийдвэр гаргах зохицуулалтуудыг тодорхой заана.	
12	Хяналтын байгууллагатай холбоотой Дүрмийн зохицуулалт УТНТХ-15.2.4, 18 дугаар зүйл.	Намын Хяналтын байгууллага Их хурлаас Хяналтын байгууллагын бүрэлдэхүүнийг сонгох (17.2.2) бөгөөд дараах зохицуулалтуудыг Дүрэмд тусгана: - Хяналтын байгууллагыг Их Хурлаас сонгох журам: • Нэр дэвшүүлэх, хэлэлцэх, шийдвэр гаргах санал хураалт явуулах журмыг заана. (8.2.3, 17.7) • Гишүүд нь хугацаанаас өмнө өөрчлөгдөх тохиолдолд нөхөн сонгох зохицуулалтыг заана. - Бүрэлдэхүүний тоог тодорхой заана. (17.2.2) - Бүрэн эрхийн хугацааг тодорхой заана. (17.2.2) - Намын Хяналтын байгууллагын гишүүнээр намын Төлөөллийн байгууллага болон Гүйцэтгэх төв байгууллагын гишүүн, орон тооны ажилтныг сонгохыг хориглосон шаардлагыг хангана. (18.2) - Намын Хяналтын байгууллага хараат бусаар ажиллах бөгөөд түүний үйл ажиллагаанд хөндлөнгөөс нөлөөлөхийг хориглох хуулийн шаардлагыг хангана. (18.3) - Хяналтын байгууллагын "маргаан хянан шийдвэрлэх журам"-ыг хэн, ямар журмаар батлах талаар заана. (18.5)	

13	Намын салбар болон бүтцийн бусад нэгжтэй холбоотой Дүрмийн зохицуулалт УТНТХ-15.2.4, 15.2.10, 19 дүгээр зүйл.	а/Бодлогын судалгааны байгууллага байгуулахтай холбоотой зохицуулалтыг тусгана. - Намын Бодлогын судалгааны байгууллагыг хаанаас байгуулах, хэдэн хүний бүрэлдэхүүнтэй ажиллах, бүрэлдэхүүний тоо, хугацаа, эрх, үүрэг, ажиллах журмыг Дүрэмдээ тодорхой заана. - Намын Бодлогын судалгааны байгууллагын бүрэлдэхүүнийг ямар журмаар сонгож, томилохыг Дүрэмдээ тодорхой заана. б/Намын дэргэд бусад байгууллага байгуулах эсэхийг намын Дүрмээр өөрөө тодорхойлно. УИХ-ын сонгуульд нэр дэвшигчийг сонгох ажлыг зохион байгуулах хороо байгуулах тохиолдолд: (19.4) - Хорооны бүрэлдэхүүнд тавих шаардлага - Хороог байгуулах журам - Ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах журам - Үйл ажиллагааны журмыг Дүрэмд тодорхой заана. Салбар болон бүтцийн бусад нэгж байгуулах тохиолдолд, тэдгээрийг байгуулах болон татан буулгах үндэслэл, журмыг тодорхой тусгана. (15.2.10) - Ямар шаардлага хангасан тохиолдолд салбар нэгж байгуулагдсан гэж үзэх, гишүүнчлэл, бүртгэл, нутаг дэвсгэрийн харьяалал - Салбар нэгжийн даргыг сонгох, чөлөөлөх зэргийг тодорхой заана. УТНТХ-ийн 41.1-д заасан арга хэмжээг авахад хүргэсэн алдаа, зөрчлийг намын орон нутгийн нэгж гаргасан тохиолдолд хэрхэх талаар намын Дүрэмд заана. (41.3) УТНТХ-ийн 42.1-д заасан арга хэмжээг авахад хүргэсэн алдаа, зөрчлийг намын орон нутгийн салбар нэгж гаргах тохиолдолд хэрхэх зохицуулалтыг намын Дүрэмд заана. (42.4)	
14	Намын даргатай холбоотой Дүрмийн зохицуулалт УТНТХ-15.2.5	Намын дарга - Намын даргын бүрэн эрхийн хугацааг тодорхой заана. Ж: "3 жил", "4 жил" гэх мэт. - Бүрэн эрхийн хугацаа нь дуусгавар болсон тохиолдолд хэрхэх талаарх зохицуулалтуудыг тусгана. Намын даргын эрх хэмжээг тодорхой заана. - Намын дарга /санхүүгийн тайланд гарын үсэг зурах/-аас бусдаар намын санхүү, төсвийн үйл ажиллагаанд захиран зарцуулах эрхтэйгээр оролцохыг хориглоно. (37.11) - Намын дарга нь аль нэг аж ахуйн нэгж, байгууллагад санхүүтэй холбогдсон ажил, албан тушаал эрхлэхийг хориглоно (37.5) гэх хуулийн шаардлагуудыг хангана. Намын даргыг сонгохтой холбоотой журмыг тусгана. - Даргыг удирдах дээд байгууллага, эсхүл төлөөллийн төв байгууллага алинаас нь сонгох, батламжлах эсэхийг заана. (17.6) - Намын даргад нэр дэвшүүлэх эрх, болзол шаардлага; - Намын даргыг сонгох асуудал хэлэлцэх журам; - Санал хураалт явуулах журам; Намын даргыг чөлөөлөх, огцруулах процедурыг заана: - Санал гаргах; - Хэлэлцэх; - Шийдвэр гаргах журмыг тодорхой заана. Намын даргыг нөхөн эсхүл дахин сонгох журмыг тодорхой заана.	
15	Намын Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулахтай холбоотой Дүрмийн зохицуулалт УТНТХ-15.2.6	Намын Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах зохицуулалт: - Намын Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах санал гаргах эрхтэй этгээдийг, - Намын Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэх, шийдвэр гаргах эрхтэй этгээдийг тодорхойлно. - Намын Дүрмийг батлах бүрэн эрхийн хүрээнд түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах эрх нь Их Хурлын онцгой бүрэн эрхэд хадгалагдах зохицуулалтыг Дүрэмд тусгана. (17.2.1) - Намын Төлөөллийн төв байгууллага хуульд заасны дагуу намын дүрэмд өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх журмыг тодорхойлно: (17.4) • Хуульд заасан хязгаарлалтыг хангуулна. - Намын Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах ажиллагаа /процесс/-г тодорхойлох: • Санал гаргах, төсөл боловсруулах, хэлэлцэх үйл явц; • Төслийг хэлэлцэн батлах журам; • Нэмэлт, өөрчлөлт хүчин төгөлдөр болох зохицуулалт;	
16	Намыг өөрчлөн байгуулах, үйл ажиллагааг нь зогсоохтой холбоотой Дүрмийн зохицуулалт УТНТХ-15.2.7, 17.2, 17.2.3	Намыг өөрчлөн байгуулах, үйл ажиллагааг зогсоох шийдвэр гаргахтай холбоотой зохицуулалт: - Намыг өөрчлөн байгуулах, үйл ажиллагааг нь зогсоох шийдвэрийг намын Их хурал гаргах эрхтэй. - Энэ талаарх шийдвэр гаргах процессыг тодорхойлох: • Санал гаргах, хэлэлцэх, шийдвэр гаргах журмыг Дүрэмдээ тодорхой заана. • Намыг өөрчлөн байгуулсан, үйл ажиллагааг нь зогсоосон шийдвэр хүчин төгөлдөр болох, үүсэх үр дагаврыг журамлах.	



17	Жендэрийн тэгш байдлыг хангахтай холбоотой Дүрмийн зохицуулалт УТНТХ-15.2.8	Жендэрийн тэгш байдлыг хангах. Нэр дэвшигчийг сонгох, томилох, албан тушаалаас чөлөөлөх, тэдгээрт жендэрийн тэгш байдлыг хуульд нийцүүлэн хэрхэн хангах талаар заана.	
18	Намын хөрөнгө, орлогыг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнахтай холбоотой Дүрмийн зохицуулалт УТНТХ-15.2.9	Намын хөрөнгө, орлогын талаарх зохицуулалт: Орлого бүрдүүлэх. Орлого төвлөрүүлэхтэй холбоотойгоор хуулийн дараах шаардлагуудыг хангана: - Нам нь хуульд заасан орлогыг зөвхөн нэг банкны дансаар хүлээн авах бөгөөд өөр харилцах данстай байхыг хориглоно. (26.7) - Нам дээрх орлогыг цахим мөнгөөр хүлээн авахыг хориглоно. (26.8) - Хуулийн 34.6-д заасан хориглосон этгээдээс хандив, тусламж, санхүүжилт шууд болон шууд бусаар авахыг хориглоно. (10.1.5) - Сонгуульд нэр дэвших эрх олгохдоо намын гишүүн, дэмжигчээсээ барьцаа, дэнчин болон бусад аливаа хэлбэрээр мөнгө болон мөнгөн бус хөрөнгө, үйлчилгээ өгөхийг шаардах, авахыг хориглоно. (10.1.6) Гишүүний татварын талаар тодорхой заана: - Гишүүний татварын хэмжээг сар эсхүл жилээр тодорхой заана. "Нэг сарын татварын хэмжээ нь нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 5 хувиас хэтрэхгүй байх", "сонгуульт гишүүний сарын татварын хэмжээ нь нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс хэтрэхгүй байх" хуулийн шаардлагуудыг хангана. (32.2, 32.3) - Татварын хэмжээг хэн /намын аль байгууллага/ тогтоох, татварын бүртгэл хяналтыг хэн хариуцах, хугацаандаа татвараа төлөөгүй тохиолдолд авах арга хэмжээ гэх мэтчлэн татварын хэмжээ, бүрдүүлэхтэй холбоотой журмыг тодорхой тусгана. (32.1) - Татвараас хөнгөлөх, чөлөөлөх эсэх талаарх зохицуулалтыг тусгана. (32.6) Хэрэв татвараас хөнгөлөх, чөлөөлөх бол: • Татвараас хөнгөлөх, чөлөөлөх хувь хэмжээ, шалгуур, үндэслэлийг заах. Намын хөрөнгө орлогыг зарцуулах. Намын хөрөнгө орлогыг хуульд заасан үйл ажиллагаанд зарцуулах хувь хэмжээг тодорхой заана: (26.3) - Төрийн санхүүжилтийн 20-оос доошгүй хувийг эмэгтэй, ахмад, залуу, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг нийгмийн бүлгүүдийн улс төрийн оролцоог дэмжих, сургаж бэлтгэхэд зарцуулах; (26.3.1) - Төрийн санхүүжилтийн 15-аас доошгүй хувийг намын гишүүдийн болон иргэдийн улс төрийн боловсролыг дээшлүүлэх, ардчилал, хүний эрхийн үнэт зүйлийг нийтэд таниулахад зарцуулах; (26.3.2) - Төрийн санхүүжилтийн 15-аас доошгүй хувийг намын хөтөлбөр, бодлого боловсруулахад чиглэсэн судалгаа хийх, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, намын дотоод ардчиллыг хөгжүүлэхэд зарцуулах; (26.3.3) - Дээрх 3 зорилтот санхүүжилт тус бүрийн гуравны нэгээс доошгүй хувийг намын Бодлогын судалгааны байгууллагын үйл ажиллагаанд зарцуулах (26.4) - Дээрх хуулийн шаардлагуудыг тус тус хангуулна. - Энэ хуулийн 26.3-т заасан санхүүжилтийг тухайн зорилгоос өөр зориулалтаар зарцуулахыг хориглох (26.5) хуулийн шаардлагыг хангана. - Төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэгийг салбар болон бүтцийн нэгжид хуваарилахтай холбоотой асуудлыг тусгана: (27.13) • Санхүүгийн дэмжлэг хуваарилах, хуваарилахгүй байх шалгуур, нөхцөл; • Хувь хэмжээ; • Шийдвэр гаргах эрх хэмжээ, процесс.	

УЛС ТӨРИЙН НАМЫН САНХҮҮЖИЛТИЙН ИЛ ТОД БАЙДЛЫГ ХАНГАХ ЦАХИМ СИСТЕМИЙН ШААРДЛАГА, ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТЫГ БОЛОВСРУУЛЛАА

Сонгуулийн ерөнхий хорооны “Улс төрийн намын санхүүжилтийн ил тод байдлыг хангах цахим системийн тодорхойлолт боловсруулах” төсөл НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн “Хүний хөгжлийн төлөөх оролцооны арга замуудыг сайжруулах Оролцоо” төслийн сонгон шалгаруулалтад шалгарч, уг төслийн санхүүжилтээр цахим системийн шаардлага, техникийн тодорхойлолтыг боловсрууллаа. “Ухаалаг Засаглал” ТББ-ын Удирдах зөвлөлийн дарга, программ хангамжийн инженер Ц.Амарбаясгалан ахлагчтай хуульч, аудитор, нээлттэй өгөгдөл, системийн шинжээч зэрэг салбар, салбарын мэргэжилтнүүдээс бүрдсэн баг уг системийг хөгжүүлэхэд тавигдах шаардлага, техникийн тодорхойлолтыг боловсруулах гүйцэтгэгчээр ажилласан юм.

Цахим систем нь улс төрийн намын бүртгэл, үйл ажиллагааны товч тайлан, санхүүгийн тайлан, төрийн санхүүжилт, намын гишүүний татвар, үйл ажиллагаан дахь жендэрийн эрх тэгш байдлын тайлан, сонгуулийн оролцоо зэрэг модультай байхаар тодорхойлжээ. Түүнчлэн намын мэдээлэл, гишүүнчлэл, санхүүжилт, хөрөнгө, санхүүгийн тайлан, сонгуулийн оролцоо, жендэрийн төлөв байдал нь нээлттэй өгөгдөл хэлбэрээр системд байрших аж. Хэрэглэхэд хялбар дизайнтай байхаас гадна найдвартай, тасралтгүй, аюулгүй байдлыг хангах техникийн шаардлагыг ажлын даалгаварт тусгажээ.

Энэхүү системийг ашиглалтад оруулснаар улс төрийн намын санхүүжилт, түүнд тавих хяналтыг бүрэн хэрэгжүүлэх, намын үйл ажиллагааны болон санхүүгийн ил тод байдлыг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой юм




СИСТЕМНИЙ ИЖ БҮРДЭЛ




СИСТЕМНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ПРОЦЕСС




САНХҮҮГИЙН ТАЙЛАН







ТӨРИЙН САНХҮҮЖИЛТ




ТӨРӨӨС ҮЗҮҮЛЭХ ШУУД БУС ДЭМЖЛЭГ






ГИШҮҮНИЙ ТАТВАР




НАМЫН БҮРТГЭЛ



УЛС ТӨРИЙН
НАМСОНГУУЛИЙН
ЕРӨНХИЙ ХОРООУЛС ТӨРИЙН НАМЫН
СОНГУУЛИЙН ОРОЛЦОО

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТОВЧ ТАЙЛАН




ХҮҮЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ

UHH.MN
СУДАЛГААНЫ САН

ТӨРИЙН САНХҮҮЖИЛТ

ХАНДИВ БҮРТГЭЛ



ЕВРОПЫН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ БАЙГУУЛЛАГААС УЛС ТӨРИЙН НАМЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨГСӨН САНАЛ ЗӨВЛӨМЖ

Варшав хот. 2025 оны 4 дүгээр сарын 3.

Энэхүү санал зөвлөмжийг Засаглал, улс төрийн намын санхүүжилтийн асуудлаарх олон улсын шинжээч, Европын Аюулгүй Байдал, Хамтын Ажиллагааны байгууллагын Ардчилсан Институт, Хүний Эрхийн Газар (ЕАБХАБ/АИХЭГ)-ын улс төрийн намын Экспертүүдийн үндсэн багийн гишүүн хатагтай Барбара Жоао-Стонестритийн тайлбар дээр үндэслэн ЕАБХАБ/АИХЭГ-ын улс төрийн намын Экспертүүдийн үндсэн багийн гишүүн, харьцуулсан улс төр судлалын дэд профессор ноён Фернандо Касаль Бертоа, Экспертүүдийн үндсэн багийн гишүүн, улс төрийн шинжлэх ухаан, төрийн удирдлагын профессор ноён Омер Фарук Генчкая болон Жон Хопкинсийн Их Сургуулийн улс төрийн шинжлэх ухааны профессор, Экспертүүдийн үндсэн багийн тэргүүн профессор Ричард Кац нар тус тус саналыг хянасан болно.

I. ТАНИЛЦУУЛГА

1. 2025 оны 1 дүгээр сарын 29-ний өдөр Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хороо (цаашид СЕХ)-ы даргаас 2024 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс дагаж мөрдөж эхэлсэн Монгол Улсын Улс төрийн намын тухай хуульд дүн шинжилгээ гаргуулж, санал зөвлөмж боловсруулж өгөх хүсэлтийг ЕАБХАБ-ын Ардчилсан Институт Хүний Эрхийн Газарт (цаашид ЕАБХАБ/АИХЭГ) ирүүлсэн болно.
2. Хүсэлтийн хариуд АИХЭГ-аас ЕАБХАБ-ын хүний хэмжигдэхүүний үүрэг хариуцлага, олон улсын хүний эрхийн хэм хэмжээнд тус хуулийн нийцлийг үнэлж, санал зөвлөмж боловсруулж өгөхөд бэлэн байгаагаа 2025 оны 2 дугаар сарын 12-ны өдөр илэрхийлсэн болно.
3. Шинэчлэлийн ач холбогдлыг харгалзан АИХЭГ уг хууль нь олон улсын холбогдох стандарт, шилдэг туршлагад нийцэж байгаа эсэхэд урьдчилсан байдлаар дүн шинжилгээ хийж, эхний зөвлөмжийг боловсруулахаар шийдвэрлэсэн. Дотоодын нөхцөл байдал, тулгамдаж буй асуудлуудын талаар илүү сайн ойлголттой болохын тулд АИХЭГ нь урьдчилсан дүгнэлт, санал зөвлөмжийг холбогдох бүх талуудад танилцуулж, хэлэлцэх болно. Ийнхүү талуудаас цуглуулсан мэдээлэлд үндэслэн урьдчилсан дүгнэлтээс гарсан санал зөвлөмжийг эргэн харж, эцсийн дүгнэлтэд нарийвчлан тусгагдана.
4. Энэхүү хуулийн дүн шинжилгээг Монгол Улсын Улс төрийн намын тухай хуулийн төсөлд АИХЭГ/Венецийн Комисстой хамтран боловсруулан гаргасан санал зөвлөмж (2022) (цаашид "2022 Хамтарсан санал зөвлөмж" гэх) болон АИХЭГ-ын 2024 оны 6 дугаар сарын 28-ны Монгол Улсын Их Хурлын Сонгууль ажиглах хорооны тайлангийн хамт уншиж танилцана уу. (цаашид "2024 АИХЭГ-ын САХ-ны Эцсийн Тайлан" гэх).

5. Энэхүү Урьдчилсан санал зөвлөмжийг дээрх гаргасан хүсэлтийн дагуу бэлтгэсэн болно. АИХЭГ нь ЕАБХАБ-ын гишүүн орнуудад хүний хэмжигдэхүүний үүрэг хариуцлагаа хэрэгжүүлэхэд нь туслах чиг үүргийнхээ хүрээнд тус санал зөвлөмжийг гаргасан болно.

II. УРЬДЧИЛСАН САНАЛ ЗӨВЛӨМЖИЙН ЦАР ХҮРЭЭ

6. Энэхүү урьдчилсан санал зөвлөмжийн цар хүрээ нь зөвхөн дүн шинжилгээ хийлгэхээр ирүүлсэн хуулийн тайлбарыг тусгасан болно. Эдгээр хязгаарлалтын улмаас хамтарсан санал зөвлөмж нь Монгол Улс дах улс төрийн намуудын эрх зүйн зохицуулалт болон институцийн хүрээнд бүрэн, дэлгэрэнгүй тойм гаргаагүй болно.
7. Энэхүү урьдчилсан санал зөвлөмжүүд нь гол асуудлыг хөндөж, цаашид анхааран засаж залруулах шаардлагатай асуудлуудыг тодорхойлсон болно. Оновчтой бөгөөд тодорхой байх үүднээс бид дээрх хууль тогтоомжийн эерэг тал дээр биш харин өөрчлөлт, залруулга шаардсан заалтууд дээр төвлөрүүлсэн болно. Санал зөвлөмжийг ЕАБХАБ-ын хүний хэмжигдэхүүний үүрэг, хариуцлага, бусад олон улсын болон бүс нутгийн хэм хэмжээ, олон улсын сайн туршлага болон АИХЭГ Венецийн Комиссын Улс төрийн намын зохицуулалтын талаарх хамтарсан удирдамж дээр тулгуурлан гаргасан болно. Мөн АИХЭГ-ын сонгууль ажигласан тухай тайлангуудад өмнө нь гаргаж байсан зөвлөмжүүдээс тусгасан болно.
8. Урьдчилсан дүгнэлтэд, зохиох тохиолдолд, ЕАБХАБ-ын гишүүн бусад орнуудын шилдэг туршлагыг онцолсон болно. Үндэсний хууль тогтоомжийг дурдахад АИХЭГ нь аль нэг улс орны загварыг сурталчлахгүй болно, харин олон улсын холбогдох стандартуудын талаар

тодорхой мэдээлэл өгөх, тэдгээр нь үндэсний тодорхой хууль тогтоомжид практикт хэрхэн хэрэгжиж байгааг харуулахад анхаардаг. Аливаа улс орны жишээнд болгоомжтой хандах хэрэгтэй, учир нь үүнийг өөр улс оронд заавал давтагдах боломжгүй бөгөөд үндэсний институци, хууль эрх зүйн орчин, тухайн улсын нөхцөл байдал, улс төрийн соёлыг харгалзан үргэлж авч үзэх хэрэгтэй.

9. Түүнчлэн, Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай НҮБ-ын конвенц (цаашид "CEDAW"), 2004 оны ЕАБХАБ-ын Жендерийн тэгш байдлыг дэмжих Үйл ажиллагааны төлөвлөгөө болон ЕАБХАБ-ын үйл ажиллагаанд жендерийн асуудлыг эрхэмлэх чиг үүргийн хүрээнд, энэхүү Санал нь жендерийн болон олон талт байдлын хэтийн төлөвийг, зохих тохиолдолд, нэгтгэсэн болно.
10. Энэхүү Саналыг хуулийн англи хэл дээрх албан бус орчуулга дээр үндэслэсэн бөгөөд буруу орчуулгын үүднээс энэхүү саналд зөрүүтэй зүйл туссан байхыг үгүйсгэхгүй. Санал нь монгол хэл дээр орчуулагдсан хэдий ч англи хэл дээрх хувилбар нь албан ёсны бичиг баримтад тооцогдоно.
11. Дээрх шалтгааны улмаас АИХЭГ-ын зүгээс цаашид нэмэлтээр Монгол Улсын холбогдох хууль тогтоомж болон тухайн хууль тогтоомжид аман эсвэл бичгээр санал, зөвлөмж гаргах зэрэг үйл ажиллагаанд энэхүү Санал хязгаарлахгүй гэдгийг тэмдэглэв.

ТОВЧ ХУРААНГУЙ БА ҮНДСЭН ЗӨВЛӨМЖҮҮД

Монгол Улсын Улс төрийн намын тухай хууль /цаашид "Хууль" гэх/ нь улс төрийн намуудын үйл ажиллагаа, санхүүжилт зэрэгтэй холбоотой үүсэх харилцааг зохицуулах эрх зүйн цогц зохицуулалтыг ерөнхийдөө тогтоосон. Тус хууль нь улс төрийн намын гишүүнчлэл, намын бүртгэлд бүртгэх, татан буулгах, хандив болон төрийн санхүүжилт, тайлагнах шаардлага, хяналт, хориглох зүйлс зэргийг хамарсан бөгөөд улс төрийн намуудын дотоод, гадаад үйл явц дах жендерийн болон олон талт оролцоог дэмжсэн заалтууд багтаасан байна.

АИХЭГ болон Венецийн комиссоос гаргасан зарим зөвлөмж, тухайлбал 2022 оны Хамтарсан санал зөвлөмж болон 2019 оны АИХЭГ-ын санал дүгнэлтэд тусгагдсан хэд хэдэн зөвлөмжийг харгалзаж тусгасан заалтуудыг АИХЭГ зүгээс сайшааж байна. Эдгээрт, ялангуяа улс төрийн намыг бүртгэх үйл явцыг харьцангуй хялбаршуулсан, улс төрийн намын үйл ажиллагаанд хориглох зүйлс харьцангуй хумигдсан, улс төрийн намыг татан буулгах үндэслэлийг илүү хязгаарласан, төрийн санхүүжилт авахад тавигддаг шалгуур, босгыг зохицуулж, төрийн санхүүжилт авах шаардлага хангах босгыг 3 хувиас 1 хувь хүртэл бууруулж, жижиг эсвэл шинээр байгуулагдсан улс төрийн намуудад илүү тэгш болгосон зэрэг заалтууд орно.

Үүний зэрэгцээ эвлэлдэн нэгдэх эрх чөлөөг хангах, улс

төрийн намын санхүүжилтийн үр дүнтэй зохицуулалтыг алдагдуулж болзошгүй цоорхойг арилгах үүднээс хуулийн зарим хэсгийг цаашид боловсронгуй болгох шаардлага байна. Үүнд намын гишүүнээр элсэх, бүртгэхтэй холбоотой заалтуудыг эргэн харах, улс төрийн намуудад дотоод зохион байгуулалт, шийдвэр гаргахад бие даасан байдал олгох, нам татан буулгах журмыг хатуу хязгаарлах, санхүүжилтийн журам, механизмуудыг болон тайлагнах шаардлагуудыг эргэн харах зэрэг багтана. Тодруулбал, намыг идэвхгүйд тооцвол сонгуульд оролцохыг хориглосон заалт, түүнчлэн гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг улс төрийн намын гишүүн болгохыг хориглосон хязгаарлалт зэргийг эргэн харах нь зүйтэй.

Түүнчлэн төрийн санхүүжилтийн хуваарилалтыг эргэн харж, хуваарилахад тэгшитгэх томьёо, аргачлалд илүү анхаарч, тухайн улс төрийн намын авсан нийт саналын тоонд жин өгөх, харин авсан суудлын тоон дээр жин өгөх явдлыг буруулахыг зөвлөж байна. Цаашлаад зохицуулалтын журмуудад жендерийн төлөөллийн шалгуур босго тогтоох гэх мэт, болон дотоод ардчиллын хэм хэмжээний тэнцвэрийг хангах замаар намын дотоод ардчилал, зохион байгуулалтыг бэхжүүлэх үүднээс энэхүү хуулийн цар хүрээг өргөжүүлэх боломжтой.

Түүнчлэн уг хуульд тусгагдсан төрийн санхүүжилтийн механизмд жендерийн асуудлыг цаашид нэгтгэн тусгаж, улс төрийн амьдралд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх, дэмжих зорилгоор улс төрийн намуудад урамшууллын хөшүүргийг бий болгох, ингэснээр Үндсэн хуульд тусгагдсан эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн тэгш байдлын зарчмыг тусгах асуудлыг анхаарч үзэх хэрэгтэй. Жендерийн хамрах хүрээнээс хальж, бүх салбарт олон талт, тэгш төлөөллийг хангаж, залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс зэрэг нийгмийн сонирхлын бүлгүүдийн төлөөлөл, оролцоог нэмэгдүүлэх арга хэмжээг авч үзэх нь нэгэн адил чухал юм. Бүр тодруулбал, дээр дурдсанаас гадна тус хуулийн заалтуудыг олон улсын жишиг, сайн туршлагад нийцүүлэн бэхжүүлэх чиглэлээр АИХЭГ-аас дараах зөвлөмжийг гаргаж байна. Үүнд:

ЗӨВЛӨМЖ А. Улс төрийн нам үүсгэн байгуулах болон гишүүнчлэлийн тухайд:

1. Хуулийн 5.1-р зүйлд тусгасан улс төрийн нам байгуулахад, эвлэлдэн нэгдэхэд "сонгуулийн эрх бүхий иргэн" байх гэсэн заалтыг хасах, ерөнхийдөө Монгол Улсын хууль тогтоомжид тусгасан сонгууль өгөх эрхийг хязгаарласан зүйл заалтуудыг эргэн харах, арилгах Монгол Улсад хэн нэгнийг эрх зүйн чадамжгүй болгох тухай ойлголтыг бүхэлд нь дахин авч үзэх;
2. Улс төрийн намын гишүүн байх эрхийг өргөтгөж, хууль ёсны оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг хамруулах, харин "иргэн"/"Монгол Улсын иргэн" гэснийг "хувь хүн" буюу "хүн бүр" гэж сольж, гадаадын иргэн, харьяалалгүй хүн хүсвэл улс төрийн намын гишүүн болох боломжийг хангах;
3. "Төрийн жинхэнэ албан хаагч" гэсэн нэр томьёог тодорхой болгож, ямар төрийн албан хаагчийг намын

гишүүн байхыг хориглосон энэхүү заалтыг илүү тодорхой болгох эсвэл холбогдох бусад хуулийг нийцүүлэх нь зүйтэй. Ингэхдээ улс төрийн намын гишүүнчлэлд тавьсан аливаа хязгаарлалтыг хатуу үндэслэлтэй байлгах, тухайлбал дээрх төрийн албан хаагчдын улс төрийн төвийг сахих байдлыг хангах шаардлагатай.

ЗӨВЛӨМЖ В. Улс төрийн намыг намын бүртгэлд бүртгэх тухайд:

1. Хуулийн 11.4.2, 12.3.4 дүгээр зүйлд намын үүсгэн байгуулах хурлаар намын мөрийн хөтөлбөр батлах тухай заалтыг мөн улс төрийн намыг бүртгүүлэх өргөдөлд хавсаргах баримт бичгийн жагсаалтаас энэхүү заалтыг тус тус хасч, өөрчлөлт оруулах;
2. Намын бүртгэлийн өргөдлийг нягтлан шалгах хугацааг богиносгож, бүртгэлийн үйл ажиллагааг хялбаршуулах, шуурхай болгох үүднээс дахин авч үзэх;
3. Улсын Их Хурлын сонгуулийн өмнөх 90 хоногийн дотор улс төрийн намыг бүртгүүлэх хүсэлтээ Улсын дээд шүүхэд гаргахыг хориглоно гэсэн хуулийн 14.10 дугаар зүйлийг хасахыг бодолцох;

ЗӨВЛӨМЖ С. Улс төрийн намуудад намын бүтэц, дотоод зохион байгуулалт, шийдвэр гаргах үйл явцыг тодорхойлох бие даасан байдлыг хангах, ялангуяа шийдвэр гаргахад саналын доод хэмжээг тогтоосон заалтыг хасах замаар хуулийн 8, 15-19 дүгээр зүйлийг шинэчлэн найруулах.

ЗӨВЛӨМЖ D. Улс төрийн намыг татан буулгах тухайд:

1. Улс төрийн намыг татан буулгах тухай СЕХ-ны шийдвэрээс үл хамааран Улсын дээд шүүх нь тус хуулийн зүйл заалт болон холбогдох нотлох баримтуудыг хянан шийдвэрлэх бүрэн эрхтэйг тус хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид тус тус тусгах;
2. Намыг татан буулгах хамгийн сүүлчийн арга зам болох онцгой нөхцөл байдлыг илүү нарийвчилж, хууль ёсны байдал, дагалдах, пропорциональ байдлын хатуу стандартын дагуу томъёолох.

ЗӨВЛӨМЖ Е. Төрийн санхүүжилт авах шаардлага хангасан намд Улсын Их Хурлын сонгуулиар тухайн намын авсан саналын тоог үндэслэн санхүүжилтийн хуваарилалтын итгэлцүүрийн хэмжээг нэмэгдүүлэх, харин намын авсан суудлын тоонд үндэслэн, итгэлцүүрийн хэмжээг бууруулах зэрэг тэгш хуваарилалтын арга нэвтрүүлэхэд анхаарч, өнөөгийн төрийн санхүүжилтийн тогтолцоог эргэн харах;

ЗӨВЛӨМЖ F. Хандивын тухайд:

1. Банкны зээл олгох журам, тэр дундаа гуравдагч этгээдийн өр барагдуулах, зээлдүүлэгчид зээлийг өршөөх тухай заалтуудыг сэргээх;
2. Хуулийн 35.1-д заасныг өргөтгөж, намын сурталчилгааны материалыг зах зээлийн үнээс доогуур үнээр борлуулахыг зөвшөөрч түүнийг намд өгсөн хандивт тооцох;

ЗӨВЛӨМЖ G. Жендэр болон олон талт оролцооны тухайд:

1. Сонгуулийн сурталчилгааны үеэр нэр дэвшигчдийн нэрсийн жагсаалтад илүү олон эмэгтэй оруулсан улс төрийн намуудад төсвийн санхүүжилтээс нэмэлт санхүүжилт тогтмол хуваарилах зэрэг урамшууллын үр дүнтэй механизмыг хуульд тусгах асуудлыг авч үзэх, жендэрийн тэнцвэртэй байдлыг хангах, эмэгтэй нэр дэвшигчдийг намын жагсаалтад хэт доогуур оруулахгүй байх, эмэгтэй нэр дэвшигч нэрээ татвал оронд нь өөр эмэгтэй нэр дэвшигчийн нэрийг оруулах гэх мэт зэрэг дэвийн журам нэвтрүүлэх;
2. Намын бүтцэд болон төрийн албанд нэр дэвших эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн хууль тогтоомжийн шаардлагын хэрэгжилтийг хангах, тухайлбал төрийн санхүүжилт олгохоос татгалзах, хэмжээг нь багасгах гэх мэт хуулийн хариуцлага тооцохыг хуульд оруулахыг бодолцох;

ЗӨВЛӨМЖ H. Ил тод байдал, тайлан гаргах шаардлагын тухайд:

1. Тайлагнах, түүний дотор хандивтай холбоотой тайлан гаргах шаардлагыг хялбарчлах, оновчтой болгох, түүнчлэн улс төрийн намуудад тайлагнах ачааллыг бууруулах зорилгоор улс төрийн намуудад нэгдсэн, аудитлагдсан нэг тайлан гаргаж ирүүлэхийг үүрэг болгох;
2. Тайланг олон нийтэд мэдээлж, хэвлэн нийтлэхдээ хандивлагч иргэний хувийн хаягийг тайланд оруулахгүй байх;

ЗӨВЛӨМЖ I. Хяналт, хариуцлагын тухайд:

1. Сонгуулийн ерөнхий хороо, Төрийн аудитын газрын хамтын ажиллагааны механизм, тухайлбал, харилцан ойлголцлын санамж бичиг байгуулж, хамтран ажиллах механизмыг албажуулах замаар бүх улс төрийн намуудын санхүүгийн тайлангийн нийцтэй байдал, дүрэм журмыг нэгэн адил мөрдөж байгаа эсэхийг нягтлан шалгах замаар үр дүнтэй хамтын ажиллагааг хангах үүднээс хуулийг шинэчлэн найруулах;
2. Хуульд заасан бүх зөрчилд оногдуулах шийтгэлийг тодорхой зааж, зөрчлийн төрөл тус бүрд оногдуулах шийтгэлийг нарийвчлан тусгаж, улс төрийн намын санхүүжилттэй холбоотой зөрчилд оногдуулах шийтгэлийг пропорциональ, тууштай хэрэглэх нөхцөлийг бүрдүүлэх;

Эдгээр болон бусад нэмэлт зөвлөмжүүдийг тод үсгээр бичиж, энэхүү санал зөвлөмжид оруулж тусгасан болно.

ЕАБХАБ-ын гишүүн орнуудад хүний хэмжигдэхүүний үүрэг хариуцлагаа хэрэгжүүлэхэд нь туслах чиг үүргийнхээ хүрээнд АИХЭГ нь гишүүн орны хүсэлтийн дагуу хуулийн төслүүд болон одоо мөрдөж буй хууль тогтоомж нь олон улсын хүний эрхийн стандарт, ЕАБХАБ-ын үзэл бодолд нийцлийг үнэлж, улмаар сайжруулах талаар тодорхой зөвлөмж өгдөг.

СОНГОГЧИЙН БОЛОВСРОЛ, ЗАН ТӨЛӨВИЙН СУДАЛГАА

Сонгуулийн ерөнхий хорооны Мэдээлэл, судалгаа, сургалтын төв

Ардчиллыг бэхжүүлэх, түгээн дэлгэрүүлэх, хөгжүүлэх гол хүчин зүйлийн нэг бол чөлөөт, шударга сонгууль юм.¹ Үндсэн хуульт ардчиллыг чөлөөт, шударга сонгуульгүйгээр төсөөлөх боломжгүй. Хууль тогтоох эрх мэдлийг хэрэгжүүлэгч парламентыг чөлөөт, шударга, ардчилсан сонгуулийн үндсэн дээр ард түмэн өөрсдийн итгэл үнэмшил, хараат бус, чөлөөт сонголтоороо байгуулах нь Үндсэн хуульт ардчилал оршин байгаа эсэхийг тодорхойлох нэгэн гол хүчин зүйл юм.² Ард түмний сонгосон хүмүүс хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг учраас эдгээр эрх мэдлийг хэрэгжүүлэх бүрэн эрх ардчилсан сонгуулийн дүнгээр улс төрийн нам, эвслийн хооронд шилждэг.³

Нөгөө талаар хууль тогтоох эрх мэдлийг хэрэгжүүлэгчдэд шударгаар хариуцлага тооцох, хяналттай байлгах үндсэн аргын нэг бол чөлөөт, шударга сонгууль юм. Үүнийг улс төрийн хариуцлага тооцох үндсэн механизм ч гэж үзэх нь бий. Сонгууль бол хэнд төрийн эрх мэдлийг итгэмжлэн шилжүүлэхийг шийдэх ардчилсан арга бөгөөд сонгогдсон, томилогдсон албан тушаалтанд итгэл үзүүлэх эсхүл хариуцлага тооцох хяналтын тогтолцоо юм.⁴

Сонгуулийн төв байгууллага нь зөвхөн сонгууль зохион байгуулах бус сонгууль шударга, ил тод явагдах, сонгуулийн үйл явц, сонгогчийн эрх, үүрэг, ардчилсан засаглалд оролцохын ач холбогдлын талаар иргэдэд мэдээлэл өгөх, соён гэгээрүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх бодлогыг тодорхойлох чиг үүрэгтэй юм.

Монгол Улсад ардчиллын үнэт зүйлсийг бэхжүүлэх, төрийн үйл ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх,

хариуцлагатай иргэн төлөвшүүлэх үйл хэрэгт сонгогчийн боловсрол чухал байр суурь эзэлдэг. Анхны ардчилсан сонгуулиар (1992 болон 2024 он) 90 гаруй хувьтай байсан ирц сүүлийн сонгуулиудын хугацаанд 95-69 хувь болж буурсан байдаг.

Иргэдийг сонгуульд мэдээлэлтэй, идэвхтэй оролцохыг дэмжих, сонгуулийн боловсрол олгох чиглэлээр дэмжсэн бодлогыг тодорхойлох зорилгоор сонгогчдын сонгуулийн боловсролын суурь түвшин, сонгууль зохион байгуулах үйл ажиллагаанд хандах хандлага, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох зорилгоор хийгдсэн энэхүү судалгаа нь чухал анхдагч мэдээлэл, нотолгоо болох ач холбогдолтой юм. Судалгаанд оролцсон иргэдийн хандлага, үнэт зүйл, ойлголт, мэдээлэл хүлээн авах орчныг тодорхойлох замаар сонгогчдын боловсролын бодлого боловсруулахад тулгуур болохуйц мэдлэг, дүгнэлтийг гаргахыг зорьсон.

Сонгуулийн ерөнхий хороо нь судалгааны үр дүнд тулгуурлан сонгогчийн боловсролыг дэмжих үндэсний хөтөлбөр, бусад арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Мөн төрийн байгууллагууд, судлаачид, боловсролын байгууллагууд болон иргэний нийгмийн байгууллагуудын үйл ажиллагаанд нотолгоонд суурилсан судалгааны эх сурвалж болон ашиглагдах боломжтой.

Энэхүү судалгааг Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хороо санаачлан, аймаг, дүүргийн Засаг даргын Тамгын газруудтай хамтран өгөгдөл, мэдээлэл цуглуулалтын ажлыг зохион байгууллаа. Судалгаанд 21 аймаг, 9 дүүргийн нийт 11,700 иргэн хамрагдсан.

Судалгаа авах ажлыг удирдан зохион байгуулсан аймаг, дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга, өгөгдөл, мэдээлэл цуглуулсан албан хаагчид, судалгаанд хамрагдсан олон мянган иргэн, судалгааны боловсруулалт, шинжилгээг хийсэн баг хамт олонд гүн талархал илэрхийлбэ.

1 Civic Academy South Africa. Cultivating democracy through civic education. <https://civicsacademy.co.za/what-are-free-and-fair-elections/>

2 Д.Бат-Эрдэнэ "Үндсэн хуульт ардчиллыг хамгаалах чиг үүрэг" 2024 он


3 Мөнхсайхан, О. (2023). Үндсэн хуульт ардчиллын төлөө 2013-2023, ярилцлага, нийтлэл. УБ, 198 дугаар тал

4 ХБНГУ-н Конрад Аденауэр сан. (2016). "Иргэн таны оролцоо ардчиллын баталгаа", УБ., 31 дүгээр тал






Инфографик тоон үзүүлэлтүүд:

2025 оны нийт сонгогчийн тоо



Боловсролын түвшин ба улс төрийн оролцооны ойлголт

Боловсрол	Мэдэхгүй	Муу	Дунд	Сайн	Нийт
Боловсролгүй	5	9	16	9	39
Бага	19	9	88	89	205
Бүрэн дунд	206	90	1079	1829	3204
Дээд	236	95	1768	6153	8252
Нийт	466	203	2951	8080	11700



Нас ба Мэдээлэл авах хэлбэр

Насны бүлэг	Бүгд	Олон нийтийн сүлжээ	Сонгуулийн хороо	Сонин, сэтгүүл	Телевиз, радио	Төрийн байгууллага	Цахим сайт	Нийт
18-19	59	18	8	24	12	0	51	172
20-24	1	216	76	30	56	25	177	582
25-29	1	590	246	69	181	82	491	1660
30-34	2	606	376	60	261	98	558	1963
35-39	2	717	465	66	336	121	541	2249
40-44	1	468	354	47	294	88	395	1648
45-49	0	328	280	47	253	71	226	1205
50-54	1	213	329	32	248	64	169	1056
55-59	1	108	150	25	170	47	82	583
60-64	0	46	77	9	90	26	37	285
65+	0	19	59	10	78	8	15	188
Нийт	10	3370	2430	403	1991	642	2742	11591

Нас ба сонгох эрхийн талаарх мэдлэг

Нас/Үнэлгээ	Дунд	Муу	Сайн	Нийт
18-19	87	14	76	177
20-24	222	21	344	587
25-29	529	41	1105	1675
30-34	561	23	1393	1977
35-39	569	34	1665	2268
40-44	376	38	1249	1663
45-49	301	20	896	1217
50-54	247	15	804	1066
55-59	93	3	494	590
60-64	51	3	235	289
65+	37	2	152	191

Боловсрол ба сонгуульд оролцсон эсэх

Боловсрол	2 сонгуульд оролцсон	Зөвхөн орон нутгийн	Зөвхөн УИХ	Оролцоогүй	Нийт
Боловсролгүй	25	7	2	5	39
Бага	174	17	7	7	205
Бүрэн дунд	2617	246	142	199	3204
Дээд	7226	358	388	280	8252
Нийт	10042	628	539	491	11700

Санал өгсөн байдал ба мэдээллийн хүртээмжийн үнэлгээ

Санал өгсөн байдал	Дунд	Маш муу	Маш сайн	Муу	Сайн	Нийт
2 сонгуульд оролцсон	3001	79	1989	316	4657	10042
Зөвхөн орон нутгийн	272	12	83	29	232	628
Зөвхөн УИХ	205	15	63	31	225	539
Оролцоогүй	239	12	37	55	148	491
Нийт	3717	118	2172	431	5262	11700

"Оролцдоггүй, мэдээлэл хязгаарлагдмал" бүлгийн гол үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Тоо	Хувь (%)
Мэдлэгээ 1-3 оноогоор үнэлсэн	901	7.7%
Аль ч сонгуульд оролцоогүй	491	4.2%
"Муу" эсвэл "маш муу" гэж мэдээллийн хүртээмжийг үнэлсэн	549	4.7%
Сонгох эрхээ "муу" мэддэг гэж хариулсан	214	1.8%
Санал өгснөөр төрийн үйл хэрэгт оролцдог гэдгээ "муу" мэддэг	203	1.7%

БАРИМТААР БАТАЛГААЖУУЛ: ИРГЭДИЙН МЭДЭЭЛЛИЙН ДАРХЛАА БА ХАРИУЦЛАГАТАЙ СОНГУУЛИЙН ОРОЛЦОО

Мэдээлэл, судалгаа, сургалтын төвийн ахлах мэргэжилтэн **С.Мэргэн**

Цахим мэдээллийн эрин үе нь хүн бүрийг мэдээллийн экосистемийн нэг эд эс болгож байна. Олон нийтийн сүлжээгээр тархаж буй мэдээллийн урсгал нь зарим тохиолдолд үнэн бодит байдлаас хазайж, бидний амьдралын өдөр тутмын шийдвэр гаргалт, тэр дундаа улс төрийн оролцоо, шийдвэр гаргалтад цаашлаад сонгуулийн шударга байдалд шууд болон шууд бусаар сөргөөр нөлөөлөх эрсдэлийг нэмэгдүүлдэг.

Энэ оны байдлаар манай улсад 2.9 сая орчим интернэт хэрэглэгч, 2.6 сая орчим идэвхтэй сошиал медиа хэрэглэгч, 4.92 сая идэвхтэй үүрэн холбооны холболт байгаа нь цахим орчны нөлөөллийн цар хүрээг илэрхийлнэ (Digital 2025: Mongolia). Энэхүү өсөлт нь мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлж байгаа ч, бодит бус, хуурамч мэдээлэл тархах эрсдэлийг нэмэгдүүлж, иргэдийн мэдээллийн дархлааг сайжруулах шаардлагыг улам бүр тодотгож байна.

Мэдээллийн экосистемийн эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлэхэд хувь нэмрээ оруулах, сонгогчдын мэдээллийн дархлааг нэмэгдүүлэхээр Сонгуулийн ерөнхий хорооны Мэдээлэл, судалгаа, сургалтын төв 2025 оны нэгдүгээр улирлаас “Баримтаар баталгаажуул” нөлөөллийн аяныг хэрэгжүүлж байна. Аяны зорилго нь иргэдийн мэдээллийг нягтлах, баримт шалгах чадварыг нэмэгдүүлэх, сонгуулийн үеийн худал мэдээлэл, далд сурталчилгаанд автахгүй байх хандлагыг төлөвшүүлэх, цахим аюулгүй байдлын зөв дадлыг олон нийтэд түгээх юм. Энэхүү санаачилга нь зөвхөн мэдээлэл түгээх кампанит ажил бус, иргэн бүрийг мэдээллийн эрүүл орчинд идэвхтэй оролцогч болгох урт хугацааны стратеги юм.

“Баримтаар баталгаажуул” аян долоо хоног бүр цахим орчинд цуврал постер, инфографик түгээж, deepfake технологи, фото мэдээллийн эх сурвалж шалгах арга, clickbait мэдээлэл, хуурамч статистик, domain хаягийн шалгалт зэрэг сэдвийг хамарч, иргэдэд мэдээллийг үнэлэх, шалгах дадлыг өдөр тутмын амьдралд хэрэглэх



боломжийг олгох зорилготойгоор үргэлжилж байна. Мөн төрийн болон төрийн бус байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллага, болон иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллах орчныг бүрдүүлэхээр хэд хэдэн уулзалт, хурлуудыг зохион байгууллаа. Тухайлбал, ЮНЕСКО-ийн Монголын Үндэсний комиссын төлөөлөлтэй уулзалт зохион байгуулан Сонгуулийн ерөнхий хорооноос хэрэгжүүлж буй “Баримтаар баталгаажуул” нөлөөллийн ажлын төслийг танилцуулах, дээрх төслийн хүрээнд цаашид хэрэгжүүлж болох хамтын ажиллагааны саналуудыг талууд тодорхойлов. Энэхүү хамтын ажиллагааны санаачилгын үр дүнд бидний хэрэгжүүлж буй нөлөөллийн ажил, аяны үйл явц, арга хэмжээг илүү боловсронгуй, олон талт үр нөлөө бүхий болгох давуу талтай.

Энэхүү аян нь зөвхөн мэдээллийн кампанит ажил төдийгүй иргэдийг мэдээллийн үнэн бодит байдалд тулгуурлан шийдвэр гаргах чадвартай болгож, сонгуулийн шударга, ил тод орчныг бүрдүүлэх урт хугацааны төсөл юм. Цаашдаа энэхүү төсөл нь контент, постерыг өргөжүүлж, бүх насны иргэдэд хүргэх, ЮНЕСКО-ийн дэмжлэгийг нэгтгэн мэдээллийн боловсролын тогтвортой систем бий болгох, сонгуулийн өмнөх болон дараах үеийн хуурамч мэдээллийг таслан зогсоох урт хугацааны стратегийг хэрэгжүүлэх зорилготой. Энэ нь зөвхөн нэг удаагийн аяны үр дүн бус, олон нийтэд баримтад тулгуурласан шийдвэр гаргах, хариуцлагатай сонгогчийг төлөвшүүлэх урт хугацааны арга хэмжээ юм.

Цуврал 9



DEEPFAKE гэж юу вэ?

Хиймэл оюун ухаан ашиглан хуурамч видео, дуу хоолой, дүр бүтээдэг технологи юм.

Яагаад аюултай вэ?

- Худал мэдээлэл тараах
- Нэр хүндэд халдах
- Олон нийтийг төөрөгдүүлэхэд ашиглагддаг.

Таних арга:

- Хөдөлгөөн хийх үеийн дүрсний алдагдал
- Нүд анивчихгүй байх, удаан анивчих
- Яриа, амны хайрцаг зөрөх, тохиромжгүй харагдах
- Эх сурвалжгүй, гэнэт анхаарал татсан видео



Deepfake видеог hivemoderation.com - оор шалгаарай

Deeplearning - Гүнзгий сургагдсан AI + Fake- хуурамч дүрс, видео



Өнөөдөр:

Олон улсын баримт шалгах өдөр тохиож байна.

Энэ өдрийг 2017 онд **Олон улсын баримт шалгагчдын сүлжээ** буюу International Fact-Checking Network санаачилж

- Худал мэдээлэлтэй тэмцэх
- Баримт шалгалтын ач холбогдлыг таниулах зорилготойгоор тэмдэглэж эхэлжээ.



'Digital 2024: Global Overview Report' тайлангаас

Хэрэглэгчдийн интернет хэрэглэх шалтгаан.

61%

Мэдээлэл хайх зорилгоор ашигладаг бөгөөд энэ нь хамгийн түгээмэл шалтгаан гэж гарсан.

Та мэдээллийн эх сурвалж, баримтыг шалгаж, үнэн, худал эсэхийг нягталдаг уу?



Баримт шалгахын ач холбогдол

Баримт шалгах нь нийгэмд үнэн зөв мэдээллийг түгээх, хуурамч мэдээ, төөрөгдлийг бууруулахад чухал үүрэгтэй.

- Үнэн, зөв мэдээлэл түгээх
- Олон нийтийн бодит ойлголтыг нэмэгдүүлэх
- Хуурамч мэдээллийн тархалтыг зогсоох
- Иргэдийн мэдээлэлтэй оролцоог дэмжих
- Хариуцлагатай сэтгүүл зүйг хөгжүүлэх
- Олон нийтийн аюулгүй байдал, тогтвортой байдалд эерэг нөлөө үзүүлэх



International Fact-checking day





БОТ гэж юу вэ?

Бот (робот) - Автоматжуулсан програм хангамж
Тодорхой үүргийг хүний оролцоогүйгээр гүйцэтгэдэг.

Зарим төрөл:

- Чатбот - Хэрэглэгчтэй ярих, асуултанд хариулах
- Вэб бот - Вэб сайтын мэдээллийг цуглуулах
- Сошиал бот - Пост нийтлэх, дагагчдыг удирдах, сэтгэгдэл бичих, хандалт өгөх г.м

Fast checking!

Буруу ойлголт

Бот - Хуурамч мэдээлэл тараагч

✓

Бот бүр хор хөнөөлтэй биш
Бот нь хүний мэхэний үйл ажиллагааг хөгөөчлөх, цаг хугацаа хэмнэх давуу талтай.

⚠

ГЭХДЭЭ сошиал ботыг ашиглан хуурамч мэдээллийг хурдтайгаар, өргөн цар хүрээнд түгээх, зориудаар хуурамч мэдээлэл хийх санхээтэй үйлдлүүд олон байдаг.

Бот биш, бодит эх сурвалжинд итгэ!

Цуврал 10

БОТЫГ ХЭРХЭН ТАНИХ ВЭ?

- Хаяг бодит уу?**
Нүүр зурга, нэр, нийтлэсэн постууд, хувиусийн хариу үйлдлүүдийг нягтлах.
- Давтагдсан пост?**
Нэг төрөл, агуулгын мэдээллийг маш олон тоогоор нийтэлж хуваалцаж байна уу гэдгийг шалгах.
- Хэл зүйн хувьд?**
Харилцаа, бизнесийн хувьд үг үсгийн алдаатай, найруулгагүй эсвэл хэт албан ёсны байна уу гэдгийг анзаараарай.





ЗӨРЧИЛТЭЙ ХАЯГ, ВЭБ ХУУДАС УСТГАХ АРГА

- ✗ Цахим заалсан
- ✗ Худал мэдээлэл тараах
- ✗ Хуурамч фэйсбүүк хаяг


Таны эргэн тойронд ямар нэгэн хуурамч аккаунт, вэб хуудас байгаа юм санагдаж байна уу?

Тэгвэл хуурамч хаяг, вэб хуудсыг хэрхэн цагцлэх аргыг хэлж өгье!









E-Mongolia апп-руу нэвтэрч ороод **ҮЙЛЧИЛГЭЭ ХАЙХ** цэсээс "ЗӨРЧИЛТЭЙ ВЭБ ХУУДАС ХААЛГАХ ХҮСЭЛТ" гэж хайж орно.








ҮЙЛЧИЛГЭЭ АВАХ товч дээр дарна

Зөрчлийн линкийг хуулаад, зөрчлийн төрлийг сонгоод, тайлбар бичин баримтаа хавсаргаад **ҮРГЭЛЖЛҮҮЛЭХ ТОВЧ**-г дарна.



Ингээд таны асуудал ажлын 5 хоногт шийдэгдэх болно.

Зөрчилтэй аккаунт, вэб хуудаснуудад баяртай гэж хэлээрэй.





“СОНГУУЛЬ-2024” ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ИЛТГЭЛ

Сонгуулийн ерөнхий хороо Хууль зүйн үндэсний хүрээлэн, “Легал дата” ХХК, “Тунгаахуй” өгөгдлийн урлантай хамтран их, дээд сургуулийн оюутан, судлаач, мэргэжлийн албан хаагчдын дунд “Сонгууль-2024” эрдэм шинжилгээний уралдааныг 2024 оны 12 дугаар сард зарлаж, дүгнэсэн.

Уралдаанд эхний гурван байрт шалгарсан илтгэлийг “Сонгуулийн боловсрол” онол, арга зүйн сэтгүүлд нийтэлж байна.

Гутгаар байрт шалгарсан илтгэлийг уншигч Танд хүргэе.



СОНГУУЛИЙН ПРОЦЕССЫН ТУЛГАМДСАН АСУУДАЛ- СОНГУУЛИЙН ИРЦИЙГ НЭМЭГДҮҮЛЭХЭД ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ НЬ



Судлаач Г.Анхзаяа
МУИС-ийн Хууль зүйн сургуулийн
4 дүгээр түвшний оюутан



Судлаач Б.Өсөхбаяр
МУИС-ийн Хууль зүйн сургуулийн
4 дүгээр түвшний оюутан

I. УДИРТГАЛЫН ОРОНД ЗОРИЛГО

Хүний эрх, эрх чөлөөг дээдэлдэг ардчилсан засаглалтай улсуудад сонгуулийг маш өндөр ач холбогдолтойгоор авч үздэг. Ийнхүү өндөр ач холбогдол өгөх нь ч зүй ёсны асуудал юм. Учир нь аль ч ардчилсан улсын ард түмэн сонгуулиар дамжуулан өөрсдийн сонгосон төлөөллийн байгууллагаараа улс орноо удирдан, төвхнүүлж байдаг. Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Ардын багш, гавьяат хуульч Б.Чимид сонгуулийг орхигдуулж болдоггүй хоёр шалтгаан бий гээд эдгээрийг: (1) сонгууль бол нэг хүний дарангуйллын эсрэг ард түмний засаг буюу тэдний төлөөлөгчдийн хамтын засаг тогтоохын тулд гарч ирсэн, (2) ард түмэн засгаа гартаа авч, түүнийгээ төлөөлөх байгууллагаараа уламжлан хэрэгжүүлэх зайлшгүй хэрэгцээнээс шууд урган гарсан гэж тодорхойлжээ.¹ Иймд сонгуулийн эрх зүйн зохицуулалтыг цаг үетэйгээ уялдуулан боловсронгуй болгох шаардлага Монгол Улсын хувьд тулгарч байгаа асуудал мөн билээ.

Монгол Улс 1992 онд шинэ Үндсэн хуулиа баталснаас хойш иргэд өөрсдийн төлөөллийн байгууллагаа сонгох

сонгууль нийтдээ 9 удаа зохион байгуулагдаж байна. 9 удаагийн сонгуулийн ирцийг авч үзвэл 1992 оны сонгуулийн ирц 95.6%, 1996 оны ирц 92.1%, 2000 оны ирц 82.4%, 2004 оны ирц 82.2%, 2008 оны ирц 76.5%, 2012 оны ирц 67.3%, 2016 оны ирц 73.6%, 2020 оны ирц 73%, 2024 оны 69.4%-д хүрсэн байна. Жил ирэх тусам сонгуулийн ирц буурсан бөгөөд саяхан болсон 2024 оны УИХ-ын сонгуулийн ирц хамгийн бага байгааг харж болно. Орон нутгийн сонгууль болон ерөнхийлөгчийн сонгуулийн хувьд ч сонгуулийн ирц буурсаар байгаа. Сонгуулийн ирцэд нийгэм, эдийн засгийн, улс төрийн, тогтолцооны, хувь хүний гээд олон хүчин зүйлс нөлөөлдөг.² Нийгэм, эдийн засаг, улс төр, хувь хүний зэрэг хүчин зүйлсийг сайжруулахад бодлогын түвшний арга хэмжээг улсын хэмжээнд авах шаардлага гарах бөгөөд эдгээр нь үр дүнтэй байх эсэхэд мөн эргэлзээтэй. Харин богино хугацаанд, үр дүнтэйгээр сонгуулийн ирцэд нөлөөлж болохуйц хүчин зүйл нь тогтолцооны хүчин зүйл байдаг. Тогтолцооны хүчин зүйлд (пропорциональ, мажоритар, холимог зэрэг) сонгуулийн тогтолцоо, санал хураан авах өдөр, зохион байгуулалт зэрэг зүйлс багтдаг. Энэхүү

¹ Б.Чимид, Сонгуульд суралцахуй (УБ; “ADMON” ХХК, 2008), 22.

² Н.Мягмарцогж, “Залуу сонгогчдын ирц, түүнд нөлөөлөгч хүчин зүйлс”, Ikon.mn, 2024 оны 12 сарын 06-нд үзсэн, <https://ikon.mn/n/29fk>.

илтгэлийнхээ хүрээнд бусад улсуудын туршлагыг судлан Монгол Улсын эрх зүйн орчныг илүү боловсронгуй болгох тал дээр санал гаргахыг зорилоо.

Илтгэлийн сэдвийн хүрээнд сонгуулийн процессын эрх зүй гэдгийг сонгуулийн хууль тогтоомж хэрэгжиж буй үйл явцыг бүхэлд нь ойлгож, энэхүү илтгэлийн сэдвээ сонгосон болно. Сонгосон сэдвийн хүрээнд сонгогчдын хувьд ач холбогдолтой зохион байгуулалтын хэлбэрүүд буюу санал авах хугацаа, сонгуулийн сурталчилгааны хугацаа, санал өгөх хэлбэр болон бусад (өвөрмөц) онцгой зохион байгуулалтын хэлбэрийг судална.

II. МОНГОЛ УЛСЫН СОНГУУЛИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Монгол Улсын УИХ-ын сонгуулийн ерөнхий зохион байгуулалтыг харахад Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль (цаашид "УИХСтХ")-д хуульчилснаар санал авах өдөр нь 06 дугаар сарын сүүлийн хагасын ажлын аль нэг өдөр байгаа бөгөөд зөвхөн тухайн өдөртөө сонгогчдын саналыг авдаг.³ Нэр дэвшигчдийн сонгуулийн сурталчилгааг санал авах өдрөөс 18 хоногийн өмнө эхлүүлж санал авах өдрийн өмнө өдөр зогсооно.⁴ Сурталчилгаа хийх боломжит 2 долоо хоногийн хугацаа л байгаа гэсэн үг. Сонгуулийн сурталчилгааг материал тараах, нийтийн эзэмшлийн гудамж, талбайд зурагт самбар, намын туг, далбааг байрлуулах, сонгогчидтой уулзалт, хурал, цуглаан хийх, ухуулах байр ажиллуулах, радио, телевизийн сурталчилгааны нэвтрүүлэг ашиглах, цахим орчин ашиглах, сонин сэтгүүлд сурталчилгаагаа хэвлүүлэх гэсэн хэлбэрүүдээр явуулж байна.⁵ Сонгогчид саналаа заавал өөрийн биеэр санал авах байранд очиж өгдөг.⁶

Сонгогчдод ач холбогдолтой зохион байгуулалтын ерөнхий дүр зураг иймэрхүү гарч ирж байна. Энэхүү хэсэгт уг зохион байгуулалтад ямар нэгэн тайлбар, дүгнэлт өгөхгүй бөгөөд дараагийн хэсгүүдэд авч үзэх болно.

III. БУСАД УЛСЫН СОНГУУЛИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

1. Холбооны Бүгд Найрамдах Герман улс

(Сонгуулийн ажиллагааг Бундестагийн сонгуулийн жишээн дээр авч үзье)

Хуульд зааснаар 18 насанд хүрсэн, ХБНГУ-ын нутаг дэвсгэрт гурван сараас доошгүй амьдарсан бүх германчууд

сонгуульд саналаа өгөх эрхтэй. Хилийн чанадад албан томилолтоор явсан хүмүүс, тэдгээрийн гэр бүлийн гишүүд, Европын холбооны гишүүн орнуудын нутаг дэвсгэр дээр амьдарч буй хүмүүс, өөр улсад байнга оршин сууж буй хүмүүс, гадаадын хөлөг онгоцны гишүүд мөн сонгох эрх эдэлнэ. Европын холбооны гишүүн орны иргэд орон нутгийн сонгуульд саналаа өгөх эрхтэй байдаг. Харин бусдын байнгын асрамжинд байгаа, шүүхийн шийдвэрээр сонгох, сонгогдох эрхээ хасуулсан этгээд, шүүхийн шийдвэрээр сэтгэл мэдрэлийн өвчтэй нь тогтоогдсон хүмүүс сонгох эрхийг эдэлдэггүй.⁷

Сонгууль явуулах өдрийг холбооны Ерөнхийлөгч товлоч бөгөөд энэ өдөр нь бүтэн сайн өдөр буюу хуулиар тогтоосон ажлын бус өдөр байвал зохино.⁸ Зөвхөн сонгогчдын нэрсийн жагсаалтад орсон буюу сонгох эрхийн үнэмлэхтэй сонгогч саналаа өөрийн биеэр өгнө. Түүнчлэн саналаа шуудангаар өгөх боломжтой. Саналын нууцлалыг хангах, саналаа өгөх, саналыг тооцох ажлыг хөнгөвчлөх зорилгоор тусгай тооцооны машин төхөөрөмжийг хэрэглэдэг.

Германд шуудангаар санал өгөхдөө оршин суугаа газрынхаа хотын захиргаанд хандаж санал авах хуудас авах ёстой.⁹ Шуудангийн саналын хуудсыг саналын хуудасны хамт автоматаар илгээнэ. Саналын хуудсыг хамгийн багадаа сонгуулийн өмнөх баасан гарагийн 18.00 цаг хүртэл авах боломжтой. Онцгой тохиолдолд, тухайлбал, сонгогч гэнэтийн өвчний улмаас санал авах байранд очих боломжгүй эсвэл үндэслэлгүй хүндрэлтэй гэж үзвэл сонгуулийн өдрийн 15.00 цаг хүртэл саналын үнэмлэх олгох хүсэлт гаргаж болно. Германд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр эсвэл, цахимаар санал өгөх боломжгүй. Эндээс үзвэл Герман улсад бүх нийтийн сонгуульд сонгогчид саналаа өгөх хэлбэр нь биечилж болон цахим шуудангаар өгөх боломжтой байгаа нь харагдаж байна.

Герман улсад нийт сонгогчдын тоо нь 61,181,072 бөгөөд өнөөдрийг хүртэлх хугацаанд нийтдээ 10 сонгуулийг зохион байгуулжээ. Сонгогчдын ирц дунджаар 83.35%¹⁰ байна. Сонгуулийн ирц өндөр байгаа нь Монгол Улстай харьцуулахад сонгогчид нь хамаагүй өргөн хүрээнд тогтоогдсон дээр дурдсанчлан мөн шуудангаар санал өгөх боломжтой байгаа нь сонгогчдын ирцэд нөлөөлж байна.

2. Бүгд Найрамдах Филиппин улс

Бүгд Найрамдах Филиппин Улсад сонгуулийн зохион байгуулалтыг 1985 онд батлагдсан Сонгуулийн нэгдсэн хуулиараа зохицуулдаг. Уг хуулийн 3 дугаар зүйлд зааснаар сонгуулийн сурталчилгааг Ерөнхийлөгч болон дэд ерөнхийлөгчийн сонгуульд 90 хоног, парламентын сонгуулийг 45 хоног, орон нутгийн сонгуулийг 15 хоногт хийх

3 Мөн тэнд, 9.2.

4 УИХСтХ, 32.12. Нэр дэвшигчийг бүртгэх тухай шийдвэр гарсан бол Сонгуулийн ерөнхий хороо нэр дэвшигчийн үнэмлэхийг санал авах өдрөөс 18 хоногийн өмнө нэг өдөр олгож, нийтэд мэдээлнэ. 39.1 Сонгуулийн сурталчилгааг нэр дэвшигчид үнэмлэх олгосон өдрөөс эхлүүлж, санал авах өдрөөс 24 цагийн өмнө буюу санал авах өдрийн өмнөх өдрийн 00:00 цагаас өмнө зогсооно.

5 7 Мөн тэнд, 39.2.

6 Мөн тэнд, 62.1.

7 Ч.Энхбаатар, Холбооны Бүгд Найрамдах Герман улсын төрийн эрх зүй, (УБ, 2009), 76.

8 Federal election act, Sec. 16, bundeswahlleiterin.de, accessed Dec 8, 2024, https://www.bundeswahlleiterin.de/en/dam/jcr/4ff317c1-041f-4ba7-bbbf-1e5dc45097b3/bundeswahlgesetz_engl.pdf,

9 Мөн тэнд, 36.1

10 Election guide, Federal republic of Germany, electionguide.org, accessed Dec 8, 2024, <https://www.electionguide.org/countries/id/193/>

эрхтэй байна.¹¹ Сонгогчид саналаа заавал өөрийн биеэр санал өгөх байранд очиж зөвхөн нэг өдрийн дотор саналаа өгнө. Бүгд Найрамдах Филиппин Улсын хувьд сонгуулийн сурталчилгаа хийх хугацаа нь Монгол Улстай харьцуулахад хамаагүй их байна. Сонгуулийн сурталчилгааны хугацаа урт байснаараа шинээр нэр дэвшигч болон олонд нэр танигдсан нэр дэвшигчийн хоорондын тэгш бус байдлыг арилгах, иргэд мэдээлэлтэй сонголт хийх боломжийг олгодог.

Энэ утгаараа Филиппин улсын сонгуулийн зохион байгуулалтын давуу тал нь сонгуулийн сурталчилгаа хийх хугацааг хангалттай хэмжээнд олгосон байна. Монгол Улсын хувьд жишээ татвал сүүлийн Ерөнхийлөгчийн сонгуулийн сурталчилгаа албан ёсоор 5-р сарын 24-ны өдрөөс 6-р сарын 2-ны өдрийн хооронд болж өнгөрсөн. 19 хоногийн турш үргэлжилж байсан ерөнхийлөгчийн сонгуулийн зар сурталчилгааны хугацааг шинэчлэн батлагдсан Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулиар 15 болгон богиносгосон нь цар тахлын улмаас аль хэдийнээ хумигдаад байсан сонгогчдоо хүрч ажиллах боломжийг улам хязгаарласан алхам болсон гэж зарим улс төрийн намууд тэмдэглэсэн байдаг.¹² эндээс үзвэл Монгол улс Филиппин улсын жишгээс үлгэрлэж зар сурталчилгаа хийх хугацааг нь нэмэгдүүлэх шаардлагатай байгаа нь харагдаж байна.

Филиппин улсын сонгогчдын тоо нь 65,745,512 бөгөөд өнөөдрийг хүртэл нийтдээ 23 удаагийн сонгуулийг зохион байгуулжээ. Нийт сонгуулийн дундаж ирц нь 73.35%¹³ байна. Монгол улстай харьцуулахад даруй 10 гаруй хувиар илүү байна. Өмнө дурдсанчлан энэхүү ялгаа нь сонгуулийн зар сурталчилгаатай хамааралтай байна.

3. Бүгд Найрамдах Сингапур Улс

Сингапур Улсад Парламентын сонгуулийн зохион байгуулалтыг 1954 онд батлагдсан "Парламентын сонгуулийн тухай хууль"-иар зохицуулдаг. Энэхүү хуульд заасны дагуу сонгуулийн өдөр нь бүх нийтийн амралтын өдөр байх бөгөөд сонгуулийг албадан өгдгөөрөө бусад улсаас ялгаатай.¹⁴

Сонгогчид нь (1) Сингапурын иргэн, (2) Сингапурт байнга оршин суудаг иргэн, (3) 21-ээс дээш насны иргэд өгнө. Сингапурт санаал өгөх 3 хэлбэр байдаг. Эхнийх нь сонгууль өгөх харьяа сонгуулийн байран дээр сонгуулиа өгөх, хоёр дахь нь гадаад оршин суугаа биечлэн өгөх боломжгүй иргэд шуудангаар саналаа өгдөг. Ингэхдээ урьдчилж бүртгүүлээд сонгогчийн үнэмлэх авч байж өгөх эрх үүснэ, гурав дахь нь гадаад байгаа элчин сайдын яаман дээр сонгуулиа өгч болдог.¹⁵ ерөнхийдөө Монгол Улстай сонгуулийн зохион

байгуулалт нь төстэй. Давуу тал нь Сингапурын хувьд шуудангаар санал авах хэлбэр байдаг. Сингапур улс нийтдээ 8 удаа Ерөнхийлөгчийн болон Парламентын сонгуулийг зохион байгуулсан байдаг. Хамгийн анхны 2001 оны Парламентын сонгуулийн ирц 94.61% байсан бол хамгийн сүүлийн 2020 оны Парламентын сонгуулийн дүн 95.81%¹⁶ хувь байгаа нь албадан сонгууль авдаг учраас зохион байгуулалттай шууд холбоотой гэж дүгнэж болохоор байна.

IV. ҮНДСЭН ХЭСЭГ

Өмнөх хэсэгт Монгол Улсын сонгуулийн зохион байгуулалтын зарим зүйлсийг бусад улсынхтай харьцуулан судаллаа. Энэхүү судалгаанаас Монгол Улсын сонгуулийн зохион байгуулалтад хэд хэдэн сул тал ажиглагдаж байна. Эдгээр нь (1) зарим улсуудтай харьцуулан үзэхэд сонгуулийн сурталчилгаа явуулах хугацаа нь бага байна, (2) сонгогч заавал санал авах байранд өөрийн биеэр очих санал өгөх хэлбэрт үндэслэн саналыг авч байна. Сонгуулийн сурталчилгаа явуулахын ач холбогдол нь сонгуулийн жилд сонгуульд өрсөлдөж буй нэр дэвшигчид мөрийн хөтөлбөрөө, өөрийгөө, өөрийн нам, эвслийг сонгогчдод таниулах гэсэн ач холбогдолтой байдаг. Өнөөдөр Монгол Улсын Дээд шүүхийн Улс төрийн намын бүртгэлд нийт 37 нам байна.¹⁷ УИХСтХ-д заасан хугацаанд энэ олон нам, нэмээд бие даан нэр дэвшигчдийн тухай мэдээлэл, мөрийн хөтөлбөртэй хангалттай танилцах хугацаа болж чадаж байгаа эсэхэд эргэлзээтэй байна. Хэдийгээр тойрогт хуваагдан уг тоо харьцангуй багасах хэдий ч сонгох эрхээ (бүрэн утгаар нь) хэрэгжүүлэхэд аль болох олон нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөртэй танилцан, сонголтоо сайн судлах шаардлагатай гэж үзэж байна.

Дараагийн нэгэн анхааралд өртөж буй зүйл бол саналыг сонгогч заавал биечлэн өгөх тухай асуудал юм. Ерөнхий зарчмын дагуу бол биеэр санал өгөх явдлыг буруутгах боломжгүй. Гэхдээ зөвхөн энэ хэлбэрээр саналыг авах нь сул тал ихтэй гэж харж байна. Жишээ нь ХБНГУ, АНУ зэрэг олон улсуудад шуудангаар саналаа өгч болдог, бүр цаашлаад Бүгд Найрамдах Эстони Улсад цахимаар сонгуулиа өгдөг зохион байгуулалтын хэлбэрийг 2005 оноос хэрэгжүүлж байна.¹⁸

11 Omnibus Election code of the Philippines, Sec. 3, accessed Dec 8, 2024, <https://chanrobles.com/electioncodeofthephilippines.html>.

12 АИХЭГ-ын сонгууль ажиглах тусгай хороо, "Монгол Улс-Ерөнхийлөгчийн сонгууль" урьдчилсан дүн, дүгнэлтийн тайлан, (УБ, 2021.06.09), 7.

13 Election guide, Republic of the Philippines, [electionguide.org](https://www.electionguide.org/countries/id/193/), accessed Dec 8, 2024, <https://www.electionguide.org/countries/id/193/>.

14 Parliamentary Election Act 1954, Sec.35, accessed Dec 8, 2024, <https://sso.agc.gov.sg/Act/PEA1954?Provids=P13-#pr35->.

15 Parliamentary Election Act 1954, Sec.14, accessed Dec 8, 2024, <https://sso.agc.gov.sg/Act/PEA1954?Provids=P13-#pr35->.

16 Election guide, Republic of Singapore, [electionguide.org](https://www.electionguide.org/countries/id/193/), accessed Dec 8, 2024, <https://www.electionguide.org/countries/id/193/>.

17 Улс төрийн намын бүртгэл, supremecourt.mn, 2024 оны 12 сарын 09-нд үзсэн, <https://www.supremecourt.mn/mn/home?page=party&id=69&pr=127&tp=list&h=0>.

18 What is e-voting? Who's using it and is it safe?, [weforum.org](https://www.weforum.org/stories/2024/04/what-is-electronic-voting/), accessed Dec 9th, 2024, <https://www.weforum.org/stories/2024/04/what-is-electronic-voting/>.

V. ДҮГНЭЛТ, САНАЛ

Дээрх судалгаанд үндэслээд илтгэл тавигчид нь сонгуулийн ирцийг нэмэгдүүлэх зорилгоор тогтолцооны хүчин зүйлийн хүрээнд дараах саналыг дэвшүүлж байна.

1. Сонгогчдод сонгох эрхээ хэрэгжүүлэх боломжийг өргөн хүрээнд нээж өгөх зорилгоор сонгуулийн сурталчилгааг уртасгах
2. Сонгуулийн сурталчилгааг хиймэл оюун ухаан, цахим орчинд тулгуурлан явуулах
3. Санал авах хэлбэрийг зөвхөн сонгогч өөрийн биеэр өгдөг хэлбэрийг нээж, бусад хэлбэрээр саналаа өгөх боломжийг нээх.

Сонгуулийн сурталчилгаа явуулах хугацааг уртасгах асуудалд тулгамдаж буй асуудал байхгүй гэж найдан хиймэл оюун ухааныг ашиглан сонгуулийн сурталчилгааг явуулах асуудалд анхаарлыг төвлөрүүлэе. Дээр дурдсанчлан хуульд заасан хугацаанд нэр дэвшигчдийн мэдээлэл, мөрийн хөтөлбөртэй бүрэн танилцахад бэрхшээлтэй. Үүнд цахим орчин, хиймэл оюун ухааныг хослон хэрэглэж нэр дэвшигчдийн тухай бүхий л мэдээллийг нэгдсэн санд оруулан хиймэл оюун ухаанаар боловсруулалт хийснээр тэнд мэдээлэл цэгцтэй, сонгогчдод хүрэхэд амар болно. Ингэснээр сонгогч нь нэр дэвшигчийн мэдээллийг өөрөө хөөцөлдөн олж авах, өөрөө тэр олон мөрийн хөтөлбөр, мэдээлэл дундаас хэрэгцээт мэдээллээ олж авах гээд цаг хугацаа хэмнэсэн шийдэл болж чадна гэж харж байна.

Дараагаар саналыг бусад аргаар авах тухай санал дэвшүүлсэн. Өмнө дурдсанчлан бусад улс оронд цахим орчин, шуудан зэрэг зүйлсийг ашиглаж сонгуулийг өгч байна. Монгол Улсад ч ийнхүү өөр аргаар сонгуулийг өгснөөр наад зах нь ахмад настай, хөгжлийн бэрхшээлтэй гээд өөрийн биеэр санал өгөхөд хүндрэл учирдаг иргэдэд саналаа өгөхөд хялбар болно. Нэмж хэлэхэд, өөрийн биеэр очиж саналаа өгөхөд дараалал хүлээх зэрэг үйл явдлаас болж зарим иргэд сонгууль өгөх хүсэл нь буурдаг.

ЭХ СУРВАЛЖ

Ном

1. Б.Чимид, Сонгуульд суралцахуй (УБ; "ADMON" ХХК, 2008)
2. Ч.Энхбаатар, Холбооны Бүгд Найрамдах Герман улсын төрийн эрх зүй, (УБ, 2009)
3. Эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн эмхэтгэл, Монгол Улс дахь Үндсэн хуулийн процессын тулгамдсан асуудал: Хууль тогтоох, сонгуулийн болон төсвийн процесс, (УБ, 2013)

Цахим эх сурвалж

1. Н.Мягмарцоож, "Залуу сонгогчдын ирц, түүнд нөлөөлөгч хүчин зүйлс", ikon.mn, 2024 оны 12 сарын 06-нд үзсэн, <https://ikon.mn/n/29fk>.
2. Монгол Улсын Их Хурлын Сонгуулын тухай хууль, 2019
3. Federal election act, Sec. 16, bundeswahlleiterin.de, accessed Dec 8, 2024, https://www.bundeswahlleiterin.de/en/dam/jcr/4ff317c1-041f-4ba7-bbbf-1e5dc45097b3/bundeswahlgesetz_engl.pdf,
4. Улс төрийн намын бүртгэл, supremecourt.mn, 2024 оны 12 сарын 09-нд үзсэн, <https://www.supremecourt.mn/mn/home?page=party&id=69&pr=127&tp=list&h=0>.
5. lection guide, Federal republic of Germany, electionguide.org, accessed Dec 8, 2024, <https://www.electionguide.org/countries/id/193/>
6. Omnibus Election code of the Philippines, accessed Dec 8, 2024, <https://chanrobles.com/electioncodeofthephilippines.htm>.
7. Parliamentary Election Act 1954, accessed Dec 8, 2024, <https://sso.agc.gov.sg/Act/PEA1954?Provs=P13-#pr35->
8. What is e-voting? Who's using it and is it safe?, weforum.org, accessed Dec 9th, 2024, <https://www.weforum.org/stories/2024/04/what-is-electronic-voting/>
9. Tungaahui.mn, 2024 оны 12 сарын 08-нд үзсэн, http://tungaahui.mn/pages/data-art.php?fbclid=IwY2xjawHFQM5leHRUA2FlbQlXMAABHeQzWJJcYT7TLMktfGdmBgHVtH906J-8xu63jY8e2zE09Jewta7ZXjN9oQLaem_8BtfEnwjU0xYvm af5Nxtw
10. АИХЭГ-ын сонгууль ажиглах тусгай хороо, "Монгол Улс-Ерөнхийлөгчийн сонгууль" урьдчилсан дүн, дүгнэлтийн тайлан, (УБ, 2021.06.09), 7.



СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ ШИЙДВЭР: ШҮҮХИЙН ХЯНАЛТ

Хуульч **П.БАТТУЛГА** -

Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн сонгуулийн процессын явцад сонгуулийн төв байгууллага буюу Сонгуулийн ерөнхий хороо (СЕХ)-ны шийдвэрийг Үндсэн хуулийн цэц ба захиргааны хэргийн шүүхийн аль нь хянах вэ? хэргийн харьяаллыг хэрхэн тогтоох вэ? шүүх (цэц, захиргааны хэргийн шүүх)-ийн хяналтын цар хүрээг хэрхэн тогтоох вэ? гэсэн асуултууд гардаг. Энэ асуултад бид хариулт өгч чадсан уу? эсхүл энэ нь манай улсын хууль зүйн шинжлэх ухаанд хариултаа хүлээсэн судлагдахуун байсаар байна уу? Энэ талаар өөрийн санал, бодлыг илэрхийлэхийг энэхүү нийтлэлээр зорьсон болно

СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ ШИЙДВЭР: ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦ

Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2-т зааснаар Үндсэн хуулийн цэц "ард нийтийн санал асуулга, Улсын Их Хурал, түүний гишүүний ба Ерөнхийлөгчийн сонгуулийн талаар сонгуулийн төв байгууллагын гаргасан шийдвэр Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх" маргааныг хянан шийдвэрлэхээр заасан. Өнгөрсөн хугацаанд Үндсэн хуулийн цэц сонгуулийн төв байгууллагад холбогдох дараах 3 маргааныг шийдвэрлэсэн байна.

№	Маргааны агуулга	Шийдвэрлэсэн байдал
1.	СЕХ-ны 1996.06.06-ны 09 дүгээр тогтоолоор Д.Нармандах, Х.Баянмөнх нарыг УИХ-ын гишүүнд нэр дэвшигчийн нэрсийн жагсаалтаас хассаныг Д.Нармандах, Х.Баянмөнх эс зөвшөөрч маргасан	Дүгнэлт. 1996.06.20, №05. СЕХ-ны шийдвэр Үндсэн хууль зөрчөөгүй Тогтоол. 1996.09.11, №04. Дүгнэлтийг хэвээр үлдээсэн.
2.	СЕХ-ны 1997.03.27-ны 03 дугаар тогтоолоор П.Очирбатыг Монгол Улсын Ерөнхийлөгчид нэр дэвшигчээр бүртгэснийг эс зөвшөөрч, иргэн Ч.Доржгочоо, О.Дашням нар Үндсэн хуулийн цэцэд хандсан.	Дүгнэлт. 1997.04.23, №03. СЕХ-ны шийдвэр Үндсэн хууль зөрчөөгүй
3.	СЕХ-ны 2012.11.24-ний "Санал хураалтын дүнгийн тухай" 160 дугаар тогтоолоор нэр дэвшигч Д.Арвиныг УИХ-ын сонгогдсон тооцсон гэсэн шийдвэрийг эс зөвшөөрч, иргэн А.Гантамир Үндсэн хуулийн цэцэд мэдээлэл гаргасан.	Дүгнэлт. 2013.02.01, №01. СЕХ-ны шийдвэр Үндсэн хууль зөрчөөгүй

Дээрх маргаануудын хувьд, эхний маргаан нь УИХ-ын сонгуульд нэр дэвшигчийг хассан, удаах маргаан нь Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчийг бүртгэсэн, сүүлийн маргаан нь санал хураалтын дүнг УИХ-д өргөн мэдүүлсэнтэй холбоотой маргаанууд байжээ.

2002 оны 12 дугаар сарын 26-ны өдөр батлагдаж, 2004 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдөгдөж буй Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4.1.6-д "Сонгуулийн ерөнхий хороо"-ны шийдвэр (захиргааны акт, захиргааны хэм хэмжээний акт)-т холбогдох маргааныг захиргааны хэргийн шүүх харьяалан шийдвэрлэхээр заасан. Гэтэл Үндсэн хуулийн цэцийн 2005 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн 02 дугаар дүгнэлтээр¹ Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6-д "Сонгуулийн ерөнхий хороо" гэж заасан нь Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2-ыг зөрчсөн гэж дүгнэсэн ба уг дүгнэлтийг УИХ хүлээн зөвшөөрч, 2005 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн хуулиар уг заалтыг хүчингүй болгосон билээ.

Уг нь Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэр Үндсэн хууль зөрчсөн гэж бус, харин сонгуулийн тухай хууль тогтоомжийг зөрчиж, өөрийнх нь эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хохироосон гэж үзвэл иргэн, хуулийн этгээд захиргааны хэргийн шүүхээр маргаанаа шийдвэрлүүлдэг байх агуулгаар Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4.1.6-д "Сонгуулийн ерөнхий хороо" гэж заасан боловч² Үндсэн хуулийн цэцийн 2005 оны 2 дугаар дүгнэлт гарснаар Сонгуулийн ерөнхий хорооны сонгуулийн тухай хууль тогтоомжийг зөрчсөнтэй холбоотой маргааныг аль шүүх шийдвэрлэх вэ? гэдэг асуултыг үүсгэсэн.

Энэ нь Улсын дээд шүүхээс "Үндсэн хуулийн цэцийн 2005 оны ... 02 дугаар дүгнэлт Үндсэн хуулийн арван зургадугаар зүйлийн 14 дэх хэсэгт заасан **"Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах"** Монгол Улсын иргэний үндсэн эрхийг хязгаарлахгүй тул Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэр Үндсэн хуулиас бусад хуулийг, Үндсэн хуулиар Монгол Улсын иргэнд олгогдсон сонгох, сонгогдох эрхээс бусад эрхийг зөрчсөн талаарх гомдлыг ... дүүргийн шүүхэд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 14 дүгээр бүлэгт заасан журмын дагуу гаргана. Хуулийн 21 дүгээр зүйлд заасан тойргийн хорооны шийдвэрт тухайн тойргийн хороог харьяалах сум буюу сум дунд, дүүргийн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 14 дүгээр бүлэгт заасан журмын

дагуу гомдол гаргана" гэж тайлбарлахад хүргэсэн байдаг.³ Хэдий Улсын дээд шүүхээс ийм тайлбарыг гаргасан боловч тойргийн сонгуулийн хороонд холбогдох маргааныг захиргааны хэргийн шүүх шийдвэрлэж байсан⁴ байдаг.

СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ ШИЙДВЭР: ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ШҮҮХ

2016 оны 2 дугаар сарын 4-ний өдөр батлагдаж, 2016 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс дагаж мөрдөгдөж буй Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 13.1-д "Захиргааны хэргийн шүүх Үндсэн хуулийн цэц болон өөр шүүхэд харьяалуулснаас бусад нийтийн эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэнэ" гэж, 112 дугаар зүйлийн 112.1.3-т "Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх "хуульд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын Их Хурлын болон Ерөнхийлөгчийн сонгуулийн маргаан"-ыг анхан шатны журмаар хянан шийдвэрлэнэ" гэж тус тус заасан. Улмаар 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдөр батлагдсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулиар сонгуулийн маргааны хэргийн харьяаллыг илүү нарийвчилсан байдлаар буюу хуулийн 81.3-т "Энэ хуулийн 74 дүгээр зүйлд заасны дагуу санал хураалтын дүнг өргөн мэдүүлсэн Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэрт холбогдуулан гаргасан маргааныг Үндсэн хуулийн цэц хянан шийдвэрлэнэ", 81.4-т "Энэ хуулийн 81.3-т зааснаас бусад Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэрт холбогдох маргааныг Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх анхан шатны журмаар, Улсын дээд шүүх давж заалдах журмаар хянан шийдвэрлэнэ" гэж, 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр батлагдсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 80.3-т "Энэ хуульд заасны дагуу санал хураалтын дүнг өргөн мэдүүлсэн Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэрт холбогдуулан гаргасан маргааныг Үндсэн хуулийн цэц хянан шийдвэрлэнэ", 80.4-т "Энэ хуулийн 80.3-т зааснаас бусад Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэрт холбогдох маргааныг Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх анхан шатны журмаар, Улсын дээд шүүх давж заалдах журмаар хянан шийдвэрлэнэ" гэж тус тус зохицуулсан.

Шүүхийн шийдвэрийн цахим сан (shuukh.mn)-аас хайж үзэхэд 2024 оны Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн үеэр Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх нам, эвсэл, нэр дэвшигчийг бүртгэхтэй холбоотойгоор Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэрт холбогдуулан гаргасан дараах 5 маргааныг шийдвэрлэсэн байна:

1 <https://legaldata.mn/tsets/shiidver/view/21ee3b2b1ca1> (Сүүлд 2025.11.19-ний өдөр хандсан)

2 Сонгуулийн ерөнхий хороо нь төрийн байгууллагын чиг үүргийг гүйцэтгэж байгаа нийтийн эрх зүйн субъектын хувьд тус улсад дагаж мөрдөж байгаа хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаа явуулна. Эдгээр хууль тогтоомжийн нэгийг зөрчсөн шийдвэр гаргасан тохиолдолд Үндсэн хуулийн цэцэд биш захиргааны хэргийн шүүхээр хянан шийдвэрлүүлнэ. Үндсэн хуулийн цэцийн 2005 оны 02 дугаар дүгнэлт. Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч Улсын Их Хурлын гишүүн Р.Эрдэнэбүрэн, С.Баярцогт нарын Үндсэн хуулийн цэцэд өгсөн тайлбараас

3 Улсын дээд шүүхийн 2008 оны 3 дугаар сарын 31-ний өдөр "Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай" 16 дугаар тогтоол

4 Улсын дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны тогтоол. "Э-н нэхэмжлэлтэй тойргийн сонгуулийн хороонд холбогдох захиргааны хэрэг" 2013.03.04, №40. Улсын дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны тогтоол. "М, Н нарын нэхэмжлэлтэй тойргийн сонгуулийн хороонд холбогдох захиргааны хэрэг" 2013.04.01, №61.

№	Маргааны агуулга	Шийдвэрлэсэн байдал
1.	Нэхэмжлэгч: Н.Н Хариуцагч: Сонгуулийн ерөнхий хороо Нэхэмжлэлийн шаардлага: СЕХ-ны 2024.05.30-ны өдрийн нэр дэвшигчээр бүртгэхээс татгалзсан 6* дугаар тогтоолыг хүчингүй болгож, нэр дэвшигчээр бүртгэж, нэр дэвшигчийн үнэмлэх олгохыг даалгуулах.	-Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шийдвэр: ⁵ 2024.06.06, №221/ШШ2024/0015 -Нэхэмжлэлийг бүхэлд нь хангасан.
2.	Нэхэмжлэгч: Б.Х Хариуцагч: Сонгуулийн ерөнхий хороо Нэхэмжлэлийн шаардлага: А намын Үндэсний бодлогын хорооны хурлын 2024 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 09 дүгээр тогтоол, түүний хавсралтад бичигдсэн Б.Х-ыг 2024 оны Монгол Улсын Их Хурлын сонгуульд нэр дэвшигчээр бүртгэхгүй байгаа Сонгуулийн ерөнхий хорооны эс үйлдэхүй хууль бус болохыг тогтоолгох, нэр дэвшигчээр бүртгэхийг даалгуулах.	-Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шийдвэр: ⁶ 2024.06.07, №221/ШШ2024/0016 -Нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон.
3.	Нэхэмжлэгч: Э нам Хариуцагч: Сонгуулийн ерөнхий хороо Нэхэмжлэлийн шаардлага: СЕХ-ны 2024 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн намуудад олгогдсон тогтоол, батламжуудын ҮҮ нам, С нам, И нам, М нам, С нам, А нам, Г нам, М нам, М нам, Д намуудад холбогдох хэсгийг хүчингүй болгуулах тухай	-Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шийдвэр: ⁷ 2024.06.12, №221/ШШ2024/0019 -Нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон.
4.	Нэхэмжлэгч: Д.Т, ИХ нам Хариуцагч: Сонгуулийн ерөнхий хороо Нэхэмжлэлийн шаардлага: "ИХН-ын нэр дэвшигч Д овогтой Т-ийг нэр дэвшигчээр бүртгэхгүй байгаа эс үйлдэхүйг хууль бус болохыг тогтоож, нэр дэвшигчээр бүртгэж, үнэмлэх олгохыг даалгах.	-Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шийдвэр: ⁸ 2024.06.14, №221/ШШ2024/0020 -Нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон.

5.	Нэхэмжлэгч: Н.Х Хариуцагч: Сонгуулийн ерөнхий хороо Нэхэмжлэлийн шаардлага: Сонгуулийн ерөнхий хорооны 2024 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 69 дүгээр тогтоолыг хүчингүй болгуулж, Н.Х-г нэр дэвшигчээр бүртгэж, нэр дэвшигчийн үнэмлэх олгохоос татгалзсан Сонгуулийн ерөнхий хорооны эс үйлдэхүй хууль бус болохыг тогтоож, Н.Х-г нэр дэвшигчээр бүртгэж, нэр дэвшигчийн үнэмлэх олгохыг хариуцагчид даалгах"	-Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шийдвэр: ⁹ 2024.06.19, №221/ШШ2024/0024 -Нэхэмжлэлийг бүхэлд нь хангасан.
----	--	--

Дээрх 5 маргааны 4 нь Сонгуулийн ерөнхий хороо нэр дэвшигчийг бүртгэхээр татгалзсан, 1 нь нам, эвслийг нэр дэвшигчээр бүртгэсэнтэй холбоотой маргаан байх ба шүүх 2-т нь нэхэмжлэлийг бүхэлд нь хангаж, 3-т нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгожээ.

Сонгуулийн маргааны хэргийн харьяалал: Үндсэн хуулийн цэц, ба Захиргааны хэргийн шүүх

Монгол Улсын Их Хурлын болон Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд зааснаар Сонгуулийн ерөнхий хорооны "санал хураалтын дүнг гаргах, өргөн мэдүүлэх"-тэй холбогдуулан гаргасан маргааныг Үндсэн хуулийн цэц хянан шийдвэрлэх, бусад маргаан (нэр дэвшигчийг бүртгэх, хасах г.м)-ыг захиргааны хэргийн шүүх шийдвэрлэхээр зохицуулснаас үзвэл, Сонгуулийн ерөнхий хорооны Монгол Улсын Их Хурлын болон Монгол Улсын Ерөнхийлөгчийн "санал хураалтын дүнг гаргах, өргөн мэдүүлэх"-тэй холбогдуулан гаргасан маргааныг захиргааны хэргийн шүүх шийдвэрлэхгүй нь тодорхой харагдаж байна.

Харин өмнөх хэсэгт дурдсанчлан Үндсэн хуулийн цэц Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн сонгуулийн үед Сонгуулийн ерөнхий хорооны нэр дэвшигчийг бүртгэсэн, хассан шийдвэр Үндсэн хууль зөрчсөн эсэхийг хянан шийдвэрлэж байсан. Харин Монгол Улсын Их Хурлын болон Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулиар зохицуулснаар Сонгуулийн ерөнхий хорооны "санал хураалтын дүнг гаргах, өргөн мэдүүлэх"-тэй холбогдуулан гаргасан шийдвэрээс бусад бүх шийдвэрт холбогдуулан гаргасан маргаан буюу нам, эвсэл, нэр дэвшигчийг бүртгэх, хасах эсэх гэх мэт шийдвэртэй холбогдуулан гаргасан маргааныг захиргааны хэргийн шүүх шийдвэрлэхээр зохицуулсан. Гэхдээ энэ нь уг маргааныг Үндсэн хуулийн цэц хянан шийдвэрлэхгүй гэсэн үг үү? Энэ асуултад шууд "тийм" гэж хэлэхэд төвөгтэй.

Учир нь Үндсэн хуулийн цэц Сонгуулийн ерөнхий хорооны нам, эвсэл, нэр дэвшигчийг бүртгэх, хасах эсэх талаар гаргасан шийдвэртэй холбогдуулан Үндсэн хуулийн цэцэд өргөдөл, мэдээлэл хүлээн авлаа гэхэд Цэц Үндсэн

5 https://shuukh.mn/single_case/8044?daterange=2024-06-01%20-%202024-12-06&id=2&court_cat=3&bb=1 (Сүүлд 2025.11.19-ний өдөр хандсан)

6 https://shuukh.mn/single_case/8236?daterange=2024-06-01%20-%202024-12-06&id=2&court_cat=3&bb=1 (Сүүлд 2025.11.19-ний өдөр хандсан)

7 https://shuukh.mn/single_case/8437?daterange=2024-06-01%20-%202024-12-06&id=2&court_cat=3&bb=1 (Сүүлд 2025.11.19-ний өдөр хандсан)

8 https://shuukh.mn/single_case/8238?daterange=2024-06-01%20-%202024-12-06&id=2&court_cat=3&bb=1 (Сүүлд 2025.11.19-ний өдөр хандсан)

9 https://shuukh.mn/single_case/8237?daterange=2024-06-01%20-%202024-12-06&id=2&court_cat=3&bb=1 (Сүүлд 2025.11.19-ний өдөр хандсан)

хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2 дахь заалт болоод өмнөх практикаа үндэслээд маргааныг хүлээн авч шийдвэрлэх боломжтой, эсхүл Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 81.4-т заасны дагуу маргаан үүсгэхээс татгалзах ч боломж харагдаж байна.

Нөгөөтэйгүүр, 2012 оны УИХ-ын ээлжит сонгуулийн хүрээнд нэр дэвшигчийг хасахтай холбоотойгоор үүссэн маргаанд Улсын дээд шүүх "... хүчин төгөлдөр үйлчилж байгаа Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн дагуу шаталсан тогтолцоотой захиргааны байгууллагын эцсийн шат болох Сонгуулийн төв байгууллагын шийдвэр эцэслэн гарч, ... Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрх нь хүлээн зөвшөөрөгдсөний дараа Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийн талаар шийдвэр гаргах эрхийг Захиргааны хэргийн шүүхэд хуулиар олгоогүй байна"¹⁰ гэсэн дүгнэлт хийсэн байдаг ба энэ шийдвэрээс харахад Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн сонгуулийн маргааны хүрээнд захиргааны хэргийн шүүхийн хяналтын цар хүрээ хэр хэмжээнд байх вэ? гэдэг асуулт бас л гарч ирж байна.

Дээр дурдсан Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхээр шийдвэрлэгдсэн 5 маргааны тухайд 2024 оны 6 дугаар сарын 6-ны өдөр анхны шийдвэр гарсан бол, 2024 оны 6 дугаар сарын 19-ний өдөр хамгийн сүүлийн шийдвэр нь гарсан байна. Эдгээр тохиолдолд хэргийн оролцогчид давж заалдах гомдол гаргалгүйгээр шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон¹¹ тул практик дээр асуудал гараагүй аж. 2024 оны Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн санал хураалт 2024 оны 6 дугаар сарын 28-ны өдөр болсон ба эндээс хэрэв, дээрх маргаануудад хэргийн оролцогчоос Улсын дээд шүүхэд давж заалдах гомдол гаргаж, маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үргэлжилж байх үед санал хураалт болоод дуусчихвал¹² захиргааны хэргийн шүүх маргааныг хэрхэн шийдвэрлэх вэ? гэдэг асуулт мөн л гарч байна.

Судлаачийн үзэж байгаагаар нам, эвсэл, хүнийг сонгуульд бүртгэх, хасах эсэх талаар гаргасан Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэр хууль бус байсан ч, нэгэнт сонгуулийн санал хураалт болоод дуусчихвал захиргааны хэргийн шүүх түүний үр дагаврыг арилгах буюу нам, эвсэл, хүнийг сонгуульд бүртгэх, хасах, сонгуулийг хүчингүй болгох, дахин сонгууль явуулахыг Сонгуулийн ерөнхий хороонд даалгаж шийдвэрлэх боломжгүй ба харин нэхэмжлэгчийн шаардлагын хүрээнд уг шийдвэр нь хууль бус байсан болохыг¹³ тогтоогоод орхих боломжтой гэж харж байна.

Сонгуулийн ерөнхий хорооны хуульд заасан болзол, шаардлагыг хангаагүй нам, эвсэл, нэр дэвшигчийг бүртгэсэн, эсхүл хангасныг нь бүртгээгүй, хасах ёсгүйг хассан, хасах ёстойг хасаагүй шийдвэр нь аль ч тохиолдолд сонгуулийн дүнд нөлөөлөхүйц шийдвэр гэдэг нь маргаангүй. Иймд Үндсэн хуулийн цэц Сонгуулийн ерөнхий хорооны зөвхөн санал хураалтын дүнг гаргасан, үр дүнг өргөн мэдүүлсэн шийдвэртэй холбогдуулан гаргасан маргааныг л хянан шийдвэрлэнэ, өөр бусад маргааныг захиргааны хэргийн шүүх шийдвэрлэнэ гэж шууд үзэх нь учир дутагдалтай байна.

Дээрхээс дүгнэхэд иргэний сонгох, сонгогдох эрхийг баталгаатай эдлүүлэх, зөрчигдсөн эрхийг сэргээх Үндсэн хуулийн үзэл санааг хэрэгжүүлэхийн тулд сонгуулийн төв байгууллагаас гаргасан шийдвэр нь Үндсэн хууль, бусад хууль тогтоомжийг зөрчсөн тохиолдолд уг маргааныг хянан шийдвэрлэх үндэслэл, хэргийн харьяалал, маргааныг шийдвэрлэх хугацаа, хяналтын цар хүрээ, шүүх (цэц, захиргааны хэргийн шүүх)-ээс гарах шийдвэрийн төрлийг оновчтой тодорхойлох асуудлыг зөвхөн сонгуулийн хуулийн хүрээнд бус Үндсэн хуулийн процессын эрх зүй, Захиргааны процессын эрх зүйн хүрээнд цогцоор нь авч үзэж, нэгдэмл, нөг нь нөгөөгөө үгүйсгээгүй, зөрчилдөөнгүй зохицуулалтыг бий болгох шаардлагатай байна.

10 Улсын дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны тогтоол. "М, Н нарын нэхэмжлэлтэй тойргийн сонгуулийн хороонд холбогдох захиргааны хэрэг" 2013.04.01, №61.

11 Шүүхийн шийдвэрийн цахим санд эдгээр шүүхийн шийдвэрийг хянаж гаргасан Улсын дээд шүүхийн тогтоол байхгүй байна.

12 Ийм асуудал үүсэх боломжтой. Учир нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 29.1-д "Сонгуульд оролцохоор бүртгүүлсэн нам, эвсэл нэр дэвшүүлэх ажиллагааг санал авах өдрөөс 45 хоногийн өмнө эхлүүлж, долоо хоногийн хугацаанд дуусгана", 32.11-т "Сонгуулийн ерөнхий хороо нэр дэвшигчийн баримт бичгийг хүлээн авах хугацаа дууссанаас хойш долоо хоногийн дотор бүртгэх эсэх асуудлыг шийдвэрлэж, тогтоол гаргана", 32.12-т "Нэр дэвшигчийг бүртгэх тухай шийдвэр гарсан бол Сонгуулийн ерөнхий хороо нэр дэвшигчийн үнэмлэхийг санал авах өдрөөс 18 хоногийн өмнө нэг өдөр олгож, нийтэд мэдээлнэ" тус гэж заасан. Харин Улсын Их Хурлын сонгуулийн маргааныг Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх анхан шатны журмаар, Улсын дээд шүүх давж заалдах журмаар хянан шийдвэрлэж дуусах хуулиар тогтоосон нийт хугацаа 78 хоног болж байна. Нэхэмжлэлийг шүүх хүлээж аваад 7 хоногийн дотор захиргааны хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэнэ. Захиргааны хэрэг үүсгэсэн тохиолдолд хэргийг 30 хоногийн дотор хянан шийдвэрлэнэ. Шаардлагатай тохиолдолд уг хугацааг 10 хүртэл хоногоор сунгаж болно. Шүүхийн шийдвэрийг 5 хоногийн дотор бичгээр үйлдэнэ. Хэргийн оролцогч шүүхийн шийдвэрийг хүлээж авснаас хойш 5 хоногийн дотор гомдол гаргана. Улсын дээд шүүх 21 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэнэ. (7+30+10+5+21=78)

13 Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль. 2016.02.04 106.3. Анхан шатны шүүхээс захиргааны хэргийг шүүх хуралдаанаар хянан хэлэлцээд дараахь шийдвэрийг гаргана: 106.3.3. захиргааны акт хүчингүй болгуулах нэхэмжлэл гаргасны дараа тухайн актыг цуцалсан болон хүчингүй болгосон, эсхүл бусад байдлаар хэрэгжсэн бөгөөд нэхэмжлэгчийн ашиг сонирхол байгаа бол маргаан бүхий акт хууль бус байсан болохыг тогтоох;



“СОНГУУЛИЙН ҮР НӨЛӨӨ ТОГТВОРТОЙ БАЙДАЛ”

СЭДЭВТ ОЛОН УЛСЫН СЕМИНАРААС ГАРГАСАН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Сонгуулийн ерөнхий хорооны дарга П.Дэлгэрнаран 10 дугаар сарын 21-23-ны өдөр Индонезийн Бандунг хотод болсон “Сонгуулийн үр нөлөө, тогтвортой байдал” сэдэвт олон улсын семинарт оролцлоо.

Бүгд Найрамдах Индонез Улсын Засгийн газар, Ардчилал, сонгуульд дэмжлэг үзүүлэх олон улсын хүрээлэн (International IDEA), Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөний Зүүн-Зүүн техникийн хамтын ажиллагааны төвөөс хамтран зохион байгуулсан уг семинарт 18 улсын сонгуулийн төв байгууллагын удирдлагууд оролцож, ардчилсан сонгууль зохион байгуулах, сонгуулийн үр нөлөөг дээшлүүлэх, зардал бууруулах талаар хэрэгжүүлж буй туршлагаа хуваалцав.

Ардчилал, сонгуульд дэмжлэг үзүүлэх олон улсын хүрээлэнгийн Африк, Баруун Азийн хөтөлбөрийн бүсийн дарга Грам Матенга семинарыг нээж хэлсэн үгэндээ “Сонгуулийн зардал ардчилалд хэзээ ч саад болж болохгүй” гэж онцлон тэмдэглэсэн. Оролцогчид сонгууль зохион байгуулах зардал нэмэгдэж байгаа нь дэлхийн хэмжээний сорилт гэдгийг хүлээн зөвшөөрч, сонгуулийн шударга байдлыг хангахын тулд хүртээмжтэй, тогтвортой шийдлүүдийг олох ач холбогдлын талаар хэлэлцлээ. Улмаар Индонез, Соломоны арлууд, Бүгд Найрамдах Ардчилсан Конго улсын оролцогчид сонгуулийн ил тод байдал, өртөг хэмнэлт, ложистикийн нарийн төвөгтэй байдлыг тэнцвэржүүлж, олон янзын орчинд сонгууль явуулахад шаардагдах үр чадварыг илтгэлдээ онцолсон.

“Сонгуулийн үр нөлөө, тогтвортой байдал” семинарын төгсгөлд оролцогч улс орнуудын сонгуулийн төв байгууллагуудын үйл ажиллагаанд чиглэсэн зөвлөмж гаргалаа. Уг зөвлөмжийг хүргэж байна.

ИНДОНЕЗИЙН БАНДУНГ ХОТ,
2025 ОНЫ 10 ДУГААР САРЫН 21-23-НЫ ӨДӨР

1. СОНГУУЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САНХҮҮЖИЛТИЙН ЗАРЧМЫН ТАЛААР:

ГОЛ ДҮГНЭЛТ: Бүх улс орны сонгуулийн удирдлагын төв байгууллагуудын мөрдвөл зохих ерөнхий зарчмууд:

- Ил тод байдлыг хангах
- Хариуцлагатай байх
- Үр нөлөөтэй байх
- Тогтвортой байх
- Сонгуулийн төв байгууллагуудын шударга байдлыг хангах
- Бүх талын оролцоог хангах
- Цаг хугацааг чанд баримтлах

Үр нөлөөг дээшлүүлэх арга хэмжээг авч буй хэдий ч сонгуулийн зардал улам бүр нэмэгдэж байна. (Гэнэтийн төлөвлөөгүй зардал, нийгмийн хэрэглээний индексийн өсөлт, байгалийн гамшиг гэх мэт зардал гарч байна.) Гэхдээ үр нөлөөг дээшлүүлэх нь зардлыг бууруулах нэг механизм юм.

Сонгууль нь хөрөнгө оруулалт бөгөөд ардчиллын тогтвортой байдалд чухал үүрэгт гүйцэтгэнэ.

Сонгуулийн санхүүжилтэд парламент ямар нэгэн хэмжээнд хяналт тавьдаг нь нийтлэг зүйл, харин иргэний нийгмийн байгууллагууд тэр бүр хяналт тавьдаггүй.

Үйл ажиллагааны бие даасан байдлыг хангах, олон нийтийн итгэлийг авахад цаг үеэ олсон, зохистой санхүүжилт (боломжтой бол олон жилээр төлөвлөх) шаардлагатай байдаг. Хангалттай бус санхүүжилт нь үр нөлөөг бууруулах төдийгүй төрийн албан хаагчдыг хөлслөн ажиллуулах зэрэгт сөргөөр нөлөөлөх талтай.

Сонгууль нь улс орны эдийн засгийн хөгжилд (ажилгүйдлийг бууруулах, дотоодын нийгмийн зардлыг

өсгөх г.м) түлхэц өгч чадна.

ЗӨВЛӨМЖ БОЛГОХ НЬ:

- Сонгуулийн удирдлагын төв байгууллагууд нь сонгуулийн түгээмэл нийтлэг зарчим, сонгуулийн сайн удирдлагын зарчимд үнэнч хэвээр үргэлжлүүлэн ажиллах,
- Ил тод байдлыг үргэлжлүүлэн дэмжих замаар олон нийтийн зүгээс хяналт тавих боломжийг өргөтгөж өгөх,
- Сонгуулийн удирдлагын төв байгууллагууд нь олон нийтийн итгэл үнэмшлийг алдахгүйгээр сонгуулийн зардлын өсөлтийг аль болох бага байлгах эсхүл бууруулах зорилгоор үр бүтээлтэй ажиллах арга замыг байнга эрэлхийж ажиллах,
- Парламент эсхүл Засгийн газрууд нь ямар ч тохиолдолд сонгуулийн үйл ажиллагааг хангалттай хэмжээгээр, цаг тухайд нь санхүүжүүлж байх шаардлагатай.
- Сонгуулийн үйл ажиллагаа нь үр дүнд төвлөрөх бөгөөд шударга сонгууль улс төр, эдийн засаг, нийгмийн тогтвортой байдлыг улс гүрнүүдэд авч ирэх учиртай.

2. СОНГУУЛИЙН САНХҮҮЖИЛТИЙН ТАЛААР:

ГОЛ ДҮГНЭЛТ: Ил тод байдлыг хангах, олон нийтийн итгэл үнэмшлийг хүлээхийн тулд сонгуулийн удирдлагын төв байгууллагууд болон сонгуулийн үйл ажиллагаа нь хангалттай хэмжээний санхүүжилттэй байх шаардлагатай.

Цаг үеийн зардалд худал хуурамч мэдээлэл, цахим гэмт хэргийн эсрэг тэмцэхтэй холбогдсон зардал багтах учиртай,

Сонгуулийн удирдлагын төв байгууллагууд нь сонгуулийн дараа үүссэн маргааныг шийдвэрлэхэд шаардлагатай хангалттай санхүүжилттэй байх ёстой.

Сонгуулийн зардлыг бие даан зарцуулах эрх хэмжээ нь сонгуулийн удирдлагын төв байгууллагуудын хувьд тэднээс сонгуулийг шударга явуулахад нь дэмжлэг болно.

Сонгуулийн зардлыг хоцроож цаг тухайд нь олгохгүй байх нь сонгуулийг шударга явуулахад саад тогтор болно.

Зохих хэмжээний санхүүжилтээр хангагдсан байх талаар сонгуулийн удирдлагын төв байгууллагуудын эрх хэмжээг үндсэн хууль, бусад хууль тогтоомжид тодорхой тусгаж өгөх шаардлагатай.

Сонгуулийн удирдлагын төв байгууллагуудад олон улсын техникийн тусламж үзүүлэх, сайн туршлага солилцуулах замаар сонгуулийн удирдлагын зарчмын дагуу сонгуулийг шударга явуулахад нь дэмжлэг үзүүлж болно.

ЗӨВЛӨМЖ БОЛГОХ НЬ:

- Сонгуулийн удирдлагын төв байгууллагууд олон нийтийн итгэл үнэмшил ямар байгааг мэдэхийн тулд судалгаа, мэдээлэлд түшиглэж байх,
- Төрийн бусад байгууллагуудын ердийн хяналтад байдаг ч гэсэн сонгуулийн удирдлагын төв байгууллагууд нь сонгуулийн зардлыг хэрхэн зарцуулах талаар илүү бие даасан эрх эдлэхийг хүсч байдаг.
- Өөрийн ажилтан нарын зүгээс эрх, үүргээ хэрэгжүүлэх, сонгогчдод цахим мэдээллийн боловсролыг олгоход дэмжлэг үзүүлэх зэрэг сонгуулийн үеийн мэдээллийн

орчныг хамгаалах зорилгоор сонгуулийн удирдлагын төв байгууллагууд зохих хэмжээний санхүүжилтээр, цаг тухай бүр хангагдсан байх учиртай.

- Гүйцэтгэх засаг гэхгүйгээр сонгуулийн зардлыг батлуулах хүсэлт тавих, тайлагнах асуудлаар парламентад шууд ханддаг байх,
- Санхүүжилтийн доод босгыг тодорхойлж баталгаажуулсан заалт хуульд тусгасан байх.

3. СОНГУУЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ҮЗҮҮЛЭХ ТЕХНОЛОГИЙН НӨЛӨӨНИЙ ТАЛААР:

ГОЛ ДҮГНЭЛТ: Технологи нь Сонгогчдын бүртгэл, Сонгогчдыг танин мэдэх, Дүнг дамжуулах, Үйл ажиллагааны явцад хяналт тавих, баталгаажуулах процессыг түргэтгэн сайжруулна.

Сонгуулийн ил тод байдлын амжилт нь мэдээллийг хэрхэн нийгмийн сүлжээгээр түгээж буй, нээлттэй мэдээллийг хэрхэн хуваалцаж буй, сонгуулийн онцлог гол үйл явдлыг хэрхэн шууд дамжуулж буйгаар илэрч байдаг.

Технологи худалдагчийн сонголт нь сонгуулийг шударга явуулахад сөргөөр нөлөөлөх талтай.

Технологи худалдагч нь өртгийг хэмнэх бус харин өртгийг илтээр нэмэгдүүлэх хандлагатай байдаг. Сонгуулийн удирдлагын төв байгууллагууд нь технологийг зохион бүтээхээс эхлүүлээд боловсронгуй болгох, хэрэглэхэд оролцох нь чухал бөгөөд ингэснээр зардлыг хэмнэж болно.

Технологийн шинэчлэлд эрсдлийн удирдлага чухал. Технологийн шинэчлэл нь шинэ үйл ажиллагаа, хуулийн шинэ зохицуулалт шаардахаас гадна сонгуулийн удирдлагын төв байгууллагуудын хувьд аюулгүй байдлын эрсдэлтэй учирна.

ЗӨВЛӨМЖ БОЛГОХ НЬ:

- Үр ашигтай технологи нь сонгуулийн зардлыг бууруулж болно. Гэхдээ технологи худалдагчид итгэл үзүүлэхэд хүрэх, түүнээс хамааралтай болох талтайгаас гадна урт хугацаанд өртөг зардал нэмэгдэхэд хүргэж магадгүй.
- Сонгуулийн удирдлагын төв байгууллагууд нь өөрийн дотоодын мэдээллийн технологийг түшиглэн мэдээлэл технологийн өөрийн мэргэжилтэн нарыг чадваржуулах, тэд тогтвортой, тууштай байдлыг хадгалахын тулд төлөвлөлт, технологийн хөгжилтөд тэргүүлэн оролцох ёстой.
- Технологийг зөвхөн батлагдсан хуулийн хүрээнд нэвтрүүлэх ёстой.
- Технологийг нутагшуулахын өмнө түүнийг улс төрийн бүх нам, сонгуульд оролцогч нийгмийн сонирхогч бүлгүүд ойлгосон, хүлээн зөвшөөрсөн, түүнд итгэл үнэмшилтэй болсон байх учиртай.
- Технологи нэвтрүүлэхийн өмнө техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулах, технологийг туршиж үзэх, туршилтын журмаар практикт ашиглах, дараа нь үр дүнг нь хөндлөнгийн судлаачдаар хянуулж дүгнүүлэх зэрэг шатлалтайгаар хэрэгжүүлнэ.
- Сонгуулийн удирдлагын төв байгууллага болон технологи худалдагчийн хоорондын үйлчилгээний гэрээ хэлцэлд бүхий зохицуулалт түүний дотор нийлүүлэх цаг

хугацааны зааг, чанарын баталгаа, санхүүгийн нөхцөл, сургалт, программ хангамж болон торгуулийн талаар тусгаж өгсөн байх ёстой.

4.ЛОЖИСТИК, ХҮН ХҮЧНИЙ ӨРТӨГ ЗАРДЛЫН ҮР НӨЛӨӨ (ӨРТӨГ ӨНДӨР ЗҮЙЛС)-ИЙН ТАЛААР:

ГОЛ ДҮГНЭЛТ: Ерөнхийдөө сургалт өндөр өртөгтэй байдаг, гэхдээ технологийн шинэчлэл хийж дараах замаар өртгийг хямдруулж болно. Үүнд:

- Танхимын сургалтын оронд технологи ашиглах (хиймэл оюун ухаан, зайны сургалт г.м) замаар зардал, цаг хэмнэх,
- Сонгуулийн туршлагатай түр ажилтан нарын боловсруулсан чанартай судалгаа мэдээлэл нь олон давтамжтай сургалтыг цөөлж зардал хэмнэж болно.

Сонгуулийн түр ажилтан нар нь ажил эрхэлдэггүй учир тэр бүр үр бүтээлтэй байж чаддаггүй.

Сонгуулийн удирдлагын олон тооны төв байгууллагууд Цахим санал хураалтыг нэвтрүүлэхээр идэвхтэй судалж байна, зарим нь зардал хэмнэх зорилгоор гадаад улс оронд суугаа иргэдийнхээ саналыг цахимаар авч байна.

Сонгуулийн зарим материалыг худалдан авахад цаг хугацаа ихээхэн шаарддаг тул хүндрэл учруулдаг, зарим материалд нь аюулгүйн шаардлага тавигддаг, мөн тээврийн өртөг зардал өндөртэй байдаг.

Сонгуулийн зарим анкет, саналын хуудсыг цөөлөх зэргээр мөрдөж буй дүрэм журмыг хянан үзэж, зардлыг багасгах боломжтой юм.

ЗӨВЛӨМЖ БОЛГОХ НЬ:

- Хуулийн хувьд боломжтой гэж үзвэл саналын хуудсыг цөөлөх чингэхдээ олон шатны сонгуулийн саналын хуудсыг нэгтгэн саналын нэг хуудсаар санал авах,
- Дүрэм журмыг шинэчлэх замаар санал авах байранд ажиллах ажилтан нарын тоог бууруулах боломж бий.
- Гадаад улс оронд амьдарч буй иргэдийн саналыг авах зардлыг бууруулах үүднээс зохих технологи ашиглах асуудлыг судлах.
- Худалдан авалтын төлөвлөлтийг оновчтой хийж, төсөв зардлыг цаг тухайд нь батлуулж, зарцуулах нь чухал болно.

5. СОНГУУЛИЙН КАМПАНИТ АЖЛЫН ӨСӨН НЭМЭГДЭЖ БҮЙ ӨРТГИЙН ТАЛААР:

ГОЛ ДҮГНЭЛТ: Сонгуулийн кампанит ажлын зардлыг өсгөж буй хүчин зүйлүүд:

- Цахимжилт ба мэдээллийн тэлэлт: Уламжлалт аргаас цахим арга /нийгмийн сүлжээ, цахим сурталчилгаа/-д шилжиж байгаа ч өртөг нь нэмэгдсээр байна.
- Сонгуулийн тойргийн тоог нэмэгдүүлэх: Хүн ам ихтэй газар нутагт сонгуулийн тойрог олноор байгуулах, ойлголцох олон хэл ашиглах шаардлага тулгарч байна.
- Улс төрийн өрсөлдөөн: Олон намын систем нь нам тус бүрийн лого, тэмдэг ашиглах зэргээр нэмэлт ложистик хүчин зүйл, илүү чармайлтыг шаардаж байна.

- Аюулгүй байдал ба гомдол санал: Хамгаалалт, зохицуулалтын арга хэмжээний зардал ялангуяа зөрчил сөргөлдөөний дараагаар нэмэгддэг.
- Сул хяналт: Хяналт сул байгаагаас төсөв хэтрүүлэн хэрэглэсэн ч хянан шалгахгүй өнгөрч байна, сонгуулийн өөр өөр системд хяналт янз бүр байгаа нь ажиглагдаж байна.
- Санал худалдан авах: Африк, Ази, Номхон далайн бүсийн олон оронд саналыг бэлэн мөнгө эсхүл бараагаар худалдан авах явдал түгээмэл байдаг.

Улсын хөрөнгийг буруугаар ашиглах- Хууль тогтоомжийн тодорхой бус байдал, хяналт сул байгаагаас улбаалан өрсөлдөөний тэгш боломжийг алдагдуулдаг.

Кампанит ажлыг цаг тухайд нь санхүүжүүлж, хэвлэл мэдээллийн зүгээс сурталчилгаа явуулах нь сонгуулийн улс төрийн ерөнхий орчныг ойлгон мэдэхэд чухал болно.

Санхүүжилтийн эх үүсвэр далд нууц байх, улс төрийн учир шалтгаантай зардал өндөр байх нь хүн бүрт хүрэх хүртээмжтэй байдалд сөргөөр нөлөөлдөг.

Өртөг зардалд хатуу хязгаар тавихдаа болгоомжтой хандах ёстой, тэгээд ч түүнд хяналт тавих явдал хүндрэлтэй, энэ нь кампанит ажлын үйл ажиллагааг илүү харгис сөрөг тал руу түлхэх аюултай.

Төрийн зүгээс улс төрийн намууд, нэр дэвшигчдийн кампанит ажлыг санхүүжүүлэх нь баян чинээлэг донорууд, бизнесийн эрх ашгаас хамаарах тэдний хамаарлыг бууруулах талтай.

Сонгуулийн удирдлагын төв байгууллагуудад сонгуулийн кампанит ажлын санхүүжилтэд хяналт тавих эрхийг олгож байгаа нь улс төрчидтэй харилцах харилцаанд нь сөрөг нөлөөтэй. Гэвч нөгөө талаар сонгуулийн удирдлагын төв байгууллагууд нь сонгуулийг шударгаар зохион байгуулах үүрэг хүлээж байгаа билээ.

ЗӨВЛӨМЖ БОЛГОХ НЬ:

- Хөрөнгө зардал, хандивын хязгаар нь бодитой, ил тод байхаас гадна тэгш хуваарьлагдсан байх ёстой.
- Ил тод, стандартын шаардлага хангасан хууль эрх зүйн орчин бий болгох нь өрсөлдөөний тэгш боломжийг хангах, өртөг хэмнэсэн үр дүнтэй кампанит ажлыг явуулах нөхцлийг бүрдүүлнэ.
- Кампанит ажлын санхүүжилтийн талаарх мэдээллийг олон нийтэд нээлттэй байлгах нь тэдний зүгээс хяналт тавих, хариуцлага тооцох боломжийг олгодог.
- Иргэний нийгмийн байгууллагууд болон хяналтын бусад агентлагууд /төрийн аудит, санхүүгийн хяналтын байгууллага г.м/-ын хоорондын хамтын ажиллагаа нь сонгуулийн кампанит ажлын санхүүжилтэд тавих хяналт, олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэхэд дэмжлэг болно.
- Кампанит ажлын санхүүжилттэй холбоотой журам дүрмийг чангатгах, хяналтыг сайжруулах, улс төрийн шийдвэрлэгдээгүй асуудлыг гэтлэн давахад уялдуулан зохицуулсан хамтын хүчин чармайлт шаардлагатай.

Орчуулсан: Ч.Баттөмөр

АРДЧИЛЛЫН ТӨЛӨВ БАЙДАЛ 2025

Сонгуулийн ерөнхий хорооны референт **Б.УЯНГА**


Ардчилал сонгуульд дэмжлэг үзүүлэх олон улсын хүрээлэнгээс гаргасан Ардчиллын төлөв 2025 тайлангаас тоймлон хүргэж байна.

Дэлхийн улс орнуудад ардчиллын үзүүлэлт ямар түвшинд байгааг Freedom House, International IDEA, V-Dem зэрэг байгууллагуудаас үнэлж тодорхойлдог. Тэдний нэг болох Ардчилал сонгуульд дэмжлэг үзүүлэх олон улсын хүрээлэнгийн энэ удаагийн 9 дэх тайлан нь ардчиллын үзүүлэлтийг дөрвөн үндсэн үзүүлэлтээр гаргахаас гадна хүн амын шилжилт хөдөлгөөн, сонгуулийн оролцооны хамаарлыг харуулсан. Мөн дэлхий даяар ардчиллын үзүүлэлт тодорхой хэмжээгээр буурч байгаа үед хамгийн олон сонгууль зохион байгуулагдсан супер сонгуулийн жил 2024 оны ардчиллын үнэлгээг танилцуулж байгаагаараа онцлогтой.

Уг тайлан 2019 оноос 2024 оны 12 дугаар сар хүртэлх өгөгдлийн мэдээллийг агуулсан ба энэ хугацаанд ардчиллын үзүүлэлт Африк тивд хамгийн их буюу 33 хувь, Европ тив 25 хувь, Ази тивийн орнууд 16-20 хувиар буурчээ. Харин 2024 он супер сонгуулийн жил дэлхийн нийт улс орнуудын тал хувь (54 хувь) буюу 94 улсад ардчиллын үзүүлэлт 5 жилийн өмнөх үеэсээ буурсан боловч эсрэгээрээ 32 хувь буюу 55 улсад ардчиллын үзүүлэлт дээшилсэн байна.

Доорх графикт 1980-2020 оны хооронд дэлхийн улс орнуудад ардчиллын үзүүлэлтийн хувийн буурсныг улаан өнгөөр, сайжирсныг цэнхэр өнгөөр харуулсан.


График 1. Ардчиллын үзүүлэлт 1980-2020 онд хувиар



АРДЧИЛЛЫН ТӨЛӨВИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ТУХАЙ

Тайлангийн эхний хэсэгт Ардчиллын үзүүлэлтийг үнэлэхдээ **төлөөлөл, хүний эрх, хууль дээдлэх ёс, оролцоо** гэсэн үндсэн дөрвөн категориор үнэлж, категор тус бүр хэд хэдэн хүчин зүйлээс бүрджээ.

График 2. Дэлхийн ардчиллын төлөвийн үзүүлэлтийн бүдүүвч



ТӨЛӨӨЛӨЛ


Төлөөллийн үзүүлэлтийн хувьд дэлхийн 47 оронд хамгийн өндөр үзүүлэлт нь болж байсан ч 2024 онд **төлөөллийн** үзүүлэлт нь 2001 оноос хойш хамгийн бага түвшиндээ хүрсэн байна. **Хууль дээдлэх ёсны** үзүүлэлт нь 2024 онд хамгийн доод үнэлгээтэй хэвээрээ буюу 71 улс (41 хувь)-д буусан үр дүнтэй үзүүлжээ. Харин Оролцоо харьцангуй тогтвортой байсан хэдий ч 2019-2024 онд 11 улсад их өөрчлөлт харуулжээ.

Ардчиллын төлөвийн бүдүүвч зурагт тодорхойлсон категориор дэд үзүүлэлт буюу индекс тус бүрээр үнэлгээ нь сайжирсан болон буурсан улсын тоог гаргажээ. Үүнээс, Ази Номхон далайн бүсийн орнуудыг харвал (График 3) :

- Шударга сонгуулийн үзүүлэлт 7 оронд суларч, 2 оронд сайжирсан,
- Улс төрийн намуудын чөлөөтэй нээлттэй байдал 4 оронд суларч, 1 оронд сайжирсан,
- Сонгуульт засгийн газар 5 оронд суларч, 2 улсад сайжирсан,
- Парламентын бүтээмж 6 оронд суларч, 3 оронд сайжирсан,

- Шүүхийн нээлттэй байдал 9 оронд суларч, 4 оронд сайжирсан,
- Иргэдийн эрх чөлөө 6 оронд суларч 1 оронд сайжирсан,
- Улс төрийн тэгш байдал 2 оронд суларсан,
- Авлигаас ангид байх 3 оронд суларч 3 оронд сайжирсан,
- Хууль эрх зүйн тогтвортой байдал 4 оронд суларч 2 улсад сайжирсан,
- Шүүхийн бие даасан байдал 6 оронд суларч 2 оронд сайжирсан,
- Иргэний нийгэм – 3 оронд суларч 1 оронд сайжирсан бол
- Иргэдийн оролцоо 1 оронд суларсан гэж дүгнэжээ.

График 3. Ардчиллын дэд үзүүлэлтээр Ази Номхон далайн бүс нутагт суларсан, сайжирсан орнуудын тоог 2024 оныг 2019 онтой харьцуулалт



■ буурсан үзүүлэлттэй орнууд ■ сайжирсан үзүүлэлттэй орнууд

Харин ардчиллын амин сүнс гэгдэх төлөөлөл нь шударга сонгууль, сонгуулийн оролцоонд суурилсан сонгох сонгогдох эрх, улс төрийн намаар эвлэлдэн нэгдэх, хууль тогтоох байгууллагын бүтээмж болон тухайн нутаг дахь ардчиллын хэрэгжилт зэрэг үнэлгээгээр дүгнэгдсэн. 2024 оны үзүүлэлтээр Герман, Дани, Норвеги улс тэргүүлсэн бол Мавритус улс хамгийн өндөр амжилтыг гаргаж 23 шатаар ахижээ.

Хүснэгт 1. 2024 онд төлөөллийн үзүүлэлтээр хамгийн өндөр 10 улс

2024 он	Улсын нэр	2023 онд	2023-с 2024 оны өөрчлөлт
1	Germany	1	0
2	Denmark	3	+1
3	Norway	2	-1
4	Costa Rica	4	0
5	Chile	5	0

6	Sweden	6	0
7	Finland	10	+3
8	Italy	13	+5
9	Netherlands	9	+1
10	Estonia	12	+2

Шударга сонгуулийн индекс нь иргэдийн төлөөлөл болох улс төрийн албан тушаалын төлөөх сонгууль аливаа тэгш бус байдлаас ангид, сонгогчийн бүртгэл, сонгуулийн сурталчилгааны үйл ажиллагаа худал ташаа зүйл, ялгаварлан гадуурхалтгүй, сонгогчийг айлган сүрдүүлэх, сонгуулийн тооллого залилан мэхлэлтээс гадуур байгаа эсэх үзүүлэлтийн нэгдэл юм.

Ихэнх улс орнууд ардчиллын үзүүлэлтээр ухарч байгаа ч шударга сонгууль, бүтээмжтэй парламентын үзүүлэлт 2024 оны байдлаар 24 улсад сайжирч, 35 улсад буурсан. Тухайлбал, Гүрж, Өмнөд Солонгос болон ардчилал сул хөгжсөн Мозамбек, Пакистан зэрэг улсыг энд дурдаж болно. Гүрж Улсын хувьд сонгуулийн үеэр сонгогчийг сүрдүүлсэн, саналын луйвар, санал худалдах гэх мэт тохиолдол гарсан тухай ажиглагчид ажиглалтын тайландаа дурдсан. Тиймээс тус улсын Ерөнхийлөгч асан, сөрөг хүчний төлөөллүүд, иргэний нийгмийн байгууллагууд сонгуулийн дүнг эсэргүүцэж тус улсад жилийн турш бүх нийтийн бослого өрнүүлээд байсан.

Бүтээмжтэй парламентын индекс нь сөрөг хүчний оролцоо, парламентын хяналт шалгалт, албан тушаалтнаас асуулга авах, гүйцэтгэх засаглалд тавих хяналт, эрх мэдлийн хязгаарлалтыг хэмжих үзүүлэлт зэргийг нэгтгэн тооцдог.

Уг үзүүлэлтээр 2024 онд 5 улсын нэг нь сул буюу нийт 32 улсад буурсан байсан бол 9 улсад сайжирсан байна. Сул үзүүлэлттэй орнуудад ардчилал өндөр хөгжсөн Япон улс хүртэл багтжээ. Харин ардчилал дунд болон сул хөгжсөн орнуудаас засгийн эрхийг цэргийн эсвэл ардчиллын бус аргаар шилжүүлэн авсан, зарим нь одоог хүртэл дотоодын зөрчилтэй байгаа орнууд тухайлбал Афганистан, Буркино Фасо, Габон, Гвиней, Гаити, Мали, Нигер, Мьянмар, Сир зэрэг улс, бусад Эл Салвадор, Кувейт, Орос, Венесуэл зэрэг орнууд үр өгөөжтэй парламентын үзүүлэлтээр доогуур үнэлгээтэй байгаа нь гүйцэтгэх засаглалаас томилсон эсвэл буулгасантай холбоотой байж болох юм. Харин дунд түвшний ардчиллын хувьд Киргизстан, Лэбанон, Мавритус, Парагуай, Словак зэрэг улсад парламентын үр өгөөж гэх үнэлгээ сул дүнтэй байна.

ОРОЛЦОО

Оролцоог Засгийн газрын бүх түвшин дэх иргэдийн оролцоо, иргэний нийгэм үйл ажиллагаагаа чөлөөтэй явуулах орон зай, иргэдийн улс төрийн болон бусад улс төрийн бус холбоонд нэгдэж буй байдал, сонгогчийн ирц гэсэн гурван индексийн үзүүлэлт байна. Улс орнууд оролцооны хувьд тогтвортой үзүүлэлттэй байгаа ч зөвхөн


11 улсад мэдэгдэхүйц сайжирсан бол ардчилал сул хөгжсөн Афганистан, Төв Африкийн Бүгд Найрамдах улс, Кувейт, Мьянмар, Никарагуа, Орос улсад улам суларсан байна. Харин Бразил, Фижи улсад иргэдийн оролцоо маш их сайжирсан байна.

Хүснэгт 2. 2024 оны оролцооны үзүүлэлтээр хамгийн өндөр үзүүлэлт бүхий 10 улс

2024 он	Улсын нэр	2023 онд	2023-с 2024 оны өөрчлөлт
1	 Denmark	1	0
2	 Germany	3	+1
3	 Switzerland	2	-1
4	 Uruguay	4	0
5	 Norway	5	0
6	 Brazil	6	0
7	 United States	10	+3
8	 Taiwan	13	+5
9	 France	9	+1
10	 Sweden	12	+2

Бүс нутгаар 2019 оны ардчиллын үзүүлэлтийг 2024 оныхтой харьцуулахад Ази Номхон далайн орнуудад шүүхийн нээлттэй байдал (13 улс), шударга сонгууль (9 улс), бүтээмжтэй парламент (9 улс) зэрэг үзүүлэлтээр томоохон өөрчлөлт гарсныг доорх графикт үзүүлж, улаан өнгөөр үзүүлэлт суларсан, цэнхэр өнгөөр сайжирсныг тэмдэглэсэн.

График 4. Ази Номхон далайн орнуудын 2019 оны үзүүлэлтийг 2024 онтой харьцуулсан байдал



Ардчиллын үзүүлэлт ухралттай хэвээрээ боловч Ази Номхон далайн бүс нутгийн ихэнх улсад ардчиллын чанар хэвийн төвшнөөс өссөн байгааг график 5-д үзүүлсэн. Тухайлбал, уг өөрчлөлт гарсан орнуудын нэг Шри Ланк Улсын ерөнхийлөгч болон парламентын 2024 оны сонгууль харьцангуй тайван явагдаж, сонгуулиар тус улсын хувьсгалч асан Анура Кумара Диссанаякэ гайхмаар ялалт байгуулсан зэрэг үйл явдлуудтай холбоотой. Шри Ланк Улсын хувьд, ардчиллын үзүүлэлт цаашид үргэлжлэн сайжрах эсэх нь Диссанаяакегийн засгийн газраас авилгын эсрэг болон тогтвортой байдлын чиглэлээр ажиллах амлалт өгөхөөс хамаарах юм. Мэдээж зарим орны онцлогоос шалтгаалан Лаос, Таджикистан, Туркменистан, Вьетнам зэрэг Азийн хэд хэдэн авторитар дэглэм бүхий улсад явагдсан сонгуулийн оролцооны тухай мэдээллээс хамааран сонгуулийн оролцооны үзүүлэлт өндөр гарсныг дурджээ.

АРДЧИЛАЛ – ХҮН АМЫН ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨН

Сүүлийн 30 жилд Ази номхон далайн бүс нутагт төдийгүй дэлхий даяар хүн амын шилжилт хөдөлгөөн эрчимтэй явагдаж 2025 оны байдлаар дэлхийн нийт хүн амын 3.7% буюу 304 сая иргэн төрсөн улсаасаа өөр улсад ажиллаж, амьдарч байна. Уг үйл явцыг харгалзан Азийн улс орнуудын дэлхийн бусад улс орнуудтай харилцах харилцаа ихээхэн өөрчлөгдөж байна. Үүнтэй зэрэгцэн ардчиллын чиглэлээр ажилладаг байгууллагууд дээрх өөрчлөлттэй дасан зохицох, шилжин суурьшсан иргэдийн сонгуульд оролцох боломжоор хангах, санал хураалтын үйл ажиллагаанд суугаа улс орноосоо оролцох эрхийг хангахад анхаарах болж байна.

Тайланд дурдсанаар, ихэнх улсад гадаад дахь санал хураалтын ирц харьцангуй доогуур байгаа төдийгүй сонгуульд оролцох эрх бүхий сонгогчийн тухай мэдээлэл нийтэд тодорхой бус зарим тохиолдолд бүрэн бус, хязгаарлагдмал байна. Мөн гадаад дахь сонгогчдын саналыг авах тодорхой тогтсон загвар байхгүй ч хууль эрх зүйн болоод сонгуулийн удирдлагын байгууллагаас гаргах загварчлалаас сонгогчийн оролцоо шууд хамааралтай байдаг тул сонгогчийн эрхийг илүү өргөн хүрээнд хэрэгжүүлэхэд тухайн улсын сонгогчийн бүртгэл, ирцийг дээшлүүлэхэд чиглэсэн нягт нарийн боловсруулсан бодлого чухал болохыг онцолжээ.

ЭХ СУРВАЛЖ: Ардчилал сонгуульд дэмжлэг үзүүлэх олон улсын хүрээлэнгийн цахим хуудас. Ардчиллын төлөв 2025 тайлан. <https://www.idea.int/publications/catalogue/html/global-state-democracy-2025-democracy-move>

ҮНДЭСНИЙ НОМЫН САНД “СОНГУУЛИЙН БОЛОВСРОЛ, ЭРХ ЗҮЙН УНШЛАГЫН ТАНХИМ” АЖИЛЛАЖ БАЙНА



Сонгуулийн ерөнхий хороо, Үндэсний номын сан, Хууль зүйн үндэсний хүрээлэн хамтран Үндэсний номын сангийн 308 тоот танхимд Ардчилсан Үндсэн хуулийн эхийг баригч, Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Ардын багш, Гавьяат хуульч, доктор, профессор Б.Чимидийн нэрэмжит “Сонгуулийн боловсрол, эрх зүйн уншлагын танхим”-ыг 2025 оны 10 дугаар сарын 15-ны өдөр нээлээ. Уг танхимд Сонгуулийн ерөнхий хорооноос эрхлэн гаргасан ном, товхимол, эмхэтгэлээс гадна Улсын Их Хурлын Тамгын газрын дэргэдэх Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэнгийн Парламентын номын сан, “Чимид сан” ТББ, Монгол Улсын Их Сургууль, Дотоод Хэргийн Их Сургууль, “Тунгаахуй” өгөгдлийн урлан сонгуулийн эрх зүйн ном, товхимол, дата мэдээлэл, судалгааны бүтээлүүдийнхээ дээжийг байршуулсан юм. “Сонгуулийн боловсрол, эрх зүйн уншлагын танхим”-д сонгууль, сонгуулийн эрх зүйн ном, товхимол, бүтээл уншихаас гадна уулзалт, хэлэлцүүлэг, сургалт, мэдээлэл, практик хичээл зохион байгуулахад нээлттэй.



Сонгуулийн эрх зүй, сонгуулийн процессын эрх зүйн салбарын эрдэм шинжилгээ, судалгааны бүтээлийг нэмэгдүүлэх, мэргэшсэн судлаач бэлтгэх, түүнд шаардлагатай орчин, нөхцөлийг бүрдүүлэх, энэ чиглэлээрх эрдэм шинжилгээ, судалгааны бүтээлийг судалгаа, шинжилгээний эргэлтэд оруулах, судлаачдыг идэвхжүүлэх, сонгуулийн хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгийг нийтэд тайлбарлан таниулах, сонгогчдод сонгуулийн болон эрх зүйн боловсрол олгох зорилгоор тус танхимыг ажиллуулж байгаа юм.



ТА ЭНДЭЭС

- ✓ Сонгуулийн хууль, тогтоомжийн эмхэтгэл
- ✓ “Сонгуулийн боловсрол” онол, арга зүйн сэтгүүл
- ✓ Сонгуулийн эрх зүйн судалгаа, эрдэм шинжилгээний бүтээлийн эмхэтгэл
- ✓ Сонгуулийн бүх төрлийн дата мэдээлэл, өгөгдөл, түүнийг дүрслэл
- ✓ Улс төрийн намын тухай хууль, тогтоомж, дүрэм, журмын эмхэтгэл
- ✓ Улс төрийн намын санхүүжилтийн мэдээллийг ном товхимол, тоон мэдээллийг авах боломжтой.



“СОНГУУЛИЙН БОЛОВСРОЛ, ЭРХ ЗҮЙН УНШЛАГЫН ТАНХИМ”-Д

- ✓ Цаг үеийн мэдээ, мэдээлэл солилцох арга хэмжээ
- ✓ Сонгуулийн эрх зүй, сонгуулийн процессын чиглэлээр мэргэшсэн судлаачид болон чиглэлээрх судалгаа, эрдэм шинжилгээний ажил хийж буй хуульч, судлаач, оюутнуудын уулзалт, хэлэлцүүлэг
- ✓ Сонгуулийн байгууллагын үйл ажиллагаатай танилцах практик дадлага, уулзалт
- ✓ Эрдэм шинжилгээний бүтээлийн уралдаан, хурал, хэлэлцүүлэг
- ✓ Сонгуулийн боловсрол олгох сургалт, мэдээлэл зэрэг үйл ажиллагаа зохион байгуулахад нээлттэй.



СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ ДАРГА П.ДЭЛГЭРНАРАН: Үндэсний номын сандаа түшиглээд аймгуудын номын сан, бусад номын сангуудаар сонгуулийн боловсролыг дээшлүүлэх, мэдээ мэдээллийг түгээн дэлгэрүүлэх, сонгуулийн эрх зүйг хөгжүүлэхээр Үндэсний номын сан, Хууль зүйн үндэсний хүрээлэн, их дээд сургууль, “Чимид сан”, “Сонгогчдын боловсрол төв” зэрэг олон байгууллагатай хамтран ажиллаж байна. “Сонгуулийн боловсрол, эрх зүйн уншлагын танхим”-ыг нээснээр ардчилсан сонгууль явуулах эрх зүйн баримт бичиг, статистик мэдээлэл, ном товхимол, судалгааны бүтээлийг нэг доороос авах, эргэлтэд оруулах ач холбогдолтой.



ҮНДЭСНИЙ НОМЫН САНГИЙН ЗАХИРАЛ Б.ИЧИНХОРЛОО: Сонгогчдын мэдлэг, боловсролыг дээшлүүлэх, төрд төлөөлөгчөө сонгох эрх болон үүрэг хариуцлагад нь дэмжлэг үзүүлэх үүднээс сонгуультай холбоотой бүхий л мэдээллийг авч болдог, өөрсдийгөө хөгжүүлдэг танхимтай болгоё гэж төрийн болон төрийн бус байгууллагууд нэгдээд уншлагын танхимаа нээлээ. Сонгогчдод эрхийг нь ойлгуулах, мэдээ мэдээлэл олгох ном, товхимлоор энэ танхим үйлчилнэ. Мөн Үндэсний номын сангийн сүлжээгээрээ дамжуулаад төрийн болон орон нутгийн номын сангуудад сонгогчдын боловсролд зориулсан гарын авлага, ном товхимлоор сонгогчдод дэм болно.



ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН ЗАХИРАЛ Б.ӨЛЗИЙСАЙХАН: Бид оюутан байхдаа Б.Чимид багшийн “Сонгуульд суралцахуй”-аас өөр бүтээл олдоггүй байсан. Өнөөдөр энэ танхимд судалгааны олон бүтээл, Сонгуулийн ерөнхий хорооноос гаргасан маш олон статистик мэдээлэлтэй танилцах боломжтой боллоо. Суралцагч, сонгогч, судлаачдыг энэ танхимд суух, мэдээлэл авах цаашлаад сонгуулийн боловсрол, эрх зүйг хөгжүүлэхэд ач холбогдолтой, өргөн цар хүрээтэй ажил болсонд судлаачийн хувьд баяртай байна. Сонгуулийн боловсролыг дээшлүүлэх, сонгуулийн эрх зүйн судалгаатай болох, энэ чиглэлээр сургалт зохион байгуулах, өргөжүүлэхэд Хууль зүйн үндэсний хүрээлэн хамтран ажиллах болно.



ОТГОНТЭНГЭР ИХ СУРГУУЛИЙН 2 ДУГААР КУРСИЙН ОЮУТАН Б.ТӨМӨРЧӨДӨР: Улсын Их Хурал, Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд намайг төлөөлөх хүнийг сонгодог гэдэг байдлаар сонгуулийн талаар тодорхой зүйлийг л мэддэг байснаас зохион байгуулах нарийн явцыг төдийлөн мэддэггүй байсан. Үндэсний номын санд ангиараа хичээллэхдээ санал тоолох төхөөрөмжид саналын хуудас уншуулж, ажиллагааг нь нарийн туршиж үзлээ. Иргэдийн дунд “Хар машин алдаатай тоолдог” гэх зарим хардлага яриа ор үндэсгүйг өөрөө туршаад мэдэж авлаа. Маш нарийн ажиллагаатай, хяналт тавих бүрэн боломжтой юм байна. Аль болох олон хүн өөрөө туршаад, мэдээлэл аваад эргэлзээгээ арилгавал сонгогчдын ирц ч нэмэгдэнэ гэж бодож байна.



ОТГОНТЭНГЭР ИХ СУРГУУЛИЙН ОЮУТАН А.САМСАРМАА: Бидний үеийнхэн олонх мэдээллээ сошиалаар авдаг нь үнэн. Гэхдээ сошиал мэдээлэл бол нүдний өмнө гүйгээд л өнгөрдөг болохоос оюун санаанд үлдэх нь ховор. Харин үеийнхнээрээ цуглаад хэлэлцүүлэг, ярилцлага өрнүүлэхээр мэдээлэл тод үлддэг юм байна гэдгийг Үндэсний номын санд ангиараа цуглаад сонгуулийн талаар албаны хүмүүсээс мэдээлэл авч, өөрсдөө туршилтын санал өгөхдөө мэдэж авлаа. Эндээс авсан мэдээлэл мартагдахгүй. Тийм учраас сонгуулийн боловсролыг залууст уулзалт, хэлэлцүүлэг хэлбэрээр өгвөл илүү ач холбогдолтой юм байна.

Залуус номын санд суух дуртай. Үндэсний номын санд сонгуулийн мэдээллээр төрөлжсөн танхим нээгдсэнд маш их баяртай байна. Би эрх зүйн ангийн хувьд байнга үйлчлүүлнэ” гэв.



ГАДААД ОРНУУДЫН ҮНДСЭН ХУУЛИАС...



Бүгд Найрамдах Итали Улс

87 дугаар зүйл.

Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч бол Төрийн Тэргүүн бөгөөд үндэсний эв нэгдлийг төлөөлнө.

84 дүгээр зүйл.

Иргэний болон улс төрийн эрх эдэлж байгаа, 50 насанд хүрсэн иргэн бүр Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгчөөр сонгогдох эрхтэй.

Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгчийн албан тушаалыг бусад албан тушаалтай хавсран гүйцэтгэхгүй.

91 дүгээр зүйл.

Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч бүрэн эрхээ хүлээн авахаас өмнө Бүгд Найрамдах Улсад чин үнэнчээр зүтгэхээ тангараглах бөгөөд Парламентын хамтарсан хуралдааны өмнө Үндсэн хуулийг чандлан сахихаа батлан тангараглана.

90 дүгээр зүйл.

Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч нь бүрэн эрхэд хамаарах чиг үүргийг хэрэгжүүлэхдээ Үндсэн хууль зөрчсөнөөс бусад тохиолдолд хариуцлага хүлээхгүй.

Хэрэв Ерөнхийлөгч Үндсэн хууль зөрчсөн гэж үзвэл Парламентын хамтарсан хуралдаанаар, гишүүдийн дийлэнхи олонхийн саналаар Ерөнхийлөгчийг гэм буруутай гэж үзнэ.

86 дугаар зүйл

Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч албан үүргээ гүйцэтгэх боломжгүй тохиолдолд Сенатын тэргүүн Ерөнхийлөгчийн үүргийг гүйцэтгэнэ.

Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч албан үүргээ гүйцэтгэх чадваргүй болсон, нас барсан, огцорсон тохиолдолд Төлөөлөгчийн Танхимын Тэргүүн нь Парламентын татан буугдах үе болон Парламентын бүрэн эрхийн хугацаа дуусахаас 3 сарын доторх хугацааг үл харгалзан 15 хоногт багтаан Бүгд Найрамдах Улсын шинэ Ерөнхийлөгчийн сонгуулийг зарлана.



МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ

Гучдугаар зүйл.

1. Монгол Улсын Ерөнхийлөгч бол төрийн тэргүүн, Монголын ард түмний эв нэгдлийг илэрхийлэгч мөн.

2. Ерөнхийлөгчөөр тавин нас хүрсэн, сүүлийн таваас доошгүй жил эх орондоо байнга оршин суусан, Монгол Улсын уугуул иргэнийг зургаан жилийн хугацаагаар зөвхөн нэг удаа сонгоно.

Гучиннэгдүгээр зүйл.

8. Ерөнхийлөгч нь Ерөнхий сайд, Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүн, хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах бусад ажил, албан тушаал хавсарч болохгүй. Хэрэв Ерөнхийлөгч өөр ажил, албан тушаал эрхэлж байгаа бол тангараг өргөсөн өдрөөсөө эхлэн уул үүргээс чөлөөлөгдөнө.

Гучин хоёрдугаар зүйл.

2. Ерөнхийлөгч сонгогдсоноосоо хойш гуч хоногийн дотор "Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, ард түмнийхээ эрх чөлөө, үндэсний эв нэгдлийг эрхэмлэн хамгаалж, Үндсэн хуулийг дээдлэн сахиж, Ерөнхийлөгчийн үүргийг шударгаар биелүүлэхээ батлан тангараглая" хэмээн Улсын Их Хуралд тангараг өргөнө.

Гучин тавдугаар зүйл.

2. Ерөнхийлөгч тангаргаасаа няцаж Үндсэн хууль, Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг зөрчвөл Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг үндэслэн Улсын Их Хурлаар хэлэлцэж чуулганд оролцсон нийт гишүүний дийлэнх олонхийн саналаар огцруулна

Гучин долдугаар зүйл.

1. Ерөнхийлөгчийг түр эзгүйд бүрэн эрхийг нь Улсын Их Хурлын дарга хэрэгжүүлнэ.

2. Ерөнхийлөгч огцорсон, нас нөгчсөн, хүсэлтээрээ чөлөөлөгдсөн бол Ерөнхийлөгч шинээр сонгогдож тангараг өргөх хүртэл бүрэн эрхийг нь Улсын Их Хурлын дарга хэрэгжүүлнэ. Энэ тохиолдолд Улсын Их Хурал Ерөнхийлөгчийн сонгуулийг дөрвөн сарын дотор зарлан явуулна.



Герман Улс

54 дүгээр зүйл.

- (1) Холбооны улсын Ерөнхийлөгчийг Холбооны улсын чуулганаас хэлэлцүүлэггүйгээр сонгоно. Бундестагийн сонгуульд оролцох эрх бүхий, 40 нас хүрсэн Герман хүн бүр Холбооны улсын Ерөнхийлөгчөөр сонгогдох эрхтэй.
- (2) Холбооны улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа 5 жил байна. Түүнийг зөвхөн нэг удаа улируулан сонгож болно.

55 дугаар зүйл.

- (2) Холбооны улсын Ерөнхийлөгч өөр цалинтай ажил, албан тушаал хаших, аж ахуй эрхлэх болон мэргэжлийн ажил эрхлэх, ашгийн төлөө аливаа аж ахуйн нэгжийн удирдлагад болон хяналтын зөвлөлийн гишүүнээр ажиллахыг хориглоно.

56 дугаар зүйл.

Холбооны улсын Ерөнхийлөгч албан тушаалаа хэрэгжүүлж эхлэхдээ Бундестагийн болон Бундесратын гишүүдийн өмнө дараахь тангараг өргөнө: "Өөрийн хүч чадлаа Германы ард түмний сайн сайхны төлөө зориулж, түүний эрх ашгийн төлөө хүчин зүтгэж, хор хөнөөлөөс хамгаалж, Үндсэн хууль болон Холбооны улсын хуулийг дээдлэн сахиж, хамгаалж, оногдсон үүргээ чин шударгаар биелүүлж, хэний ч өмнө шударга ёсыг баримтлахаа тангараглая. Бурхан намайг ивээх болтугай".

Мөн тангаргийг шашны илэрхийлэлгүй өргөж болно.

61 дүгээр зүйл.

- (2) Холбооны улсын Ерөнхийлөгч Үндсэн хууль, эсхүл Холбооны улсын бусад хуулийг санаатайгаар зөрчсөн буруутай болохыг Үндсэн хуулийн шүүх тогтоовол түүнийг албан тушаалаа алдсан хэмээн зарлаж болно. Гомдол гаргасны дараа Үндсэн хуулийн шүүх түр захирамж гарган Холбооны улсын Ерөнхийлөгчийн албан тушаалыг түдгэлзүүлэхээр шийдвэрлэж болно.

57 дугаар зүйл.

Холбооны улсын Ерөнхийлөгч бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болсон эсхүл хугацаанаас өмнө чөлөөлөгдсөн бол Бундесратын Ерөнхийлөгч түүний бүрэн эрхийг орлон хэрэгжүүлнэ.



МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ

Гучдугаар зүйл.

2.Ерөнхийлөгчөөр тавин нас хүрсэн, сүүлийн таваас доошгүй жил эх орондоо байнга оршин суусан, Монгол Улсын уугуул иргэнийг зургаан жилийн хугацаагаар зөвхөн нэг удаа сонгоно.

Гучиннэгдүгээр зүйл.

8.Ерөнхийлөгч нь Ерөнхий сайд, Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүн, хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах бусад ажил, албан тушаал хавсарч болохгүй. Хэрэв Ерөнхийлөгч өөр ажил, албан тушаал эрхэлж байгаа бол тангараг өргөсөн өдрөөсөө эхлэн уул үүргээс чөлөөлөгдөнө.

Гучин хоёрдугаар зүйл.

2.Ерөнхийлөгч сонгогдсоноосоо хойш гуч хоногийн дотор "Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, ард түмнийхээ эрх чөлөө, үндэсний эв нэгдлийг эрхэмлэн хамгаалж, Үндсэн хуулийг дээдлэн сахиж, Ерөнхийлөгчийн үүргийг шударгаар биелүүлэхээ батлан тангараглая" хэмээн Улсын Их Хуралд тангараг өргөнө.

Гучин тавдугаар зүйл.

2.Ерөнхийлөгч тангаргаасаа няцаж Үндсэн хууль, Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг зөрчвөл Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг үндэслэн Улсын Их Хурлаар хэлэлцэж чуулганд оролцсон нийт гишүүний дийлэнх олонхийн саналаар огцруулна.

Гучин долдугаар зүйл.

1.Ерөнхийлөгчийг түр эзгүйд бүрэн эрхийг нь Улсын Их Хурлын дарга хэрэгжүүлнэ.



БНСУ

66 дугаар зүйл.

1.Ерөнхийлөгч бол төрийн тэргүүн бөгөөд гадаад улсад улсаа төлөөлнө.

67 дугаар зүйл.

4.Ерөнхийлөгчөөр сонгогдох боломжтой этгээд нь Үндэсний Ассемблейн гишүүнээр сонгогдох эрхтэй бөгөөд сонгуулийн өдрөөр тооцоход дөчин нас хүрсэн байна.

70 дугаар зүйл.

1.Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа таван жил байх бөгөөд дахин сонгогдохгүй.

83 дугаар зүйл.

1.Ерөнхийлөгч Ерөнхий сайд Төрийн зөвлөлийн гишүүн бусад гүйцэтгэх яамны сайд болон бусад хуулиар тогтоосон албан тушаалыг эрхэлж болохгүй.

69 дүгээр зүйл.

1.Ерөнхийлөгч сонгогдсоноосоо хойш дараах тангараг өргөнө. "Би Үндсэн



МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ

Гучдугаар зүйл.

1.Монгол Улсын Ерөнхийлөгч бол төрийн тэргүүн, Монголын ард түмний эв нэгдлийг илэрхийлэгч мөн.

2.Ерөнхийлөгчөөр тавин нас хүрсэн, сүүлийн таваас доошгүй жил эх орондоо байнга оршин суусан, Монгол Улсын уугуул иргэнийг зургаан жилийн хугацаагаар зөвхөн нэг удаа сонгоно.

Гучиннэгдүгээр зүйл.

8.Ерөнхийлөгч нь Ерөнхий сайд, Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүн, хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах бусад ажил, албан тушаал хавсарч болохгүй. Хэрэв Ерөнхийлөгч өөр ажил, албан тушаал эрхэлж байгаа бол тангараг өргөсөн өдрөөсөө эхлэн уул үүргээс чөлөөлөгдөнө.

хуулиа сахиж, эх орноо хамгаалан эх орноо энх тайвнаар нэгтгэж ард түмний эрх чөлөө, амьдралыг дээшлүүлэх болон үндэсний хөгжил дэвшлийн төлөө зүтгэж, Ерөнхийлөгчийн үүргээ үнэнчээр биелүүлэхээ ард түмнийхээ өмнө тангараглаж байна.”

74 дүгээр зүйл.

1.Ерөнхийлөгч Үндсэн хууль болон хууль тогтоомжид заасны дагуу Зэвсэгт хүчийг удирдана.

71 дүгээр зүйл.

1.Ерөнхийлөгчийн орон тоо сул байгаа эсхүл албан үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон тохиолдолд Ерөнхийлөгчийг төлөөлж хуульд зааснаар Ерөнхий сайд, Төрийн зөвлөлийн гишүүн орлоно.

Гучин хоёрдугаар зүйл.

2.Ерөнхийлөгч сонгогдсоноосоо хойш гуч хоногийн дотор “Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, ард түмнийхээ эрх чөлөө, үндэсний эв нэгдлийг эрхэмлэн хамгаалж, Үндсэн хуулийг дээдлэн сахиж, Ерөнхийлөгчийн үүргийг шударгаар биелүүлэхээ батлан тангараглая” хэмээн Улсын Их Хуралд тангараг өргөнө

Гучин гуравдугаар зүйл.

1.Ерөнхийлөгч Монгол Улсын зэвсэгт хүчний ерөнхий командлагч байна.

Гучин долдугаар зүйл.

1.Ерөнхийлөгчийг түр эзгүйд бүрэн эрхийг нь Улсын Их Хурлын дарга хэрэгжүүлнэ.



Оросын Холбооны Улс

80 дугаар зүйл.

1.Оросын Холбооны Улсын Ерөнхийлөгч бол төрийн тэргүүн мөн.
2.Оросын Холбооны Улсын Ерөнхийлөгч бол Оросын Холбооны Улсын Үндсэн хууль, хүний болон иргэний эрх, эрх чөлөөний баталгаа мөн.

81 дүгээр зүйл.

2.Оросын Холбооны Ерөнхийлөгчөөр 35 нас хүрсэн. Оросын Холбооны Улсад 25 жилээс багагүй хугацаагаар байнга оршин суусан, гадаад улсын иргэншилгүй, гадаад улсын иргэншил авч байгаагүй, эсвэл гадаад улсын нутаг дэвсгэрт байнга оршин суух зөвшөөрөлгүй Оросын Холбооны Улсын иргэнийг сонгоно.

3.Нэг хүн Оросын Холбооны Улсын Ерөнхийлөгчийн албан тушаалыг хоёр ба түүнээс дээш бүрэн эрхийн хугацаагаар хашиж болохгүй.

92 дугаар зүйл.

1.Оросын Холбооны Ерөнхийлөгчийн бүрэн эрх тангараг өргөсөн цагаас эхлэн хэрэгжих бөгөөд Оросын Холбооны Улсын шинээр сонгогдсон Ерөнхийлөгч тангараг өргөснөөр дуусгавар болно.

82 дугаар зүйл.

1.Оросын Холбооны Улсын Ерөнхийлөгч ажлаа хүлээн авмагц ард түмэндээ дараах тангараг өргөнө:

“Оросын Холбооны Улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг хэрэгжүүлэхдээ хүний болон иргэний эрх, эрх чөлөөг хүндэтгэн, хамгаалж, Оросын Холбооны Улсын Үндсэн хуулийг сахин хамгаалж, улсын тусгаар тогтнол, халдашгүй байдал, бүрэн бүтэн байдлыг хамгаалж, ард түмэндээ үнэнчээр үйлчлэхээ тангараглаж байна.

87 дугаар зүйл.

1.Оросын Холбооны Улсын Ерөнхийлөгч нь Оросын Холбооны Улсын Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч байна.

92 дугаар зүйл.

3.Оросын Холбооны Ерөнхийлөгч үүргээ биелүүлэх боломжгүй бүх тохиолдолд түүний үүргийг Оросын Холбооны Улсын Засгийн газрын Дарга түр гүйцэтгэнэ. Оросын Холбооны Улсын Ерөнхийлөгчийн үүргийг түр гүйцэтгэгч нь Төрийн Думыг тараах, ард нийтийн санал асуулга явуулах, түүнчлэн Оросын Холбооны Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай санал гаргах эрх эдлэхгүй.



МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ

Гучдугаар зүйл.

1.Монгол Улсын Ерөнхийлөгч бол төрийн тэргүүн, Монголын ард түмний эв нэгдлийг илэрхийлэгч мөн.

Гучдугаар зүйл.

2.Ерөнхийлөгчөөр тавин нас хүрсэн, сүүлийн таваас доошгүй жил эх орондоо байнга оршин суусан, Монгол Улсын уугуул иргэнийг зургаан жилийн хугацаагаар зөвхөн нэг удаа сонгоно.

Гучин хоёрдугаар зүйл.

1.Ерөнхийлөгчийн бүрэн эрх тангараг өргөснөөр эхэлж, шинэ сонгогдсон Ерөнхийлөгч тангараг өргөснөөр дуусгавар болно.

Гучин хоёрдугаар зүйл.

2.Ерөнхийлөгч сонгогдсоноосоо хойш гуч хоногийн дотор “Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, ард түмнийхээ эрх чөлөө, үндэсний эв нэгдлийг эрхэмлэн хамгаалж, Үндсэн хуулийг дээдлэн сахиж, Ерөнхийлөгчийн үүргийг шударгаар биелүүлэхээ батлан тангараглая” хэмээн Улсын Их Хуралд тангараг өргөнө

Гучин гуравдугаар зүйл.

1.Ерөнхийлөгч Монгол Улсын зэвсэгт хүчний ерөнхий командлагч байна.

Гучин долдугаар зүйл.

1.Ерөнхийлөгчийг түр эзгүйд бүрэн эрхийг нь Улсын Их Хурлын дарга хэрэгжүүлнэ.

Зохих байгуулагч:



Хангран зохих байгуулагч:



Ардчилсан Үндсэн хуулийн эхийг баригч Б.ЧИМИДИЙН НЭРЭМЖИТ

Эрдэм шинжилгээний ШИЛДЭГ ИЛТГЭЛИЙН УРАЛДААН

Сэдэв

“МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ: АРДЧИЛСАН СОНГУУЛЬ”

ШАГНАЛЫН САН

ОЮУТНЫ АНГИЛАЛ

СУДЛААЧИЙН АНГИЛАЛ



Илтгэл хүлээн авах
2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн
17:00 цаг хүртэл цаасаар болон цахимаар ирүүлэх

Илтгэлийг хавтаслан эх хувиар нь Хууль зүйн
үндэсний хэрээтэнгийн байранд зарласан хугацаанд
багтаан өгнө.

ЦАХИМААР ХҮЛЭЭН АВАХ:
bayarmaa@legalinstitute.mn; chimidsan@gmail.com



Нэгдүгээр шат
2026 оны 01 дүгээр сарын 07-ны өдөр
илтгэлийг II шатанд оролцуулахаар шалгаруулна.



Хоёрдугаар шат
2026 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр шалгарсан
5 илтгэлийг хэлэлцүүлж, ишлэдэг илтгэлийг тодруулна.



1 Өргөмжлөл, ном
1,500,000₮



1 Өргөмжлөл, ном
1,000,000₮



1 Өргөмжлөл, ном
500,000₮



2 Өргөмжлөл, ном
100,000₮

1 Өргөмжлөл, ном
1,700,000₮

1 Өргөмжлөл, ном
1,200,000₮

1 Өргөмжлөл, ном
700,000₮

2 Өргөмжлөл, ном
200,000₮

Удирдамжтай
танилцах



“Б.ЧИМИДИЙН НЭРЭМЖИТ ШИЛДЭГ ИЛТГЭЛИЙН УРАЛДААН-2026” ЗАРЛАЛАА

Монгол Улсын Ардчилсан Үндсэн хуулийн эхийг баригч, Хөдөлмөрийн баатар, Ардын багш,
Гавьяат хуульч, доктор, профессор Бяраагийн Чимидийн нэрэмжит шилдэг илтгэлийн
17 дахь удаагийн уралдаан зарлалаа.



Илтгэлийн ерөнхий сэдэв: “Монгол Улсын
Ардчилсан Үндсэн хуулийн үзэл баримтлал:
Ардчилсан сонгууль”



Оролцох ангилал:
• Судлаачийн ангилал
• Оюутны ангилал



Илтгэл хүлээн авах хугацаа:
2025 оны 12-р сарын 30-ны 17:00 цаг хүртэл
(Цаасаар болон цахимаар илгээх)



Илгээх хаяг: Bayarmaa@legalinstitute.mn
Chimidsan@gmail.com



Холбоо барих: 89340007 – Хууль зүйн
үндэсний хүрээлэн



МОНГОЛ УЛСЫН СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРОО

Засгийн газрын 11 дүгээр байр
Ж.Самбуугийн гудамж,
Улаанбаатар – 15141, Монгол Улс

Санал хүсэлт хүлээн авах хаяг
gescm@m-election.mn
(976) -51 262127

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

